District	MNS5641.3	Khoroo	合計 / SO2 TPY	合計 / NOx TPY	合計 / TSP TPY	合計 / PM10 TPY	合計 / CO TPY
Bayangol	110767	9	2.259167233	0.743523393	1.572337947	0.943702768	3.342995564
	110769	10	7.480876684	2.462060631	5.208205286	3.124923172	11.0698036
	110771	11	4.262086332	1.402711957	2.967275294	1.780365176	6.306808761
	110781	16	6.223168999	2.048131569	4.332586012	2.599551807	9.208714633
Bayanzurkh	111053	2	14.4597162	4.758393941	10.08689103	6.040134617	21.3967193
	111057	4	3.634539878	1.196177881	2.530375884	1.518225519	5.378198882
	111059	5	4.418872945	1.454345526	3.076500152	1.845900091	6.538961231
	111065	8	10.14533434	3.338970794	7.063207449	4.237924469	15.01252638
	111067	9	9.007806388	2.964627419	6.271327232	3.762786339	13.32942097
	111069	10	6.027060733	1.983589808	4.19605494	2.517632964	8.918524046
	111071	11	2.274855895	0.74868875	1.583760433	0.95025626	3.366210811
	111073	12	18.14655162	5.972232812	12.63367518	7.580205107	26.85230233
	111075	13	3.1115845	1.024065785	2.166293006	1.299775804	4.604357317
	111077	14	10.63429761	3.499895417	7.403624921	4.442174953	15.73606824
	111081	16	3.203101691	1.054185367	2.230007506	1.338004504	4.739779591
	111083	17	6.654607186	2.190123884	4.63295437	2.779772622	9.847133925
	111087	19	6.066282386	1.996498	4.223361155	2.534016693	8.976562164
	111089	20	28.8409891	9.491971097	20.07916963	12.04750178	42.67736236
	111091	21	5.255701155	1.729724561	3.659032725	2.195419635	7.777107737

[EmissionByKhoroo] sheet-ийн шинэчилсэн дүнг [EmissionByKhoroo\_ForGrid] sheet-д байгаа тухайн хорооны холбогдох хэсэгт хуулж оруулна. (Хүснэгт 2.1-18)

**Хүснэгт 2.1-18 Бага оврын УХЗ-ны инвентор шинэчлэл**

	A	B	C	D	E	F	G	H	I	J	K	L
1	DIS_KHO	District_ID	MNS5641	District	Khoroo	TPY_SOx	TPY_NOx	TPY_TSP	TPY_PM10	TPY_CO		
2	2001	2	110751	Bayangol	1	0	0	0	0	0		
3	2002	2	110753	Bayangol	2	0	0	0	0	0		
4	2003	2	110755	Bayangol	3	0	0	0	0	0		
5	2004	2	110757	Bayangol	4	0	0	0	0	0		
6	2005	2	110759	Bayangol	5	0	0	0	0	0		
7	2006	2	110761	Bayangol	6	0	0	0	0	0		
8	2007	2	110763	Bayangol	7	0	0	0	0	0		
9	2008	2	110765	Bayangol	8	0	0	0	0	0		
10	2009	2	110767	Bayangol	9	2.259167233	0.743523393	1.572837947	0.943702768	3.342995564		
11	2010	2	110769	Bayangol	10	7.480876684	2.462060681	5.208205286	3.124923172	11.0698036		
12	2011	2	110771	Bayangol	11	4.262086332	1.402711957	2.967275294	1.780365176	6.306808761		
13	2012	2	110773	Bayangol	12	0	0	0	0	0		
14	2013	2	110775	Bayangol	13	0	0	0	0	0		
15	2014	2	110777	Bayangol	14	0	0	0	0	0		
16	2015	2	110779	Bayangol	15	0	0	0	0	0		
17	2016	2	110781	Bayangol	16	6.223168999	2.048131569	4.332586012	2.599551607	9.208714633		
18	2017	2	110783	Bayangol	17	0	0	0	0	0		
19	2018	2	110785	Bayangol	18	0	0	0	0	0		
20	2019	2	110787	Bayangol	19	0	0	0	0	0		
21	2020	2	110789	Bayangol	20	0	0	0	0	0		
22	3001	3	111051	Bayanzurkh	1	0	0	0	0	0		
23	3002	3	111053	Bayanzurkh	2	14.4597162	4.758893941	10.06689103	6.040134617	21.3967193		
24	3003	3	111055	Bayanzurkh	3	0	0	0	0	0		
25	3004	3	111057	Bayanzurkh	4	3.634539878	1.196177681	2.530375864	1.518225519	5.378198882		
26	3005	3	111059	Bayanzurkh	5	4.418972945	1.454345526	3.076500152	1.845900091	6.538961231		
27	3006	3	111061	Bayanzurkh	6	0	0	0	0	0		
28	3007	3	111063	Bayanzurkh	7	0	0	0	0	0		

Бага оврын УХЗ-ны улирал тус бүрийн цагийн хуваарь тус бүрээрх ажиллагааны хэлбэрийг Дэлхийн банкны "Mongolia Heating in Poor, Peri-urban Ger Areas of Ulaanbaatar" (2009) гарсан улирал тус бүрийн цагийн хуваарь тус бүрээрх түлш тэтгэж хийх тоо (Table 4.3) -ноос тооцоолж гаргасан. (Хүснэгт 2.1-19)

**Хүснэгт 2.1-19 Бага оврын УХЗ-ны ажиллагааны байдлын тооцооллын хүснэгт**

	A	B	C	D	E	F	G	H	I	J	K	L	M	N	O	P	Q	R
1		Ger & Wall	Stove & CFWH															
2													6.21002931					
3																		
4	時間					count for throwing coal to ger stove (by WB Report)		時間	Nov, Dec, Jan, Feb					WINTER	SPRING	SUMMER	AUTUMN	
5	1				0.090	0.090				0.180	0.180	0.875		0.875	0.225	0.000	0.450	
6	2				0.090	0.090				0.180	0.180	0.875		0.875	0.225	0.000	0.450	
7	3				0.090	0.090				0.180	0.180	0.875		0.875	0.225	0.000	0.450	
8	4				0.090	0.090				0.180	0.180	0.875		0.875	0.225	0.000	0.450	
9	5				0.090	0.090				0.180	0.180	0.875		0.875	0.225	0.000	0.450	
10	6	0.088			0.088	0.088		0.158		0.158	0.593		0.593	0.220	0.000	0.418		
11	7	0.088			0.088	0.088		0.158		0.158	0.593		0.593	0.220	0.000	0.418		
12	8	0.088			0.088	0.088		0.158		0.158	0.593		0.593	0.220	0.000	0.418		
13	9	0.088			0.088	0.088		0.158		0.158	0.593		0.593	0.220	0.000	0.418		
14	10	0.088			0.088	0.088		0.158		0.158	0.593		0.593	0.220	0.000	0.418		
15	11	0.088			0.088	0.088		0.158		0.158	0.593		0.593	0.220	0.000	0.418		
16	12	0.088			0.088	0.088		0.158		0.158	0.593		0.593	0.220	0.000	0.418		
17	13	0.088			0.088	0.088		0.158		0.158	0.593		0.593	0.220	0.000	0.418		
18	14	0.088			0.088	0.088		0.158		0.158	0.593		0.593	0.220	0.000	0.418		
19	15	0.088			0.088	0.088		0.158		0.158	0.593		0.593	0.220	0.000	0.418		
20	16	0.088			0.088	0.088		0.158		0.158	0.593		0.593	0.220	0.000	0.418		
21	17		0.118		0.118	0.118			0.267		0.267	1.000		1.000	0.296	0.000	0.629	
22	18		0.118		0.118	0.118			0.267		0.267	1.000		1.000	0.296	0.000	0.629	
23	19		0.118		0.118	0.118			0.267		0.267	1.000		1.000	0.296	0.000	0.629	
24	20		0.118		0.118	0.118			0.267		0.267	1.000		1.000	0.296	0.000	0.629	
25	21		0.118		0.118	0.118			0.267		0.267	1.000		1.000	0.296	0.000	0.629	
26	22		0.118		0.118	0.118			0.267		0.267	1.000		1.000	0.296	0.000	0.629	
27	23			0.090	0.090	0.090				0.180	0.180	0.875		0.875	0.225	0.000	0.450	
28	24			0.090	0.090	0.090				0.180	0.180	0.875		0.875	0.225	0.000	0.450	
29																		

**4) Гэрийн зуух**

Ашиглагдаж буй гэрийн зуухны тоог баримжаалан тооцооллох аргын хувьд 2010 онд Дэлхийн банкны шугамаар хийгдсэн гэрийн зуух болон ханын пийшингийн судалгааны дүнгээс олон тооны зуухтай айл өрхийг хамгийн бага хувилбар болон мэргэжилтний дүгнэлтийн хувилбарт 2%, хамгийн их хувилбарт 25% гэж үзсэн. 2010 он болон 2011 оны хувилбарт зарим хорооны хувьд хиймэл дагуулын зурагт гарсан гэрийн тоог тоолж, айл өрхийн тоо болон гэрийн тооны харьцааг баталгаажуулсан дүнгээс олон тооны зуухтай айлыг 20% гэж үзсэн.

Гэрийн зуух болон ханын пийшингийн ялгарлын инвенторыг тооцоолоход шаардлагатай үзүүлэлтийг Хүснэгт 2.1-20-д үзүүлэв.

Хороо тус бүрийн гэр мөн байшинд амьдрах хүн ам болон өрхийн тооны хамгийн шинэ өгөгдлөөр шинэчилсэн бөгөөд олон тооны зуухтай айл өрх байгааг харгалзан үзэж, гэрийн зуухны тоог тооцоолж гаргасан. 1 зууханд оногдох жилийн түлш зарцуулалтын хэмжээ, Я/К-ийг утааны хийн хэмжилтийн дүнгээр шинэчлэнэ.

Ялгарлын хэмжээ нь гэрийн зуухны тоо, 1 зууханд оногдох жилийн түлш зарцуулалтын хэмжээ, Я/К-оос автоматаар тооцоологдоно.

**Хүснэгт 2.1-20 Гэрийн зуухны ялгарлын инвенторт шаардлагатай үзүүлэлт**

District Name	MNS5641	Khoroo ID	Ger				Ger Stove	Fuel Consumption per one ger stove (ton/year)	Fuel Consumption_TPY	TSP
			family	corr_family	Population	Corr_Population				
Bayangol	110751	1	51	53.1165	183	190.5945	54.2	3.49	189.3	
	110753	2		0		0	0.0	3.49	0.0	
	110755	3	23	23.9545	75	78.1125	24.5	3.49	85.4	
	110757	4		0		0	0.0	3.49	0.0	
	110759	5		0		0	0.0	3.49	0.0	
	110761	6	22	22.913	80	83.32	23.4	3.49	81.6	
	110763	7	43	44.7845	190	197.885	45.7	3.49	159.6	
	110765	8		0		0	0.0	3.49	0.0	
	110767	9	1288	1341.452	5277	5495.9955	1369.6	3.49	4780.0	
	110769	10	1853	1929.8995	6460	6728.09	1970.4	3.49	6876.8	

District Name	MNS5641	Khoroo ID	Coal									
			Emission Factor (kg/ton)					Emission (ton_year)				
			TSP	PM10	SOx	NOx	CO	TSP	PM10	SOx	NOx	CO
Bayangol	110751	1	5.4	3.3	7.5	2.4	173.34	1.0	0.6	1.4	0.5	32.8
	110753	2	5.4	3.3	7.5	2.4	173.34	0.0	0.0	0.0	0.0	0.0
	110755	3	5.4	3.3	7.5	2.4	173.34	0.5	0.3	0.6	0.2	14.8
	110757	4	5.4	3.3	7.5	2.4	173.34	0.0	0.0	0.0	0.0	0.0
	110759	5	5.4	3.3	7.5	2.4	173.34	0.0	0.0	0.0	0.0	0.0
	110761	6	5.4	3.3	7.5	2.4	173.34	0.4	0.3	0.6	0.2	14.2
	110763	7	5.4	3.3	7.5	2.4	173.34	0.9	0.5	1.2	0.4	27.7
	110765	8	5.4	3.3	7.5	2.4	173.34	0.0	0.0	0.0	0.0	0.0
	110767	9	5.4	3.3	7.5	2.4	173.34	25.8	15.8	35.8	11.5	828.6
	110769	10	5.4	3.3	7.5	2.4	173.34	37.1	22.7	51.6	16.5	1192.0

Ялгарлын хэмжээг зуухны төрөл түлш тус бүрээр sheet гаргасан бөгөөд тэдгээрийн нийлбэрийг «TotalEmissionByKhoroo» sheet-д тооцоологдож байхаар шинэчилнэ (Хүснэгт 2.1-21).

Жишээлбэл, Traditional буюу уламжлалт гэрийн зуухнаас турк зуухны хэрэглээнд шилжсэн байдлыг тусгахдаа шинээр sheet нээж, турк зуухны инвенторыг боловсруулж гаргана.

**Хүснэгт 2.1-21 Хороо тус бүрийн ялгарлын инвенторын тооцоолол**

A	B	C	D	E	F	G	H	I	J	K
DIS_KHO	District_ID	MNS5641	DISTRICT_NAME	KHOROO_ID	TSP_TPY	PM10_TPY	SO2_TPY	NOx_TPY	CO_TPY	
2001	2	110751	Bayangol	1	1.7	1.3	1.4	0.7	45.1	
2002	2	110753	Bayangol	2	0.0	0.0	0.0	0.0	0.0	
2003	2	110755	Bayangol	3	0.8	0.6	0.7	0.3	22.4	
2004	2	110757	Bayangol	4	0.0	0.0	0.0	0.0	0.0	
2005	2	110759	Bayangol	5	0.0	0.0	0.0	0.0	0.0	
2006	2	110761	Bayangol	6	0.7	0.6	0.6	0.3	19.4	
2007	2	110763	Bayangol	7	2.9	2.2	2.8	1.2	90.4	
2008	2	110765	Bayangol	8	0.0	0.0	0.0	0.0	0.0	
2009	2	110767	Bayangol	9	82.4	63.7	80.5	34.8	2,596.8	
2010	2	110769	Bayangol	10	117.0	90.5	114.0	49.3	3,677.7	
2011	2	110771	Bayangol	11	89.6	69.3	88.0	37.9	2,842.0	
2012	2	110773	Bayangol	12	0.0	0.0	0.0	0.0	0.0	
2013	2	110775	Bayangol	13	0.0	0.0	0.0	0.0	0.0	
2014	2	110777	Bayangol	14	0.0	0.0	0.0	0.0	0.0	
2015	2	110779	Bayangol	15	0.1	0.1	0.1	0.0	1.8	
2016	2	110781	Bayangol	16	49.3	38.3	50.9	21.4	1,651.4	

Гэрийн зуухны улирал тус бүрийн цагийн хуваарть бүрийн ажиллагааны хэлбэрийн тооцооллын процессыг Хүснэгт 2.1-22-т үзүүлэв. Гэрийн зуухны ажиллагааны хэлбэрийг гэр хороолол болон орон сууцны хорооллоор улирал болон цагийн хуваарь тус бүрээр SO<sub>2</sub>-ийн агууламжийн зөрүүг гаргаснаар (хүснэгтийн L багана ~ O багана хүртэл), гэрээс үүдэлтэй агууламжийг тооцоолон гэрийн зуух болон ханын пийшингийн ажиллагааны хэлбэр болгож байгаа юм.

**Хүснэгт 2.1-22 Гэрийн зуухны ажиллагааны байдал**

Ger	Use SO2 concentration pattern at UB5 monitoring station	Use SO2 concentration at UB2 as not-ger area concentration	UB5-UB2 concentration (Minimum is 0)	Mar-May	Jun-Aug	Sep-Oct	Nov-Feb						
1	40.054348	8.833333	27.6875	112.65	26.439827	4.309852	18.428571	55.842105	13.550821	4.329474	9.258928	56.807895	
2	35.958696	8.011111	22.387097	111.555556	27.1875	3.486111	15.95122	56.878261	8.1711957	4.525	6.4358773	54.877295	
3	30.835165	7.0786517	18.25	99.779861	24.965854	2.830137	13.439024	53.219298	6.4693112	4.4485147	4.8109756	45.660383	
4	27.450674	6.4673913	15.21875	89	21.6375	2.495065	10.926829	48.965217	5.8231742	3.9788848	4.2919207	40.034793	
5	23.955556	5.9456522	11.84375	78.663886	19.555556	2.2857143	9.047619	42.965217	4.4	3.8599379	2.796131	35.698648	
6	21.606742	5.7582418	10.75	68.168067	18.5	2.1025641	8.195122	39.33913	3.1067416	3.6556777	2.554878	28.828937	
7	22.888889	7.4891304	11.193548	63.898931	18.682922	2.3333333	7.7560976	37.791304	4.2059621	5.1557971	3.4374508	25.598526	
8	32.333333	10.25	14.6875	66.588235	28.560976	4.2435897	10.902439	38.434788	8.7723577	6.0064103	3.785061	28.153453	
9	53.373626	14.293478	26.354839	87.208333	32.1125	8.0789474	16.707317	44.964602	21.261126	6.2145309	9.6475216	42.243732	
10	65.208791	14.836957	34.833333	129.25	35.5	13.025974	19.829268	50.321429	29.708791	1.8109825	15.004065	78.928571	
11	63.472527	14.76087	31.25	177.33933	40.641975	18.232684	27.297297	58.267857	22.839562	0	3.9527027	119.06548	
12	58.155556	17.644444	31.78125	167.49167	46.594937	21.272727	29.175	68.221239	11.560619	0	2.80625	99.270428	
13	52.868132	16.098901	32.484848	130.95798	42.407407	18.833333	28.255814	65.269565	10.460724	0	4.2290345	65.888418	
14	47.25	13.845055	30.40625	116.68067	35.597561	18.171053	30.317073	66.350877	11.652439	0	0.0891768	50.328795	
15	40.965909	12.912088	29.5625	103.91525	31.6875	18.589744	30.238095	60.147826	9.2784091	0	0	43.767428	
16	38	12.233333	23	94.125	29.292688	17.842105	24.325	53.403509	8.7073171	0	0	40.721491	
17	36.747253	11.880899	23.727273	85.956522	25.493976	16.065789	19.6	47.964602	11.253277	0	4.1272727	37.99192	
18	37.714286	12.224719	28.909091	82.016807	24.950617	14.933333	19.15	42.713043	12.763668	0	9.7590909	39.303763	
19	38.978022	11.988889	63.65625	101.91597	23.108434	13.907895	18.341463	44.2	15.889588	0	45.314787	57.715966	
20	50.155556	10.956044	80.25	116.27119	23.890795	11.909091	28.435897	56.044643	26.45676	0	51.814103	60.226544	
21	68.444444	11.318681	56.25	116.52101	27.891566	10.064103	34.97561	54.20354	40.552878	1.2545788	2.127439	62.317469	
22	64.895652	11.494505	45.606061	113.82203	35.180729	8.8625	30.952381	59.59292	29.514929	2.8320055	14.85368	54.229114	
23	52.5	10.912088	39.939394	112.93333	30.650602	6.7179487	26.27907	58.330435	21.849398	4.1941392	13.860324	54.602899	
24	47.793478	8.411111	33.69697	114.19167	29.650602	5.1216216	23.488872	57.424779	18.142876	4.2894895	10.208598	56.766888	
25	Total	1050.8166	265.94557	743.7262	2540.386	694.44402	245.30466	502.01458	1260.6562	356.37262	56.844423	243.71222	1279.7298

**2.1.4.2 Хөдөлгөөнт эх үүсвэр**

**(1) Ялгарлын хэмжээг тооцооллох арга**

Хөдөлгөөнт эх үүсвэрийн эх үүсвэр тус бүрийн үйл ажиллагааны эрчим, Я/К болон эх үүсвэрийн төрөл, хувиарлалтыг Хүснэгт 2.1-23-т үзүүлэв.

Автомашинууд хагалдаг утааг хөдөлгөөнт эх үүсвэрт хамруулсан болно.

Хөдөлгөөнт эх үүсвэрийн ялгарлын хэмжээг үндсэндээ бохирдуулах бодисын ялгарлын хэмжээ = үйл ажиллагааны эрчим × Я/К гэсэн томъёогоор тооцоолсон.

Гол автозамын үйл ажиллагааны эрчим нь хөдөлгөөний эрчим бөгөөд хөдөлгөөний эрчим нь хөдөлгөөний эрчим = линк тус бүрээр зорчих автомашины тоо × линкийн урт гэсэн томъёогоор тооцоолсон. Линк тус бүрээр зорчих автомашины тоог тус төслийн хүрээнд хэрэгжүүлсэн хөдөлгөөний эрчмийн судалгааны өгөгдөл болон УБ хотын замын хөдөлгөөний удирдлагын төвийн VDS мэдрэгчийн өгөгдлөөс баримжаалан тооцоолсон хөдөлгөөний эрчмийн өгөгдлийг ашигласан юм.

Гол автозамаас бусад замын үйл ажиллагааны эрчим нь бусад замд зарцуулагдах түлшний хэмжээ юм. УБ хотын Гаалийн газраас авсан түлшний нийт импортын хэмжээнээс УБ хотын хэмжээн дэх түлшний зарцуулалтыг баримжаалан тогтоож, түүнээс гол автозамд зарцуулагдах түлшний хэмжээг хасаж тооцоолсон болно.

Гол автозамын Я/К-ийг японы Я/К-нд үндэслэн УБ хотын нөхцөл байдалд нийцүүлэн засварласан коэффициентийг баримжаалан тогтоож үржүүлээд, мөн УБ хотын автомашины оношлогоонд тэнцсэн бүх автомашины өгөгдлөөс тооцоолсон автомашины төрөл тус бүрээрх хаягдал хийн ялгарлын хэм хэмжээ тус бүрийн зорчих зайны харьцаагаар жинлэсэн дундаж болгож тооцоолсон.

Гол автозамаас бусад замын Я/К нь түлшний зарцуулалтын хэмжээн дэх агаар бохирдуулах бодисын ялгарлын хэмжээ бөгөөд гол автозамын ялгарлын хэмжээний тооцооллын дүнгээс бодож гаргасан.

Гол автозамын хувьд зам тус бүрийг шугаман эх үүсвэр гэж авч үзэн эх үүсвэрийн инвенторыг боловсруулсан. Бусад замын ялгарлын хэмжээг УБ хотын хэмжээний нийт ялгарлын хэмжээг хороо тус бүрээр хөдөлгөөнт эх үүсвэрийг ашиглах хүн амын эзлэх хувиар хороонд хувиарлан, мөн хороо тус бүрийн ялгарлын хэмжээг хотын төвийн бүс нутгийн хүрээнд гридийн талбайн харьцаанд хувааж, талбайн эх үүсвэрээр бодож инвенторыг боловсруулсан.

Техникийн ур чадавхийн дэлгэрэнгүй агуулгыг салбарын тайлан (хөдөлгөөнт эх үүсвэрээс ялгарах агаар бохирдуулах бодисын ялгарлын инвентор)-д бичсэн болно. (Хавсралт материал 2.1-12)

**Хүснэгт 2.1-23 Эх үүсвэр тус бүрээрх ялгарлын хэмжээний тооцооллын арга, үйл ажиллагааны эрчим, Я/К болон эх үүсвэрийн төрөл, хувиарлалт**

	<b>Ялгарлын хэмжээний тооцооллын арга</b>	<b>Үйл ажиллагааны эрчим</b>	<b>Я/К</b>	<b>Эх үүсвэрийн төрөл, хувиарлалт</b>
Автомашины хаягдал утаа : Гол автозамын хэсэг	Ялгарлын хэмжээ = автомашины төрөл тус бүрээрх хөдөлгөөний эрчим × автомашины төрөл тус бүрээрх агаар бохирдуулах бодисын Я/К	Линк тус бүрийн хөдөлгөөний эрчмийн судалгааны өгөгдөл болон хотын замын хөдөлгөөний удирдлагын төвийн VDS мэдрэгчийн өгөгдлөөс тооцоолж хөдөлгөөний эрчмийн өгөгдөлд линкийн уртыг үржүүлэн бодож гаргасан.	Японы Я/К-нд үндэслэн УБ хотын нөхцөл байдалд нийцүүлэн засварласан коэффициентийг баримжаалан гаргаж үржүүлээд, 2009 онд УБ хотын оношлогоонд тэнцсэн бүх автомашины өгөгдлөөс тооцоолж гаргасан автомашины төрөл тус бүрийн хаягдал хийн ялгарлын хэм хэмжээ бүрийн	Эх үүсвэрийн төрөл : шугаман эх үүсвэр

			зорчих зайн харьцаагаар жинлэсэн дундаж болгож тооцоолсон.	
Автомашинны хаягдал утаа : Гол автозамаас бусад замын хэсэг	Ялгарлын хэмжээ = Бусад замын түлшний зарцуулалт × түлшний зарцуулалтын хэмжээн дэх агаар бохирдуулах бодисын ялгарлын хэмжээ	УБ хотын Гаалийн газарт бүртгэгдсэн түлшний импортын хэмжээнээс УБ хотын хэмжээний түлш зарцуулалтыг баримжаалан тооцоолж, гол автозамын түлшний зарцуулалтыг хассан хэмжээ	Гол автозамын түлшний зарцуулалт болон агаар бохирдуулах бодисын ялгарлын хэмжээнээс түлшний зарцуулалтын хэмжээн дэх бохирдуулах бодисын ялгарлын хэмжээг тооцоолсон.	Эх үүсвэрийн төрөл : талбайн эх үүсвэр Хөдөлгөөнт эх үүсвэрийг ашиглах хүн ам (хороо тус бүрийн оюутны тоо + хөдөлмөрчдийн тоотой адил гэж үзэх) болон грид тус бүрийн хотын төвийн талбайд хуваах

**(2) Инвенторын өгөгдлийг шинэчлэх арга**

**1) Автомашинны хаягдал утаа : Гол автозамаас үүдэлтэй ялгарлын хэмжээ**

Линкийн нэгжээр ялгарлын хэмжээг тооцоолно.

Автомашинны хаягдал хий (гол автозамын хэсэг)-н ялгарлын инвенторт шаардлагатай үзүүлэлтийг Зураг 2.1-7-д үзүүлэв.

Хөдөлгөөний эрчмийн өгөгдөлд 2010 оны хөдөлгөөний эрчмийн өгөгдлийг үндсэн өгөгдөл болгосон. Нарны гүүр шиг хөдөлгөөний эрчим нь ихээхэн өөрчлөгдсөн замын эргэн тойрны хөдөлгөөний эрчмийн судалгааны өгөгдлөөр сольж, бусад замын хувьд хотын замын хөдөлгөөний удирдлагын төвийн VDS мэдрэгчийн өгөгдлөөс тооцоолсон хөдөлгөөний эрчмийн нэмэгдэж хасагдсан хэмжээг үржүүлэн бодож гаргасан.

ЯК-ийг японы ЯК-ийг үндэслэн УБ хотын нөхцөл байдалд нийцүүлэн засварласан коэффициентийг баримжаалан гаргаж үржүүлээд УБ хотын 2009 оны оношлогоонд тэнцсэн бүх автомашинны өгөгдлөөс тооцоолсон автомашинны төрөл тус бүрийн хаягдал утааны ялгарлын хэм хэмжээ тус бүрийн зорчих зайн харьцаагаар жинлэсэн дундаж болгож тооцоолсон.

Автомашинны төрөл тус бүрийн хаягдал утааны хэм хэмжээ тус бүрээрх зорчих зайн харьцаа нь УБ хотын оношлогоонд тэнцсэн бүх автомашинны өгөгдлийг олж аван, тооцоолж гаргасан.

Quegu –г дарааллан ачаалж тооцооллол хийгдсэнээр (Зураг 2.1-8 нь тооцоололд ашигласан гол quegu жишээ), ялгарлын хэмжээг бодож гаргадаг (Зураг 2.1-9 нь тооцооллын дүнгийн жишээ).

Монгол Улс Улаанбаатар хотын агаарын бохирдлыг бууруулах хяналтын чадавхийг бэхжүүлэх төсөл


Төслийн эцсийн тайлан

The image displays three screenshots of Microsoft Access database tables. The first screenshot shows the 'in\_TrafficCount' table with columns for LocationID, Season, DayType, Direction, TimePeriod, and various traffic counts. The second screenshot shows the 'in\_TravelSpeedRaw' table with columns for Route, Lane, SpeedClass, TimeClass, Date, Season, Week, DayType, Distance, Direction, Start/End GPS coordinates, Start/End Time, and Travel Speed. The third screenshot shows the 'in\_VehicleInspection\_Private' table with columns for ID, Vehicle ID, Country, Brand/Model, Engine Type, Year, Total Mileage, Vehicle Type, Import Date, and Inspection Date.

Тайлбар: Дээрээс хөдөлгөөний эрчмийн өгөгдөл, зорчих хурдны өгөгдөл, автомашины оношлогооны өгөгдөл гэж дараалсан болно.


**Зураг 2.1-7 Автомашины хаягдал утаа (гол автозамын хэсэг) –ны ялгарлын инвенторт шаардлагатай үзүүлэлт**





Тайлбар: Зүүн талд query жагсаалтыг, баруун талд Я/К-ийг тооцооллох query болон ялгарлын хэмжээг тооцооллох query

**Зураг 2.1-8 Автомашны хаягдал утаа (гол автозамын хэсэг)-ны ялгарлын инвенторын тооцоололд ашиглах query жишээ**




**Зураг 2.1-9 Автомашны хаягдал утаа (гол автозамын хэсэг)-ны ялгарлын инвенторын тооцооллын дүнгийн жишээ**

## 2) Автозамын хаягдал утаа : Гол автозамаас бусад замын ялгарлын хэмжээ

Гол автозамаас бусад зам дах автомашины түлшний зарцуулалтын хэмжээг тооцоолж, агаар бохирдуулах бодисын ялгарлын хэмжээг тооцоолон гридэд хуваана.

Гол автозамаас бусад зам дах автомашины түлшний зарцуулалтын хэмжээг УБ хотын хэмжээний түлш зарцуулалтын хэмжээнээс гол замын түлш зарцуулалтыг хасаж тооцоолсон. УБ хотын автомашины түлш зарцуулалтын хэмжээний статистик мэдээлэл хийгдээгүй тул Гаалийн газраас авсан автомашины түлшний импортын хэмжээ (Зураг 2.1-10)-нээс баримжаагаар тооцоолж гаргасан УБ хотын хэмжээний зарцуулалтын хувийг үржүүлж тооцоолсон юм.

Query дарааллан ачаалж тооцоог хийвэл (Зураг 2.1-11 нь тооцоололд ашигласан гол query жишээ) ялгарлын хэмжээ тооцоологдож гарна (Зураг 2.1-12 нь тооцооллын дүнгийн жишээ).




The screenshot shows a Microsoft Access database window titled 'in\_FuelImportA6UB - Microsoft Access'. The 'Tables' pane on the left lists several tables, including 'in\_FuelImportA6UB'. The main window displays a table with the following data:

ID	Gasoline tpy	Diesel tpy	Gasoline r_UB
199658.92	283088.275		0.8


Тайлбар: УБ хотын Гаалийн газрын автомашины түлшний импортын хэмжээний өгөгдөл.

**Зураг 2.1-10 Гол автозамаас бусад замаас үүдэлтэй автомашины хаягдал утааны ялгарлын инвенторт шаардлагатай үзүүлэлт**



Тайлбар: Зүүн талд query жагсаалтыг, баруун талд нийт ялгарлын хэмжээг тооцоолох query болон ялгарлын хэмжээг гридэд хуваасан query-г үзүүлэв.

**Зураг 2.1-11 Гол автозамаас бусад замын автомашины хаягдал утааны ялгарлын инвенторын тооцоололд ашиглах query жишээ**



Тайлбар: Зүүн гар талд хүснэгтийн жагсаалт, баруун талд нийт ялгарлын хэмжээг гридээр илэрхийлсэн ялгарлын хэмжээ

**Зураг 2.1-12 Гол автозамаас бусад замын автомашины хаягдал утааны ялгарлын инвенторын тооцооллын дүнгийн жишээ**

### 2.1.4.3 Бусад эх үүсвэр

#### (1) Ялгарлын хэмжээний тооцооллын арга

Бусад эх үүсвэрийн эх үүсвэр тус бүрийн үйл ажиллагааны эрчим, Я/К болон эх үүсвэрийн төрөл, хувиарлалтыг Хүснэгт 2.1-24-д үзүүлэв.

ДЦС-ын үнсэн санг бусад эх үүсвэрт хамруулсан.

Бохирдуулах бодисын ялгарлын хэмжээг бохирдуулах бодисын ялгарлын хэмжээ = үйл ажиллагааны эрчим × Я/К гэсэн томъёогоор тооцоолсон. Үйл ажиллагааны эрчмийг ДЦС тус бүрээс авсан асуулга ярилцлага, үнсэн дээр хийгдсэн бодит судалгаа зэрэгт үндэслэн хийсэх магадлалтай талбай хэмжсэн. Я/К-ийг тус төслийн хүрээнд хийгдсэн үнсний хийсэлтийн хэмжээний судалгааны өгөгдлийг ашиглан тооцоолсон болно.

Эх үүсвэрийн төрлийн хувьд талбайн эх үүсвэр гэж үзээд эх үүсвэрийн инвенторыг боловсруулсан.

**Хүснэгт 2.1-24 Эх үүсвэр тус бүрийн ялгарлын хэмжээний тооцооллын арга, үйл ажиллагааны эрчим, Я/К болон эх үүсвэрийн төрөл, хувиарлалт**

	Ялгарлын хэмжээг тооцооллох арга	Үйл ажиллагааны эрчим	Я/К	Эх үүсвэрийн төрөл, хувиарлалт
ДЦС-ын үнсэн сан	Ялгарлын хэмжээ = Хийсэх магадлалтай талбай × Агаар бохирдуулах бодис тус бүрийн Я/К	ДЦС –ээс авсан ярилцлага, асуулга, бодит судалгааны дүн зэргээс тодорхой болсон үнс хийсэх магадлалтай талбай	Тус төслийн хүрээнд хийгдсэн үнс хийсэх хэмжээний судалгааны өгөгдлөөс тооцоолж гаргасан.  TSP-ээс PM <sub>10</sub> -ын шилжүүлэхдээ зуухнаас гарах үнсний ширхэглэлийн тархалт болон үнсэн санг хучсан гадаргын үнсний ширхэглэлийн хэмжээний тархалтаас тооцоолсон PM <sub>10</sub> -ын хувийг үржүүлэн бодож гаргасан.	Эх үүсвэрийн төрөл: талбайн эх үүсвэр

#### (2) Инвенторын өгөгдлийг шинэчлэх арга

##### 1) ДЦС-ын үнсэн сан

Үнсэн сан тус бүрээр ялгарлын хэмжээг тооцоолсон.

ДЦС-ын үнсэн сангаас хийсэх үнсний инвенторын тооцоололд шаардлагатай өгөгдөл, үзүүлэлт болон ялгарлын хэмжээг тооцооллох процессыг Хүснэгт 2.1-25-д үзүүлэв.

PM<sub>10</sub> Ratio sheet-д үнсэнд агуулагдах 10 микрон хүрэхгүй диаметртэй тоосонцорын хэмжээг оруулан тооцоолсон байгаа. Шаталтын арга зэргийг өөрчилсөн тохиолдолд зөвхөн үнсэнд агуулагдах 10 микроноос дооших диаметртэй тоосонцорын хувийг хэмжиж шинэчилсэн.

Emission sheet-д үнсэн сангийн талбай, хийсэх магадлалтай гадаргуун талбайн хэмжээ, элэгдлийн гүн, хуурайшилтын нягтшлийн өгөгдлийг оруулж, хэмжилт хийгдсэн хугацаан дах хийсэлтийн хэмжээг

тооцоолсон. Мөн дараагийн Pattern sheet-д тооцоолсон сар бүрийн хийсэлтийн хэмжээнээс жилийн хийсэлтийн хэмжээг тооцоолж гаргасан. Хийсэх магадлалтай гадаргын талбайн хэмжээ нь үнсэн сангийн хяналт (хөрсөөр хучих, усаар дүүргэж зэрэг) –ын байдлаас хамааран өөрчлөгдөж байдаг тул жил бүр өгөгдлийг шинэчлэх шаардлагатай юм. Элэгдлийн гүн болон хуурайшилтын нягтшлийг шинээр хэмжсэн тохиолдолд эдгээр утгыг бас шинэчлэх юм.

Pattern sheet-д сар тус бүрийн хийсэлтийн хувийг суурилуулж өгч, сар тутмын TSP-ын хийсэлтийн хэмжээ болон PM-10-ын хийсэлтийн хэмжээг тооцоолсон . Бүтэн жилийн туршид хөрсний элэгдлийн зузааныг хэмжих ажил амжилттай хийгдсэн зэрэг сар тутмын хийсэлтийн хувь хэмжээний талаар шинэ мэдээлэл олж авсан тохиолдолд тохирох утгыг шинэчлэх ёстой юм.

Дээрх өгөгдлөөс Pattern sheet-д сар тутмын ялгарлын хэмжээг, Emission sheet-д жилийн нийт ялгарлын хэмжээг тус тус тооцоолсон .

**Хүснэгт 2.1-25 ДЦС-ын үнсэн сангийн хийсэлтийн инвенторт шаардлагатай үзүүлэлт болон тооцооллын жишээ**

PP	Area	Nano Square (m <sup>2</sup> )	D fugitive area (%)	E Average erosion depth (cm)	G TSP emission (ton)	H TSP_TPY	I PM10_TPY		
2	PP2	West	50,882	100%	0.576	1.29	378	986.77	201.46
3		East	55,968	0%	0.576	1.29	0	0.00	0.00
4		Subtotal				378	986.77	201.46	
5	PP3	1	123,000	0%	0.576	1.29	0	0.00	0.00
6		2	141,000	0%	0.576	1.29	0	0.00	0.00
7		3	119,000	0%	0.576	1.29	0	0.00	0.00
8		4	102,600	100%	0.576	1.29	762	1,989.76	406.23
9		5	60,000	0%	0.576	1.29	0	0.00	0.00
10		Subtotal				762	1,989.76	406.23	
11	PP4	3	250,000	40%	0.576	1.29	743	1,939.33	395.93
12		4	160,000	25%	0.576	1.29	297	775.73	158.37
13		5	180,000	70%	0.576	1.29	936	2,443.56	498.88
14		Subtotal				1,976	5,158.63	1,053.19	
15	Total					3,117	8,135.16	1,660.87	

Month	Average wind	Inverse of wind	Pattern	Pattern for simulation	Maximum temperature	Minimum temperature	West	East	Subtotal	PP2	PP3	PP4	Total
1	1.3	0.769	1	0.046	-7.3	-32.2	3,780,736	0	3,780,736	0	0	0	3,780,736
2	1.9	0.526	1	0.046	-1	-30.1	3,780,736	0	3,780,736	0	0	0	3,780,736
3	2.8	0.357	10	0.460	9.9	-23.7	3,780,736	0	3,780,736	0	0	0	3,780,736
4	3	0.333	50	2.298	20.1	-14.3	189,098	0	189,098	0	0	0	189,098
5	3.7	0.270	100	4.598	27.9	-6.3	378,073.6	0	378,073.6	0	0	0	378,073.6
6	3.3	0.303	50	2.298	30.4	1.3	189,098	0	189,098	0	0	0	189,098
7	3.1	0.323	30	1.378	30.9	5.3	113,422.1	0	113,422.1	0	0	0	113,422.1
8	2.8	0.357	10	0.460	29.3	3.2	37,807.36	0	37,807.36	0	0	0	37,807.36
9	2.4	0.417	5	0.230	25	-5.1	18,909.8	0	18,909.8	0	0	0	18,909.8
10	2	0.500	2	0.092	19.4	-14.9	7,564.72	0	7,564.72	0	0	0	7,564.72
11	1.9	0.526	1	0.046	5.9	-25.1	3,780,736	0	3,780,736	0	0	0	3,780,736
12	1.9	0.526	1	0.046	-4.9	-31.5	3,780,736	0	3,780,736	0	0	0	3,780,736
17			261				986,772.1	0	986,772.1	0	0	0	986,772.1

**2.1.5 Эх үүсвэрийн инвентор боловсруулалтын дүн**

2010 он болон 2011 оны мэргэжилтний дүгнэлтийн эх үүсвэр тус бүрийн ялгарлын хэмжээг Хүснэгт 2.1-26-д үзүүлэв. Мөн 2010 оны бүх эх үүсвэрээс ялгарах PM10-ын ялгарлын хэмжээний тархалтыг Зураг 2.1-14-д үзүүлэв. TSP-ын ялгарлын хэмжээний хувьд ДЦС хамгийн их, дараа нь гэрийн зуух, замын тоос шороо гэсэн дараалалтай байна. PM10-ын ялгарлын хэмжээгээр ДЦС хамгийн их, дараа нь замын тоос шороо, гэрийн зуух гэсэн байдалтай байна. SOx болон NOx-ын ялгарлын хэмжээгээр ДЦС, гэрийн зуух гэж дараалж байгаа бөгөөд ДЦС болон гэрийн зуухны ялгарлын хэмжээ нь нийт ялгарлын хэмжээний 90% орчмыг эзэлж байна. CO ялгарлын хэмжээний хувьд гэрийн зуух нь нийт ялгарлын хэмжээний 60% орчмыг эзэлж байгаа нь автозамаас үүдэлтэй ялгарлын хэмжээнээс бараг 2.5 дахин их гарч байгааг тогтоосон. Үйл ажиллагааны эрчим, ялгарлын коэффициентийн суурилуулалт, 2010 оноос бусад үеийн ялгарлын хэмжээний дэлгэрэнгүйг Хавсралт материал 2.1-13-д үзүүлэв.

2010 он болон 2011 оны ялгарлын хэмжээний харьцуулсан дүнг Зураг 2.1-13-т үзүүлэв. TSP-ын ялгарлын хэмжээний хувьд ДЦС-ын  $PM_{10}$ -ын ялгарлын хэмжээ нь 2010 оноос 2011 он хүртэл өөрчлөгдөөгүй байгаа хэдий ч гэрийн зуухны ялгарлын хэмжээ нь бараг 600 тонн/жил-ээр багассан байна. УХЗ-ны хувьд 2011 он гэхэд бараг 260 тонн/жил-ээр багассан байна.

SOx болон NOx-ын ялгарлын хэмжээний хувьд 2010 оноос 2011 он хүртэл бүх эх үүсвэрийн хэмжээнд томоохон өөрчлөлт гараагүй.

CO-ын ялгарлын хэмжээгээр хэсэгчилсэн эх үүсвэрт жил бүрийн хувьд их өөрчлөлт гараагүй ч гэрийн зуухны хувьд 62,078 тонн/жил-ээс 59,070 тонн/жил болж багассан байна.


Мөн 2011 онд төрөөс татаас мөнгө олгосны дагуу 63,224 ширхэг борлуулагдсан бүтээмж сайтай сайжруулсан зуухны хувьд утааны хийн урсгал хурд багатай, агууламжийн өөрчлөлт ихтэй байгаа тул хэмжилт хийхэд бэрхшээлтэй, хэмжилтийн дээжийн тоо цөөн, утгын хэлбэлзэл ихтэй байгаа юм. Утааны хийн агаар бохирдуулах бодисын агууламжийн өгөгдлийг ашиглан ялгарлын хэмжээг тооцоолж байгаа бөгөөд оршин суугчдаас галлагааны аргачлалын талаар санал асуулга авах мөн тус аргачлалд тулгуурласан утааны хийн хэмжилт хийснээр хэмжилтийн дүнгийн нарийвчлалыг сайжруулах шаардлагатай юм.

**Хүснэгт 2.1-26 Эх үүсвэр тус бүрийн ялгарлын хэмжээ (мэргэжилтний дүгнэлтийн хувилбар)**


Нэгж : тонн/жил

	TSP		PM10		SOx		NOx		CO	
	2010 он	2011 он	2010 он	2011 он	2010он	2011 он	2010 он	2011 он	2010 он	2011 он
ДЦС	19,826	20,108	12,887	13,070	10,545	10,667	14,251	14,275	8,481	8,484
УХЗ	2,011	1,607	1,307	1,044	764	830	126	146	4,970	5,944
Бага оврын УХЗ	218	246	131	148	313	354	103	116	463	524
Гэрийн зуух	7,720	7,466	5,018	4,853	4,258	4,627	592	657	62,078	59,070
Автозам	195	212	195	212	204	257	4,186	3,303	24,293	16,462
Нарийн зам	31	33	31	33	32	40	654	516	3,795	2,572
Тоос шороо	6,812	6,644	6,812	6,644	-	-	-	-	-	-
Үнс хийсэлт	8,135	3,105	1,950	956	-	-	-	-	-	-
Нийт	44,948	39,420	28,331	26,959	16,116	16,775	19,912	19,013	104,080	93,056





Зураг 2.1-13 2010 он болон 2011 оны ялгарлын хэмжээний харьцуулалт



**Зураг 2.1-14 PM<sub>10</sub>-ын ялгарлын хэмжээний тархалт (2010 он)**


**2.1.6 Тархалтын загварчлалын модель боловсруулах арга****2.1.6.1 Тархалтын загварчлалыг тооцооллох нөхцөл, үндсэн бүтэц****(1) Тархалтын загварчлалыг тооцооллох нөхцөл**

Энэ удаа тооцоолж гаргасан тархалтын загварчлалын моделийг тооцооллын нөхцөлийг Хүснэгт 2.1-27, тархалтын загварчлалын үндсэн бүтцийг Зураг 2.1-15-д тус тус үзүүлэв. Тархалтын загварчлалын модельд оруулах өгөгдөл нь агаар орчны өгөгдөл, цаг уурын өгөгдөл, эх үүсвэрийн өгөгдөл юм. УБ хотын суурин харуулд мониторинг хийж байгаа  $PM_{10}$ ,  $SO_x$ ,  $NO_x$ ,  $CO$ ,  $WD$  (салхины чиг),  $WS$  (салхины хурд)-ийг модельд оруулан боловсруулалт хийсэн. Мөн адил эх үүсвэрийн инвенторыг модельд оруулан боловсруулсан. Эдгээр ажиллагааг цаг уурын өгөгдлийн хувиргалт болон эх үүсвэрийн хувиргалтаар гүйцэтгэсэн.

**Хүснэгт 2.1-27 Тархалтын загварчлалын үндсэн нөхцөл**

Үзүүлэлт	Агуулга	
Ашиглах загвар ISC-ST3 (US-EPA)+Puff Model	Хамрагдах бүс нутаг	Хотын захын, хотын төв нийслэл, үйлдвэрийн бүс нутаг
	Газрын хэлбэр	Тооцооллын грид тус бүрийн далайн дундаж түвшингөөс өндөр газрын хэлбэрийг харгалзан үзэх
	Хамруулах утааны эх үүсвэр	Өндөр утааны эх үүсвэр, гадаргын утааны эх үүсвэр
Хамруулах бодис	$PM_{10}$ , $SO_x$ ( $SO_2$ ), $CO$ , $NO_x$ ( $NO$ , $NO_2$ )	
Эх үүсвэр	Суурин эх үүсвэр, Хөдөлгөөнт эх үүсвэр, Бусад эх үүсвэр	
Хамруулсан хугацаа	2010 оны 11 сар~2011 оны 2 сар	
Цаг уурын өгөгдлийн дүн шинжилгээ	Цаг уурын өгөгдлийг дүн шинжилгээ хийж, модельд оруулах өгөгдөл болгон өөрчлөх.	
Агаарын орчны өгөгдлийн дүн шинжилгээ	Сар, жилийн дундаж тоон утга, цаг тутмын өөрчлөлт зэрэг үндсэн анализ, дүн шинжилгээг хийснээр УБ хотын АБ-ын нөхцөл байдлыг шинжлэх.	
Хамрагдах бүс нутаг, нарийвчлалын хэмжээ	өв хэсгийг хамруулсан 34км×28км, нарийвчлалын хэмжээ 1км×1км	

Өгөгдөл боловсруулалт



Зураг 2.1-15 Тархалтын загварчлалын моделийн үндсэн бүтэц

(2) **Моделийн үндсэн бүтэц**

Тархалтын загварчлалын модельд USEPA-аас гаргасан ISCST3 моделийг ашигласан. Гэвч ISCST3 модельд салхины хурд 1 м/с-ээс доош байгаа цаг уурын нөхцөлд агууламжийг тооцоолдоггүй тул тийм тохиолдолд Puff моделийг ашигласан.

ISCST3-д ашиглаж буй Plume томъёог үзүүлбэл,

$$\chi = \frac{QKVD}{2\pi u_s \sigma_y \sigma_z} \exp \left[ -0.5 \left( \frac{y}{\sigma_y} \right)^2 \right]$$

$\chi$  : Concentration ( $\mu\text{g}/\text{m}^3$ )

Q : Pollution emission rate (mass per unit time)

K : Scaling coefficient to convert calculated concentration to desired units  
(default value of  $1 \times 10^6$  for Q in g/s and concentration in  $\mu\text{g}/\text{m}^3$ )

V : Vertical term

D : Decay term

$\sigma_x, \sigma_y$  : Standard deviation of lateral and vertical concentration distribution (m)

$u_s$  : Mean wind speed (m/s) at release height

Puff моделийн томъёо нь дараах болно.

$$C(R, z) = \frac{1}{\sqrt{2\pi}} \cdot \frac{Q_p}{\frac{\pi}{8} \gamma} \cdot \left\{ \frac{1}{\eta_-^2} \cdot \exp\left(-\frac{u^2(z - He)^2}{2\gamma^2 \eta_-^2}\right) + \frac{1}{\eta_+^2} \cdot \exp\left(-\frac{u^2(z + He)^2}{2\gamma^2 \eta_+^2}\right) \right\}$$

$$\eta_-^2 = R^2 + \frac{\alpha^2}{\gamma^2} (z - He)^2$$

$$\eta_+^2 = R^2 + \frac{\alpha^2}{\gamma^2} (z + He)^2$$

$$R^2 = x^2 + y^2$$

- R : Horizontal distance from point source to calculation point  
 Q<sub>p</sub> : Emission (m<sup>3</sup>N/s)  
 U : Wind speed (m/s)  
 He : Effective plume height (m)

### (3) Яндангийн ашиглалтын өндөр (effective height)-ийн тооцоолол

Яндангийн ашиглалтын өндөр буюу effective height (he) гэдэг нь яндангаас ялгарах хий нь өөрт хадгалагдах дулаан болон яндангаас баагиж гарах хурднаас хамаарах хөдөлгөөний эрчмээр тодорхой өндөрт хүрч дээшилсэн тухайн өндрийг хэлдэг. Энэ өндөрт хүрсэний дараа салхиар агаарт тархаж эхэлдэг бөгөөд өөрөөр хэлбэл, хэвтээ чиглэлийн салхи нь ижил эрчтэй байх үед яндангийн ашиглалтын өндөр нь өндөр байх тусам тархалт өргөн хүрээнд явагдсанаар бохирдуулах бодис нь тэр хэмжээгээр жигд тархаж нимгэрдэг байна. Ингэснээр орчны агууламжийг багасгаж чаддаг. Хэвтээ чиглэлийн салхи жигд байгаа үед яндангийн ашиглалтын өндрийг өндөрсгөхийн тулд утааны хийн температур, хурд болон яндангийн өндрийг аль болох өндөр их, яндангийн диаметр нь бага байх шаардлагатай юм.

Агаарын тогтвортой байдал нь тогтворгүй эсвэл дундаж саармаг нөхцөл байдалтай байхад ISC-ST3 моделийн яндангийн ашиглалтын өндрийг дараах томъёогоор бодож олно.

$$h_e = h_s' + 21.425 \frac{F_b^{3/4}}{u_s} \quad F_b < 55$$

$$h_e = h_s' + 38.71 \frac{F_b^{3/5}}{u_s} \quad F_b \geq 55$$

Chip stack downwash буюу яндангаас гарах утааны хийн яндангийн нөлөөллөөр яндан орчмын салхины эргүүлэгт орж доошлох байдлыг бодолцож үзсэний үндсэн дээр яндангаас гарах өндөр (h<sub>s</sub>') болон Buoyancy flux parameter (дээшилж хөөрөх урсгалын параметр) (F<sub>b</sub>)-ийг дараах томъёогоор бодож гаргасан.

$$F_b = g v_s d_s^2 \left( \frac{\Delta T}{4T_s} \right)$$

$$h_s' = h_s + 2d_s \left( \frac{v_s}{u_s} - 1.5 \right) \quad v_s < 1.5$$

$$h_s' = h_s \quad v_s \geq 1.5$$

- u<sub>s</sub> : яндангаас гарах өндрийг засварласан хэвтээ чиглэлийн салхины хурд (м/с)  
 g : таталцлын хүчний хурд (Gravity force) (м/с<sup>2</sup>)


vs	: утааны хийн хурд (м/с)
ds	: яндангийн диаметр (м)
$\Delta T$	: утааны хийн температур ( $T_s$ ) болон агаарын температур ( $T_a$ )-ын зөрүү (К)
hs	: яндангийн бодит өндөр (м)

## 2.1.6.2 Цаг уурын өгөгдөл болон агаар орчны өгөгдлийн дүн шинжилгээ

### (1) Цаг уурын өгөгдөл

ЦУОШГ-аас авсан цаг уурын өгөгдлийг ашигласан. Салхины тархалтыг Шулуун зураас: Салхины чиглэл бүрийн давтамж, Тасархай зураас: Салхины чиглэл бүрийн дундаж хурд

Зураг 2.1-16-т үзүүлсэн бөгөөд салхины тархалт нь зүүнээс баруун зүгийн салхины давтамж өндөртэй байгаа нь УБ хотын газарзүйн онцлогийг харуулсан байна. Гэвч бүтэн жилийн цаг уурын өгөгдлийн хэмжигдсэн хугацаа нь 6000 цагаас илүү байгаа нь тархалтын загварчлалын моделийн нарийвчлалд багагүй нөлөө үзүүлж байна.




Шулуун зураас: Салхины чиглэл бүрийн давтамж, Тасархай зураас: Салхины чиглэл бүрийн дундаж хурд

**Зураг 2.1-16 Салхины тархалт (2010 он 3 сар ~2011 он 2 сар)**

**(2) Агаар орчны өгөгдөл**

Тархалтын загварчлалын нарийвчлалын хувьд агаар орчны агууламжийн хэмжилтийн утгатай тархалтын загварчлалаар тооцоолж гаргасан тооцооллын утгыг харьцуулан үнэлэх нь зүйтэй юм. Иймд агаар орчны агууламжийн хэмжилтийн утгыг цуглуулж, агаарын бохирдлын ерөнхий байдалд дүн шинжилгээ хийсэн болно.


Агаарын бохирдлыг тасралтгүй хэмжигч хэмжилтийн багаж төхөөрөмж суурилуусан газрыг Зураг 2.1-17-д үзүүлэв.




**Зураг 2.1-17** АБ-ын хэмжилтийн цэгүүд (зөвхөн тасралтгүй хэмжигч төхөөрөмж суурилуулсан цэгүүд)

Сар тус бүрийн агууламжийн өөрчлөлтийг Зураг 2.1-18~Зураг 2.1-22-д тус тус үзүүлэв. Зурагт улаан болон шаргал өнгөөр тэмдэглэсэн шулуун шугамаар тус бүрийн БО-ны стандартын утгыг харуулсан болно. Зургаас харахад  $PM_{10}$  болон  $SO_2$ -ын хувьд 12 сар~1 сарын хооронд агууламж өндөртэй,  $NO$ ,  $NO_2$  болон  $CO$  нь 9 сар~4 сарын хоорондох халаалтын улиралд агууламж өндөртэй байна. БОХЗГЛ-ын хэмжилтийн утгад үндэслэсэн дүн шинжилгээ (Хавсралт материал 2.1-5)-нд  $PM_{10}$ ,  $SO_2$ ,  $NO_2$ -ын үзүүлэлт нь бүх хэмжилтийн цэгт жилийн дундаж стандартын утгаас давсан байгаа юм. Харин  $CO$ -ын хувьд ихэвчлэн стандартаас хэтрээгүй байна.







Зураг 2.1-18 Сур тус бүрээрх агууламжийн өөрчлөлт (PM<sub>10</sub>)




Зураг 2.1-19 Сар тус бүрээрх агууламжийн өөрчлөлт (SO<sub>2</sub>)



Зураг 2.1-20 Сар тус бүрээрх агууламжийн өөрчлөлт (NO)



Зураг 2.1-21 Сар тус бүрээрх агууламжийн өөрчлөлт (NO<sub>2</sub>)



Зураг 2.1-22 Сар тус бүрээрх агууламжийн өөрчлөлт (CO)

### 2.1.6.3 Тархалтын загварчлалын модель гаргалт

#### (1) Эх үүсвэрийн ялгарлын өндөр (нийтлэг)

Эх үүсвэр тус бүрийн ялгарлын өндрийг Хүснэгт 2.1-28-д үзүүлэв. Утааны хийн агаарт тархах өндрийг яндангийн effective height -ийн баримжаалсан тооцооллын аргыг ашиглан тооцоолсон.

Хүснэгт 2.1-28 Эх үүсвэр тус бүрийн ялгарлын өндөр

Эх үүсвэр	Ялгарлын өндөр
ДЦС, УХЗ, үйлдвэр	Яндангийн өндөр + Утааны хийн агаарт тархах өндөр
Бага оврын УХЗ	5 м
Гэрийн зуух (ханан пийшин)	3 м
Автомашин (Замын тоосонцорыг багтаана), бусад эх үүсвэр	2 м

#### (2) Цагийн өөрчлөлт (нийтлэг)

Эх үүсвэр тус бүрийн цагийн өөрчлөлтийг Хүснэгт 2.1-29-д үзүүлэв.

**Хүснэгт 2.1-29 Эх үүсвэр тус бүрийн цагийн өөрчлөлт**


Эх үүсвэр	Цагийн өөрчлөлт
ДЦС, УХЗ, Үйлдвэр	Сар бүрийн түлш зарцуулалтын хэмжээнээс сар тус бүрийн өөрчлөлтийг тогтоосон
Бага оврын УХЗ	Сар бүрийн түлш зарцуулалтын хэмжээнээс сар тус бүрийн өөрчлөлтийг тогтоосон
Гэрийн зуух (ханан пийшин)	Улирал бүрээр, цаг бүрээр өөрчлөлтийг тогтоосон.
Автомашин (Замын тоосонцорыг багтаана), бусад талын эх үүсвэр	Ажлын өдөр, амралтын өдөр бүрээр цагийн өөрчлөлтийг тогтоосон.
Бусад	Сар бүрээр өөрчлөлтийг тогтоосон.

**(3) NO<sub>2</sub>-ын хувиргалт**

Агаарын орчны стандартад NO<sub>2</sub> -ыг хамруулдаг учир NOx-ын тархалтын загварчлалын дүнг NO<sub>2</sub>-н агууламжид хувиргах шаардлагатай байдаг. Иймд бодит хэмжилтийн утгын NOx болон NO<sub>2</sub>-оос, азотын ислийн нийт хэмжээний хэм хэмжээний зааварчилгаанд байгаа статистикийн моделийг ашиглаж NO<sub>2</sub>-ын хувиргалтын томъёог тооцоолсон. Мониторингийн дүнгээс NOx-оос NO<sub>2</sub>-д хувиргах томъёог Зураг 2.1-23-д үзүүлэв. Хувиргалтын томъёоны хувьд NOx-ын тархалтын загварчлалын дүнг дараах байдлаар тохируулснаар NO<sub>2</sub>-ын тооцооллын агууламжийг гаргасан.

Гэхдээ [NO<sub>2</sub>-ын тооцооллын агууламж]>[NOx-ын тооцооллын агууламж]-ын тохиолдолд [NO<sub>2</sub>-ын тооцоолсон агууламж]=[NOx-ын тооцоолсон агууламж] гэж тооцож үзсэн.

$$[NO_2 \text{ тооцооллын агууламж}] = 2.9076 \times [NOx \text{ тооцооллын агууламж}]^{0.6216}$$



**Зураг 2.1-23 NOx-оос NO<sub>2</sub>-д хувиргах тооцоолол**


**(4) Тооцооллын утгыг бодит хэмжилтийн утгатай харьцуулсан модель боловсруулалт**

УБ хотын хэмжээнд НАЧА болон БОХТЛ-ын агаар орчны суурин харуулаар автоматаар тасралтгүй хэмжилт явагдаж байдаг. БОХТЛ-ын суурин харуулын хувьд техникийн засвар үйлчилгээг тогтмол хийж байдаг тул хэмжилтийн утгын гажуудал бараг байхгүй, өвлийн улирлын цаг тутмын дундаж агууламжийн дүн шинжилгээнээс дүгнэхэд хэмжилтийн өгөгдөл нь итгэлцүүрийн түвшин өндөртэй гэж үзэж байна. Харин НАЧА-ны суурин харуулын тухайд төслийн судалгаанд хамруулсан хугацааны хэмжилтийн өгөгдлийн зөрүү, утгын гажуудал ихтэй байгаа юм. Иймд БОХТЛ-ийн өгөгдлийг ашиглаж тооцооллын утга болон бодит хэмжилтийн утгын харьцуулалтыг хийж, тархалтын загварчлалын моделийг гаргасан болно. Тархалтын загварчлалын моделийг гаргахдаа мэргэжилтний дүгнэлтийн эх үүсвэрийн инвенторыг ашигласан.


БОХТЛ-ын суурин харуулын тооцооллын утгатай бодит хэмжилтийн утгыг харьцуулсан дүнг Зураг 2.1-24~Зураг 2.1-27-д үзүүлэв.  $SO_2$ ,  $CO$  -нь тооцооллын утгатай бодит хэмжилтийн утгын харьцаа нь бараг 1 харьцах 1 гэсэн байдалтай байгаа бөгөөд корреляцын коэффициент нь нэлээн өндөр байгаа тул маш нарийвчлал сайтай тархалтын загварчлалыг гаргаж чадсан.

Мөн  $PM_{10}$ -ын хувьд корреляцын коэффициент нь өндөр байгаа бөгөөд тооцооллын утга нь бодит хэмжилтийн утгын тал хувьтай болсон байна.  $PM_{10}$ -ын тооцооллын утга нь бодит хэмжилтийн агууламжийн тал хувь байгаагын шалтгааныг дараагийн ” 2.1.6.4  $PM_{10}$ -ын тооцооллын утга болон бодит хэмжилтийн утгын агууламжийн зөрүү “ хэсэгт тайлбарлана.


$NO_2$ -ын хувьд корреляцын коэффициент нь харьцангуй өндөр байна. 3 суурин харуулын тооцооллын утга нь хэтэрхий их өндөр болсон байгаа бөгөөд БОХЗТЛ-ын CLEM -2 суурин харуулын тооцооллын утгын загварт илэрхийлэгдэх дүрслэлийн байдал доогуур байна. Үүний шалтгаан нь CLEM 02 суурин харуул нь хөдөлгөөн ихтэй замын уулзварт байрласан байдаг тул автомашины хаягдал утааг хэмжих суурин харуулын төрөлд орох юм. Иймд автомашины хаягдал утааны нөлөөллийн улмаас бодит хэмжилтийн утга нь тухайн цэгийн төлөөлөх үндсэн агууламжаас их гарсан байх магадлал өндөртэй юм. Тус модель нь 1 км×1 км-ийн хавтгай дөрвөлжин талбайн дундаж агууламжийг ашиглахад тохиромжтой боловч хэдэн арван метрийн талбайг хамарсан агууламжийг илэрхийлэхэд тохиромжгүй юм. Автомашины хаягдал утааны нөлөөлөлтэй хэсэг газрыг хасвал УБ хотын хэмжээнд  $NO_2$ -ын орчны агууламжийг тодорхойлж мэдэхэд нарийвчлал сайтай модель болсон.




Зураг 2.1-24 Тооцооллын утгыг бодит хэмжилтийн утгатай харьцуулсан дүн (PM<sub>10</sub>)



Зураг 2.1-25 Тооцооллын утгыг бодит хэмжилтийн утгатай харьцуулсан дүн (SO<sub>2</sub>)



Зураг 2.1-26 Тооцооллын утгыг бодит хэмжилтийн утгатай харьцуулсан дүн (CO)



Зураг 2.1-27 Тооцооллын утгыг бодит хэмжилтийн утгатай харьцуулсан дүн ( $\text{NO}_2$ )

#### 2.1.6.4 PM<sub>10</sub>-ын тооцооллын утга болон бодит хэмжилтийн утгын агууламжийн зөрүү

PM<sub>10</sub>-ын ялгарлын хэмжээг тархалтын загварчлалын дүнтэй харьцуулахад дөнгөж тал хувьтай байгааг тодорхойлж мэдсэн бөгөөд тархалтын загварчлалын дүнг бодит хэмжилтийн дүнтэй харьцуулахад ийнхүү дөнгөж хагас хувьтай байгааг дараах шалтгаанаас үүдэлтэй гэж үзэж болох юм.

- Суурин харуулын PM<sub>10</sub> нь β туяа нэвчүүлэх арга (Beta-ray attenuation method) эсвэл туяа сарниулах аргачлалыг ашигласан хэмжилтийн аргачлалыг хэрэглэсэн юм. Өвлийн улирлийн хэмжилтэд УБ хотын -30 ~ -40 температурт буурах нөхцөлд хөлдсөн агаар дахь чийгийг хэтрүүлэн хэмжиж, бодит агууламжаас хэт их гарсан байх магадлалтай юм.
- Агаарт ялгарсан бохирдуулах бодис (анхдагч тоосонцор) нь урвалд орж үүсмэл тоосонцор болдог ба PM<sub>10</sub>-ын тархалтын загварчлалын модельд үүсмэл тоосонцорыг харгалзан оруулаагүй болно. Үүсмэл тоосонцорт хүхрийн нэгдэл (сульфат), азотын нэгдэл (нитрат, аммони), хлорын нэгдэл (хлорид) болон нүүрстөрөгчийн нэгдэл (органик бодис) гэсэн 4 төрөл байдаг. Ялангуяа УБ хотод нүүрсний шаталтаас хүхрийн ислүүд (SO<sub>x</sub>) болон органик бодисын ялгарал их байдаг ба үүсмэл тоосонцор их хэмжээгээр үүсч бий болдог. Иймээс PM<sub>10</sub>-ын бодит хэмжилтийн утга нь анхдагч тоосонцор гэж үзэж байгаа эх үүсвэрээс баримжаалан тооцоолсон тооцооллын утгаас өндөр гарсан байх магадлалтай юм.
- PM<sub>10</sub> -д түлшний шаталтаас үүдэлтэй ялгарлаас гадна үнсэн сангаас хийсэх тоосонцор, автозамаас бужигнах тоос шороог хамруулсан болно. Шаталтаас бусад тоосонцор, тоос шорооны ялгарлын коэффициент нь маш өргөн хүрээг хамардаг тул ямар, аль коэффициентийг ашиглахаас шалтгаалан ялгарлын хэмжээнд ихээхэн зөрүү ялгаа үүсдэг. Мөн коэффициентийн нарийвчлал нь хангалтгүй байдаг.
- Шаталтын төрлөөс бусад байдлаар PM<sub>10</sub> -ыг үүсгэж ялгаруулж байгаа эх үүсвэр байгаа.
- Үйлдвэр зэргийн ялгарлын хэмжээг тодорхойж мэдэж чадаагүй байгаа зүйл бий. Гэвч ихэнх тоосгоны үйлдвэр, асбелтын үйлдвэр нь зуны улиралд ажилладаг тул зөвхөн өвлийн улиралд ажиллаж байгаа үйлдвэрийг хамруулах болно. Иймээс үйлдвэрийн нөлөөлөл нь бусад хүчин зүйлтэй харьцуулахад нөлөөлөл нь бага байх магадлалтай юм.

PM<sub>10</sub>-ын ялгарлын хэмжээний баримжаалсан тооцоололд ашигласан ялгарлын коэффициент нь тус төслийн 2 дахь дэлгэрэнгүй төлөвлөгөөг боловсруулах судалгааны хүрээнд хэмжигдсэн нүүрс 5.4 кг/тонн, түлээ 3.82 кг/тонн-ыг ашигласан. Дэлхийн банкны “Агаарын мониторинг, агаарын бохирдлын эрүүл мэндэд үзүүлж буй нөлөөллийн талаарх суур судалгаа” (AMHIV)ны хувьд гэрийн зуухны ялгарлын коэффициентыг 16 кг/тонн, түлээ 18.5кг/тонн гэж ашигласан байгаа. ЕМЕР/ЕЕА<sup>4</sup>-ын ялгарлын коэффициент (380гр/ГЖ) болон нүүрсний дулааны хэмжээ<sup>2</sup> (13.4ГЖ/тонн) -ээс тооцсон PM<sub>10</sub>-ын ялгарлын коэффициент 5.09 кг/тонн-той харьцуулсан ч Дэлхийн банк AMHIV-ны ялгарлын коэффициент илэрхий өндөр байгаа нь тодорхой байна. Одоогийн шатанд Дэлхийн банк AMHIV-ны гэрийн зуухны ялгарлын өндөр коэффициентыг тайлбарлаж чадах үндэслэл байхгүй байна.

PM нь БО-ны стандартын утгаас доогуур болгох арга хэмжээг сонгоход, эх үүсвэрийн инвентор, тархалтын загварчлалын моделийг сайжруулах шаардлагатай юм. Шинээр одоо инвенторт хамруулж чадаагүй байгаа агаар бохирдуулах эх үүсвэрийг хайж тогтоох, PM-ын найрлагын дүн шинжилгээ,

---

<sup>4</sup> Small Single household scale, capacity<=50kWth boiler

Tier 2 emission factors for source category boiler burning solid fuel (except biomass)

<http://www.eea.europa.eu/publications/emep-eea-emission-inventory-guidebook-2009/part-b-sectoral-guidance-chapters/1-energy/1-a-combustion/1-a-4-small-combustion-tfeip-endorsed-draft.pdf>

<sup>4</sup> ДЦС 4-ын нүүрсний найрлагын шинжилгээний дүн ( 3200kcal/kg)-д үндэслэн суурилуулсан.




2догч үүсмэл моделийг гаргахад шаардлагатай цаг уурын өгөгдөл зэргийг хэмжиж, РМ нь агууламж өндөртэй байгаагын шалтгааныг тодруулах шаардлагатай байна. Мөн үүсмэл 2догч шинжтэй бодисын ялгарлыг багасгах, ялангуяа SO<sub>x</sub>-ын ялгарлын хэмжээг ихээр бууруулах аргын талаар судлах нь зүйтэй юм.


## **2.1.7 Тархалтын загварчлалын дүн**

### **2.1.7.1 Тархалтын загварчлалын дүн**


Хамруулсан хугацаа (2010 оны 11 сараас 2011 оны 2 сар хүртэл)-н дахь SO<sub>2</sub>, РМ<sub>10</sub>, СО болон NO<sub>2</sub>-ын тархалтын загварчлалын дүнг Зураг 2.1-28~Зураг 2.1-31-д үзүүлэв. SO<sub>2</sub> болон РМ<sub>10</sub>-ын хувьд Энх тайвны өргөн чөлөөнөөс хойд талын гэр хорооллын нутаг дэвсгэрт агууламж хамгийн өндөр байгаа бөгөөд бараг ижил хэмжээгээр тархсан байна. Гэр хорооллын нутаг дэвсгэрт өндөр агууламжтай байгаа нь ялгарлын өндөр газраас 5 м хүрэхгүй нам дор байгаагаас орчны агууламжид хүчтэй нөлөөлж байна гэж үзэж байна. СО нь SO<sub>2</sub> болон РМ<sub>10</sub>-тай төстэй тархсан байгаа бөгөөд ДЦС-ын ялгарлын нөлөөлөл багатай тул ерөнхийдөө агууламжийн тархалтын хүрээ нарийссан байна. NO<sub>2</sub> нь хөдөлгөөний эрчим ихтэй замын уулзвар орчимд агууламж өндөртэй гарч байна. Бусад хугацааны тархалтын загварчлалын дүнг Хавсралт материал 2.1-14-д, УХЗ-ны тархалтын загварчлалын дүнг Хавсралт материал 2.1-15-д тус тус үзүүлэв.




Зураг 2.1-28 SO<sub>2</sub>-ын тархалтын загварчлалын дүн (2010 он)



Зураг 2.1-29 PM<sub>10</sub>-ын тархалтын загварчлалын дүн (2010 он)



Зураг 2.1-30 СО-ын тархалтын загварчлалын дүн (2010 он)



Зураг 2.1-31 NO<sub>2</sub>-ын тархалтын загварчлалын дүн (2010 он)

### **2.1.7.2 Агаар орчны суурин харуулын тооцооллын агууламж болон эх үүсвэр тус бүрийн эзлэх нөлөөллийн агууламж**

2010 оны агаар орчны суурин харуул (НАЧА, БОХЗТЛ) болон УХЗ-ны орчны хамгийн өндөр агууламж бүхий газар дах бохирдуулах эх үүсвэр тус бүрээр тооцоолсон агууламжийг Хүснэгт 2.1-30-д үзүүлэв. Тооцоолсон агууламжийг 100% гэж үзэхэд тухайн газар болгоны эх үүсвэр тус бүрийн эзлэх нөлөөллийн хэмжээг Зураг 2.1-32~Зураг 2.1-35 –д үзүүлэв. Мөн эх үүсвэрийн төрлөөр өмнө болон хойд зүгээр хөндлөн огтолж үзүүлсэн бохирдуулах бодис тус бүрийн эзлэх нөлөөллийн агууламжийг Зураг 2.1-36~Зураг 2.1-39- д үзүүлэв.

Тус тооцооллын агууламж нь 4 сарын (11 сараас 2 сар) хугацааны дундаж утга юм. Орчны агаарын стандарт (MNS 4585:2007) ын дундажилсан цаг нь өөр бөгөөд тус стандарт нь агаарын бохирдлын түвшинг тогтоох зорилготой болохоор стандартын утгыг ч зурагт үзүүлсэн болно.

Энэ зургаас агаар бохирдуулах бодис тус бүрээр эзлэх нөлөөллийн агууламжийг бууруулах шаардлагатай эх үүсвэрийн төрөл, стандартаас хэтэрсэн байдлыг мэдэж болох юм. Тус техникийн хамтын ажиллагааны төслийн хүрээнд боловсруулсан инвентор, тархалтын загварчлалын техникийн гарын авлагыг ашиглавал төрөөс авч хэрэгжүүлэх бодлогыг тогтоож шийдвэрлэхдээ тус бүрийн эзлэх нөлөөллийн агууламжийг тооцоолж гаргаснаар үр дүн сайтай бодлого, арга хэмжээг сонгох боломжтой болох юм. Мөн тус төслөөс ялгарлын бууруулахад үр дүнтэй гэж үзэж буй хэрэгжүүлэх арга хэмжээний санал болон УБ хот болон МУ-ын хэмжээнд судлагдаж буй төрийн гол гол бодлогоос сонгож, ялгарлын бууралтын үр дүнтэй эзлэх нөлөөллийн агууламжийг бууруулах үр дүнг үнэлэх талаар жишээ гаргаж үзүүлэв. (2.5.9 харах)

#### **(1) SO<sub>2</sub>**

SO<sub>2</sub>-ын хувьд гэрийн зуух (ханын пийшин оруулсан) -ны нийт агууламжийн 70~80%-ийг эзэлж байгаа бөгөөд эзлэх нөлөөлөл хамгийн ихтэй байна. Дараа нь ДЦС орж байна. Ялгарлын хэмжээний тухайд эзлэх нөлөөллийн агууламж нь өндөр байгаа нь гэрийн зуухнаас ялгарах бохирдол нь тухайн орчиндоо тархдаг тул орчны агууламжид шууд хүчтэй нөлөөлж байгаа юм.

AQDCC-2 болон CLEM-5-д зөвхөн гэрийн зуухны эзлэх нөлөөллийн агууламж нь өдрийн дундаж стандартаас 4.5-6.5 дахин их агууламжтай байна. Гэрийн зуух (ханын пийшин оруулсан)-наас ялгарах SO<sub>2</sub>-ын ялгарлын хэмжээг дорвитой бууруулах төрийн бодлого, арга хэмжээг хэрэгжүүлэхгүй бол агаарын чанарын стандартыг хангах боломжгүй гэж үзэж байна.

#### **(2) PM<sub>10</sub>**

- Төвлөрүүлэлтэнд хамруулах зуухнууд дотор ялгаралын коэффициент ихэй, АҮК муутай зуух ашиглагдаж байгаа бөгөөд эдгээрийг төвлөрүүлэн нэгтгэхдээ ялгаралын коэффициент багатай өндөр АҮК-той зуухаар солисноор PM<sub>10</sub>-ын ялгарлын хэмжээг бууруулж чадах юм.

**(5) Арга хэмжээний зардал**

8,440,000,000₮ (=¥495,000,000)

Хоёр шаттай хөнгөлттэй зээлээр Ар-Хангай аймагт хэрэгжиж байгаа УХЗ-ыг төвлөрүүлэх ажлын зардлыг Ар-Хангай аймгийн УХЗ-ны дулааны хэмжээтэй төвлөрүүлхээр болоод байгаа УХЗ-нуудын нийт дулааны хэмжээний харьцуулалтаас арга хэмжээний зардлыг тооцоолсон.

**(6) Тенхикийн зохистой байдал-Тогтолцоонд тулгарах асуудал**

Орон нутгийн тухайд том оврын УХЗ-нууд суурилагдсан байгаа нь технологийн хувьд асуудал гарахгүй гэсэн үг.

Урьд өмнө төлөвлөгдөөд байсан Амгалангийн дүүрэгт төвлөрсөн УХЗ-нд шилжүүлэх тухайд ИТХ-ын тогтоол зэрэг баримт бичгийн бүрдүүлэлт хэрэгтэй байсан бөгөөд тэрхүү бүрдүүлэлт асуудалгүй шийдвэрлэгдсэн гэж дуулсан. Тухай үед гарч байсан гол асуудал нь түгээх шугам угсралтын зардлын асуудал байсан.

**(7) Үйл ажиллагаа эрхлэгч-Төр захиргааны байгууллагын үүрэг оролцоо**

УХЗ-ыг төвлөрүүлнэ гэдэг нь өмнө нь байсан УХЗ-ыг ашиглалтаас гаргана гэсэн үг учраас төр захиргааны байгууллагаас тэрхүү УХЗ-ны үйл ажиллагаа явуулдаг ААН-д тохируулга хийх шаардлагатай болно гэж бодож байна.

Үйл ажиллагаа эрхлэгчид санхүүжилтээ гаргаж УХЗ-ны угсралт-ажиллуулах ажлыг гүйцэтгэнэ. төр захиргааны байгууллага нь үйл ажиллагааны төлөвлөгөөг баталж, зөвшөөрөл олгодог байх

**(8) Арга хэмжээтэй холбоотой бусад асуудал**

УХЗ-нд циклон үнс баригч суурилуулалт нь УХЗ-ны овор хэмжээнээс хамаарахгүй боломжтой учраас төвлөрүүлсэн УХЗ-д циклон үнс баригч суурилуулах боломжтой. Мөн төвлөрүүлхээр болсон тохиолдолд жижиг УХЗ-ыг ашиглалтаас гаргах болж байгаа тул УХЗ-нуудад циклон үнс баригч суурилуулах арга хэмжээтэй давхцах зүйлгүй юм.

**2.5.9.3 Циклон үнс баригч суурилуулалт ( Арга хэмжээний санал-2)**

**(1) Арга хэмжээний товч талицуулга**

2010 онд зуухны байгууламжаар биечлэн явж хийсэн судалгаанд тулгуурлан утааны хийн ялгарлыг бууруулах тодорхой арга хэмжээ аваагүй УХЗ-нд шинээр циклон суурилуулах.

**(2) Арга хэмжээнд нөлөөлөх орчин**

УБ хотын хэмжээнд 200 гаруй УХЗ байдаг бөгөөд тэдгээрийн ихэнх нь РМ<sub>10</sub>-ын ялгарлын стандартыг хангаагүй байна. Мөн зуухны байгууламж байрлах нутаг дэвсгэр нь ДЦС-ын төвийн шугамд холбогдох боломж муутай байгаа тул агаарын бохирдлыг бууруулах арга хэмжээг яаралтай авч хэрэгжүүлэх нь чухал юм. Иймд УХЗ-ны ажиллагааг зогсоолгүй харьцангуй бага зардал бүхий холбогдох тоног төхөөрөмжийг суурилуулах зэргээр агаарын бохирдлыг бууруулах шаардлагатай байна.

УХЗ нь циклонтой эсэхээс шалтгаалан РМ<sub>10</sub>-ын ялгарлын коэффициент нь хэдэн арав дахин зөрүүтэй байдаг. Циклоныг УХЗ суурилуулсаны дараа суурилуулж болох бөгөөд ашиглалт болон засвар үйлчилгээ хийхэд амархан төхөөрөмж юм. Иймээс арга хэмжээ санал (2)-д циклонгүй байгаа УХЗ-нуудыг хамруулан циклон суурилуулж, утааны хийг шүүх ажлыг санал болгох юм.

**(3) Арга хэмжээний дэлгэрэнгүй**

УХЗ-нд авах арга хэмжээний санал (2)-ын суурь нөхцөл болон арга хэмжээний хувилбарыг боловсруулах товч агуулгыг Хүснэгт 2.5-18 -д үзүүлэв.


**Хүснэгт 2.5-18 Суурь нөхцөл болон арга хэмжээний хувилбарын танилцуулга**

	<b>Суурь нөхцөл</b>	<b>Циклон суурилуулалт</b>
Агуулга		2010 оны зуухны биечилсэн судалгаанд утааны хийн арга хэмжээ аваагүй УХЗ-нд шинээр циклон суурилуулж, тоосны ялгарлыг багасгах.
Нүүрс зарцуулалт	2010 оны зуухны биечилсэн судалгааны мэдээлэл	Суурь судалгаатай адил
Яндангийн мэдээлэл	2010 оны зуухны биечилсэн судалгааны мэдээлэл	Суурь судалгаатай адил
Ялгарлын коэффициент	2 дах жилийн утаа хийн хэмжилтийн дүн	Суурь судалгаатай адил
Тоос барих хувь	2010 оны зуухны биечилсэн судалгааны мэдээлэл	73% (Галын хотлын сийрэгжилтийн дүнг харгалзан үзэх)

**(4) Арга хэмжээний үр дүн**

Суурь нөхцөл болон арга хэмжээ (2) –т  $PM_{10}$ -ын ялгарлын хэмжээний графикийг Зураг 2.5-22-т үзүүлэв. Мөн суурь нөхцөл болон арга хэмжээ санал (2)-ын ялгарлын хэмжээний тархалтыг Зураг 2.5-23-д үзүүлэв. Циклон үнс баригчаар авсан арга хэмжээгээр  $PM_{10}$ -ын ялгарлын хэмжээ 813.59 тонноор буурсан байна.

Мөн арга хэмжээний санал (2)-ын  $PM_{10}$ -ын агууламжийн тархалтын харьцуулалтыг Зураг 2.5-24-д үзүүлэв.




	PM <sub>10</sub>
Суурь нөхцөл	1,307.00
Арга хэмжээ (2)	493.41


Нэгж : тонн/жил

Зураг 2.5-22 Суурь нөхцөл ба арга хэмжээний санал (2)-ын PM<sub>10</sub>-ын ялгарлын хэмжээ





Зураг 2.5-23 Суурь нөхцөл ба арга хэмжээний санал (2)-ын PM<sub>10</sub>-ын ялгарлын хэмжээний тархалтын харьцуулалт



Зураг 2.5-24 Суурь нөхцөл ба арга хэмжээний санал (2)-ын PM<sub>10</sub> агууламжийн тархалтын харьцуулалт

Суурь нөхцөл болон арга хэмжээний хувилбарын тархалтын загварчлалд хамгийн өндөр агууламжийг Хүснэгт 2.5-19 -д үзүүлэв.  $PM_{10}$ -ын нийт агууламжийн тухайд буурсан байгаа бөгөөд арга хэмжээний санал (1)-тэй харицуулахад бууралтын үр дүн багатай байна.  $PM_{10}$ -ын ялгарлын хэмжээ буурч хамгийн өндөр агууламжаар суурь нөхцөлтэй харьцуулахад 1/3 болсон байгаа бөгөөд УХЗ-ны ялгарлын тархалт өөрчлөгдсөн учраас хамгийн өндөр агууламж үүсэх бүхий газарт томоохон өөрчлөлт ороогүй гэж бодож байна.

**Хүснэгт 2.5-19 Суурь нөхцөл болон арга хэмжээний санал (2)-ын тархалтын загварчлалын хамгийн өндөр агууламж**

Нэгж :  $\mu g/m^3$

	Суурь нөхцөл	Арга хэмжээ (2)
$PM_{10}$	33.71	11.04

Дээр үзүүлсэнчлэн циклоныг суурилуулсанаар тодорхой хэмжээгээр агаарын бохирдлыг бууруулах ач холбогдолтой гэж үзэж байгаа тул үр дүнтэй арга хэмжээг голлон хэрэгжүүлэх боломжтой юм. Гэхдээ циклон үнс баригчаар 73%-ийн шүүлттэй арга хэмжээ авсан байлаа ч УХЗ-ны ялгарлын стандартыг хангахгүй УХЗ их хэмжээтэй үлдсэн байгаа. Үйм учраас цаашид УХЗ-ны шаталтын хяналтыг сайжруулж, циклон үнс баригчийн шүүлтийг дээшлүүлэх, УХЗ-ыг төвлөрүүлэх болон шинэчлэх ажлыг идэвхжүүлэх шаардлага байна.

**(5) Арга хэмжээний зардал**

428,000,000₮ (=¥25,200,000)

Зуух тус бүрт циклон үнс баригч болон утаа сорогч суурилуулах зардал болох 510,000₮ болон 84 ширхэг УХЗ-нд тооцоолсон.

**(6) Технологийн зохистой байдал-Тогтолцоонд тулгарах асуудал**

Циклон үнс баригч суурилуулсан УХЗ-нууд оршин байгаа нь технологийн боломжтой гэсэн илэрхийлэл болно. Гэхдээ циклон үнс баригчийг суурилуулж байршуулах орон зайн асуудал болон циклон үнс баригч суурилуулснаас болж үүдэх даралтын алдагдлаас хамгаалах утаа сорогч суурилуулж тохиргоо хийх шаардлагатай. УХЗ-ны эзэмшигч өөрийн зардлаар циклон үнс баригчийг суурилуулах учраас тогтолцоонд зөрчил үүсэхгүй.

**(7) Үйл ажиллагаа эрхлэгч-Төр захиргааны байгууллагын үүрэг оролцоо**

Ирээдүйд, үйл ажиллагаа эрхлэгч нь ялгарлын стандартыг мөрдөж ажиллах үүрэгтэй болох бөгөөд, циклон үнс баригч суурилуулах нь үүний нэг арга хэмжээний шатлал юм. Төр захиргааны байгууллагын үүрэг оролцоо нь ялгарлын журмыг эрх тэгш байдлаар хэрэгжүүлэх явдал бөгөөд үйл ажиллагаа эрхлэгч нар арга хэмжээний зориулалттай тоноглол суурилуулалтын ажилд дэмжлэг үзүүлэх санхүүжилтийн тогтолцоо зэргийг судалж үзэх асуудал үүдэн гарна.

**(8) Арга хэмжээтэй холбоотой бусад асуудал**

Дээр дурьдсанчлан циклон үнс баригч суурилуулах нь ялгарлын стандартыг мөрдүүлэх арга зам бөгөөд энэ арга хэмжээ нь урьд нь байсан УХЗ-нд нэмэлтээр суулгах, шинээр УХЗ-ны суурилуулалтанд ч боломжтой болно.

**2.5.9.4 Гэрийн зуухыг УХЗ-аар солих (Арга хэмжээний санал-3)**

**(1) Арга хэмжээний товч танилцуулга**

Чингэлтэй дүүргийн хойд хэсгийн гэр хорооллын гэрийн зуух болон ханын пийшингийн хэрэглээг зогсоож, оронд нь том оврын АҮК өндөртэй DZL маркийн зуухыг суурилуулах.


**(2) Арга хэмжээний нөлөөлөх орчин**

ДЦС-аас УБ хотын гэр хорооллыг дулаанаар хангахын тулд маш их хэмжээний хөрөнгө оруулалт шаардагдах тул бүрэн биелэгдэх магадлал багатай бөгөөд одоогийн ДЦС-ын дулаан хангамжийн хүчин чадлаар гэр хорооллыг хангах боломжгүй юм.

Турк зуух, сайжруулсан түлш хэрэглэх зэрэг арга хэмжээнээс гадна нэмэлт арга хэмжээг хэрэгжүүлэх шаардлагатай байна. Халаалтын зуух ашиглалт зохицуулалтын газар нь 500 гаруй өрхийг төвлөрсөн үүсгүүртэй болгож том оврын АҮК өндөртэй УХЗ-ыг суурилуулах талаар судалж байна. Иймд цаашид хэрэгжүүлэх арга хэмжээний санал (3) -д Чингэлтэй дүүргийн гэр хорооллыг төвлөрүүлсэн үүсгүүртэй болгож өндөр бүтээмж бүхий УХЗ суурилуулахыг санал болгож байна.

**(3) Арга хэмжээний дэлгэрэнгүй**

Арга хэмжээний санал (3)-д УХЗ-нд шилжүүлэх газрын хамрах хүрээг Зураг 2.5-25, суурь нөхцөл болон арга хэмжээний хувилбарыг суулгасан агуулгыг Хүснэгт 2.5-20-д үзүүлэв.



(шар зүүгээр хороодод тархсан УХЗ-ны байршлыг баримжаалан үзүүлэв.)

**Зураг 2.5-25 Арга хэмжээний санал (3)-д гэрийн зуухыг УХЗ-нд шилжүүлэх бүс нутаг (Чингэлтэй дүүргийн хойд хэсэг)**


**Хүснэгт 2.5-20 Суурь нөхцөл болон арга хэмжээний хувилбарын товч танилцуулга**

	Суурь нөхцөл	Гэрийн зуухыг УХЗ-аар солих
Агуулга		Хамрагдах хүрээ : Чингэлтэй дүүргийн гэр хороолол (Зураг 2.5-25) Шинээр суурилуулсан УХЗ-ны байршил : 500 өрхөд 1 зуухны байгууламж (бөөгнөсөн яндан) гэж үзээд хороодын өрхийн тооны мэдээллээс хороо тус бүрээр УХЗ-ны тархалтын тоог тооцоолох.
Нүүрс зарцуулалт	2010 оны зуухны биечилсэн судалгааны мэдээлэл	Суурилуулсан зуух : Гэр хорооллын хороо тус бүрийн нүүрс зарцуулалтын хэмжээ/ УХЗ-ны суурилуулсан тоогоор тооцооллох.
Яндангийн мэдээлэл	2010 оны зуухны биечилсэн судалгааны мэдээлэл	Суурилуулсан зуухны өндөр : 33 м Диаметр : 0.6 м Утааны хийн температур : төслийн 2 дах жилийн DZL зуухны утааны хийн хэмжилтийн дүн Утааны хийн хурд : Хороо тус бүрээр шаталтын чийгтэй утааны хэмжээ ба нүүрсний нийт зарцуулалтаас тооцооллох.
Ялгарлын коэффициент	Төслийн 2 дах жилийн утааны хийн хэмжилтийн дүн	Суурилуулсан зуух : 2 дах жилийн DZL зуухны утааны хийн хэмжилтийн дүн
Тоос барилт	2010 оны зуухны биечилсэн судалгааны мэдээлэл	Суурь нөхцөлтэй адил

**(4) Арга хэмжээний үр дүн**

Суурь нөхцөл ба арга хэмжээний санал (3)-ын SO<sub>2</sub> болон PM<sub>10</sub>-ын ялгарлын хэмжээний графикийг Зураг 2.5-26-д үзүүлэв. Мөн суурь нөхцөл болон арга хэмжээний санал (3)-ын ялгарлын хэмжээний тархалтыг Зураг 2.5-27 болон Зураг 2.5-28-д үзүүлэв. Гэрийн зуухыг DZL-ээр сольж тавьснаар 50%-аас 76.3%-ийн сайжиралт гарах тул нүүрсний хэрэглээ 34.5%-аар буурна. SO<sub>2</sub>-ялгарлын хэмжээ арга хэмжээ авахаас өмнө болон дараах байдалд 34.5% (287.85ton) -р буурч, PM<sub>10</sub>-ын ялгалын хэмжээ 87.7% (548.3ton) -оор буурах боломжтой болж байна.


Мөн арга хэмжээний санал (3)-ын SO<sub>2</sub> болон PM<sub>10</sub>-ын агууламжийн тархалтын харьцуулалтыг Зураг 2.5-29 болон Зураг 2.5-30-д тус тус үзүүлэв. Зурагт улаанаар дугуйлсан хэсэг нь хамгийн өндөр агууламж бүхий газар юм.




	SO <sub>2</sub>	PM <sub>10</sub>
Суурь нөхцөл	834.35	625.25
Арга хэмжээний санал (3)	546.50	76.85

Нэгж : тонн/жил

**Зураг 2.5-26 Суурь нөхцөл ба арга хэмжээний санал (3)-ын SO<sub>2</sub> болон PM<sub>10</sub>-ын ялгарлын хэмжээ**




Зураг 2.5-27 нөхцөл ба арга хэмжээний санал (3)-ын SO<sub>2</sub>-ын ялгарлын хэмжээний тархалтын харьцуулалт




Зураг 2.5-28 Суурь нөхцөл ба арга хэмжээний санал (3)-ын PM<sub>10</sub>-ын ялгарлын хэмжээний тархалтын харьцуулалт





Зураг 2.5-29 Суурь нөхцөл ба арга хэмжээний санал (3)-ын SO<sub>2</sub>-ын агууламжийн тархалтын харьцуулалт



Зураг 2.5-30 Суурь нөхцөл ба арга хэмжээний санал (3)-ын PM<sub>10</sub>-ын агууламжийн тархалтын харьцуулалт

Суурь нөхцөл болон арга хэмжээний хувилбарын агууламжийн тархалтын загварчлалд хамгийн өндөр агууламжийг Хүснэгт 2.5-21-д үзүүлэв.

УХЗ-нд шилжүүлсэн бүс нутагт SO<sub>2</sub>, PM<sub>10</sub>-ын агууламж илэрхий багассан байдалтай харагдаж байна. Хамгийн өндөр агууламж нь арга хэмжээ хэрэгжүүлээгүй үеийн байдалтай харьцуулахад 89%, 98% - иар тус тус буурсан байна.

**Хүснэгт 2.5-21 Суурь нөхцөл болон арга хэмжээний санал (3)-ын тархалтын загварчлалын хамгийн өндөр агууламж**

Нэгж :  $\mu\text{g}/\text{m}^3$

	Суурь нөхцөл	Арга хэмжээний санал (3)
SO <sub>2</sub>	78.52	8.62
PM <sub>10</sub>	59.10	1.21

Дээр дурдсанчилсан гэрийн зуухнаас УХЗ-нд шилжүүлэх арга хэмжээ нь үр дүнтэй байх шалтгааныг дурдвал:

- Гэрийн зуухнаас УХЗ-нд шилжүүлсэнээр 1 байгууламжид оногдох нүүрс зарцуулалтын хэмжээ нэмэгдэнэ. Ингэснээр шаталтын бүтээгдэхүүн утааны хийн хэмжээ ихсэж, яндангаас гарах утааны бодит өндрийн хэмжээ (effective height)-г өндөрсгөх боломжтой юм. Үүний үр дүнд SO<sub>2</sub>, PM<sub>10</sub> зэргийн тархалтыг шингэрүүлэн агаар орчны агууламжийг багасгах боломжтой болно.
- Гэрийн зуух нь АҮК өндөртэй УХЗ-тай харьцуулахад ялгарлын коэффициент өндөртэй тул нүүрсний зарцуулалт адилхан үед ч PM<sub>10</sub> зэргийн ялгарлын хэмжээ их байдаг. Иймд ялгарлын коэффициент бага, АҮК өндөртэй зууханд шилжүүлж төвлөрсөн эх үүсвэртэй болгосноор PM<sub>10</sub>-ын ялгарлын хэмжээг багасгаж чадах юм.
- Өндөр АҮК-той мөн том оврын УХЗ-ны хувьд циклон үнс баригч болон скруббер суурилуулах нь харьцангуй амархан бөгөөд эдгээр тоноглолоор PM<sub>10</sub>-ын ялгарлын бууралтад нөлөө үзүүлэх горьдлого төрүүлж байна.

**(5) Арга хэмжээний зардал**

16,930,000,000₮ (=¥996,000,000)

Хоёр шаттай хөнгөлттэй зээлээр ар хангай аймагт хэрэгжиж байгаа УХЗ-ыг төвлөрүүлсэн дулаанаар хангахаар тооцогдох хүн ам газрын нутгийн оршин суугчдын харьцаанаас арга хэмжээний зардлыг тооцоолсон.

**(6) Технологийн зохистой байдал-тогтолцоонд тулгарах асуудал**

Гэр хороололд УХЗ суурилуулах тохиолдолд цахилгаан эрчим хүч-хэрэглээний ус гэсэн дэд бүтцийн хангалт хүрэлцээгүй асуудлын талаар хангалттай сайн судалгаа хийх шаардлагатай бол дэд бүтцийг өргөтгөх хэрэгцээ шаардлага гарах магадлалтай.

Мөн УХЗ-аар халуун ус түгээхэд шаардлагатай шугамны угсралт холболтын зардал гаргах шаардлагатай болох бөгөөд бодитоор хэрэгжүүлэх тохиолдолд ТЭЗҮ-ийн судалгаа хийх хэрэгтэй болов уу.

Үйл ажиллагаа эрхлэгчийн талаас ч гэсэн орлого хаагдсан эсэх асуудал үүсэх магадлалтай учир эхний ээлжинд ХЗАЗГ-ын харьяа төрийн байгууллагад туршилтаар хэрэгжүүлэх нь илүү амьдралд ойрхон болов уу гэж бодож байна.

**(7) Үйл ажиллагаа эрхлэгч-Төр захиргааны байгууллагын үүрэг оролцоо**

Дээр өгүүлсэнчлэн төрийн байгууллагад туршилтаар хэргжүүлж, тэрхүү мэдээллийг хувийн хэвшилд өгөх зэргээр өргөжүүлэх байдлаар хэрэгжих боломжтой гэж үзэж байна.

**(8) Арга хэмжээтэй холбоотой бусад асуудал**

Гэр хороололд суурилуулах УХЗ-ны тухайд ялгарлын стандартыг мөрдүүлэлт болон циклон үнс баригч суурилуулах гэсэн арга хэмжээний судалгаанд авч үзэх. Гэрийн зуухыг орлуулахаар төсөөлсөн арга хэмжээ болж байгаа учраас энэ арга хэмжээг хэрэгжүүлэх газарт агаарын орчныг сайжруулсан бүс болон сайржуулсан түлшнүүд шаардлагагүй болно гэж төсөөлөгдөж байна.

**2.5.9.5 Буцламтгай үет шаталтгай зуухаар сайжруулах (Арга хэмжээний санал-4)**

**(1) Арга хэмжээний товч танилцуулга**

ДЦС Ш–ын тоосруулсан шаталтын системтэй зуухыг буцламтгай үет зуух болгож өөрчлөх.

**(2) Арга хэмжээний нөлөөлөх орчин**

ДЦС Ш –ын тоосруулсан шаталтын болон бункерийн системийн улмаас дэлбэрэлт гарах зэрэг асуудал үүсдэг тул зарим тоосруулсан шаталтын систем бүхий 75 т/ц зуухыг буцламтгай үет зуух болгон өөрчилсөн байдаг. Төслийн мэргэжилтний баг нь тус станцын дээрх байдлаар системийг шинэчлэн өөрчилсөн зуухыг судалж үзэхэд буцламтгай үет зуухны шаталт нь бохирдуулах бодисын ялгарлын хэмжээг багасгаж байгааг мэдэж магадласан болно. Тиймээс авах арга хэмжээний санал (4)-д ДЦС Ш-ын тоосруулсан шаталтын системтэй зуухыг буцламтгай үет зуух болгож өөрчлөх ажлыг хийх юм.

**(3) Арга хэмжээний дэлгэрэнгүй**

ДЦС Ш-т авах арга хэмжээний санал (4)-ын дэлгэрэнгүйг Хүснэгт 2.5-22-т үзүүлэв.


**Хүснэгт 2.5-22 Суурь нөхцөл болон авах арга хэмжээний хувилбарын товч танилцуулга**

	Суурь нөхцөл	Буцламтгай үет зуух болгох
Агуулга		ДЦС Ш-д суурилуулсан тоосруулсан шаталтын системтэй зуухыг буцламтгай үет зуух болгон өөрчлөх.
Нүүрс зарцуулалт	2010 оны 3 сар~2011 оны 2 сарын хооронд хэрэглэсэн нүүрсний хэмжээ	Суурь нөхцөлтэй адилхан
Яндангийн мэдээлэл	Яндангийн өндөр, диаметр, урьдчилсан судалгаагаар цуглуулсан мэдээллийн дүн Утааны хийн температур, хурд: 2 дах жилд хийгдсэн утааны хийн хэмжилтийн дүн	Суурь нөхцөлтэй адилхан
Ялгарлын коэффициент	2 дах жилд хийгдсэн утааны хийн хэмжилтийн дүн	Суурь нөхцөлтэй адилхан
Тоос барилт	байхгүй	2011 оны 12 сард 75т/ц-ын тоосруулсан шаталтын системтэй болон буцламтгай үет зууханд хийгдсэн хэмжилтийн дүнгээс зуух тус бүрийн хувьд 75%-иар суурилуулж, зуух бүрийн нүүрс зарцуулалттай жинлэсэн дундажийг авч ялгарлын багассан хэмжээг тооцоолсон. (75т/ц:54.63%, 220т/ц:72.68%)

**(4) Арга хэмжээний үр дүн**

Суурь нөхцөл болон арга хэмжээний санал (4)-ын  $PM_{10}$ -ын ялгарлын хэмжээний графикийг Зураг 2.5-31-д үзүүлэв. Буцламтгай үет шаталттай болгосноор  $PM_{10}$ -ын ялгарлын хэмжээ нийтдээ 2,943.51 тонноор багассан байна. Ялангуяа 220т/ц хүчин чадалтай зуух олонтой ДЦС-2,3-ын хувьд үр ашиг өндөртэй байгааг харж болно.


Мөн арга хэмжээний санал (4)-ын  $PM_{10}$ -ын агууламжийн тархалтын харьцуулалтыг Зураг 2.5-32-д үзүүлэв. Зурагт улаанаар дугуйлсан mesh нь орчны хамгийн өндөр агууламж бүхий цэг юм.



	Суурь нөхцөл	Арга хэмжээ (4)	Багассан хувь
PowerPlant 3-1	2,287.81	1,037.98	54.63%
PowerPlant 3-2	2,330.32	636.54	72.68%
ДЦС III нийт	4,618.13	1,674.62	63.74%

Нэгж : тонн/жил

**Зураг 2.5-31 Суурь нөхцөл болон арга хэмжээний санал (4)-ын PM<sub>10</sub>-ын ялгарлын хэмжээ болон ялгарлын багассан хэмжээ**



Зураг 2.5-32 Суурь нөхцөл болон арга хэмжээний санал (4)-ын PM<sub>10</sub> агууламжийн тархалтын харьцуулалт

Суурь нөхцөл болон арга хэмжээний хувилбарын агууламжийн тархалтын загварчлалын хамгийн өндөр агууламжийг Хүснэгт 2.5-23-т үзүүлэв.

Буцламтгай үет зуух болгож өөрчилсөнөөр агууламж их хэмжээгээр багасах нь харагдаж байгаа бөгөөд орчны хамгийн өндөр агууламжийг арга хэмжээ хэрэгжүүлээгүй байх тохиолдолтой харьцуулахад 65%-иар багассан байна.

**Хүснэгт 2.5-23 Суурь нөхцөл болон арга хэмжээний санал (4)-ын тархалтын загварчлалын хамгийн өндөр агууламж**

Нэгж :  $\mu\text{g}/\text{m}^3$

	Суурь нөхцөл	Арга хэмжээний санал (4)
PM <sub>10</sub>	9.37	3.31

Арга хэмжээний өмнөхтэй хамгийн өндөр агууламжийн харьцуулалтаар ДЦС Ш-ын тоосруулсан шаталтын системтэй зуухыг буцламтгай үет зуух болгосноор 65% орчим агаарын бохирдлын бууралт харагдаж байна. 75 т/ц зуухыг шинэчлэн өөрчлөхийн хувьд Монголд хийгдсэн бодит үр дүн байгаа тул санхүүжилтийг бүрдүүлж чадвал арга хэмжээг өмнөхийн адил хэрэгжүүлм чадна. Харин 220 т/ц зуухыг өөрчлөхийн хувьд Монголд хийсэн туршлага байхгүй болохоор зуухны овор томрох асуудал ч байгаа болхоор ахдагч загварын тухайд гадаад орны технологийг нэвтрүүлэх шаардлагатай. Анхдагч загварыг нэвтрүүлцнээр технологийн туршлага хуримтлагдаж, 2 дах загвараас хойш анхдагч загварын жишээгээр Монголд үйлдвэрлэх боломжтой болно гэж үзлээ.

**(5) Арга хэмжээний зардал**

Нийт 66,000,000 ам доллар (=¥5,412,000,000)

75т/ц Зуух: 1,000,000 ам. доллар/ × 4ширхэг

220т/ц Зуух: 20,000,000 ам доллар (Анхдагч загвар)

: 8,000,000 ам доллар/ширхэг (Анхдагч загвараас гадна)×5 ширхэг

Гэхдээ зогссон үед Зуух-9-ыг дахин ачааллах чиг хандлагагүй байгаа учраас хамруулаагүй болно.

**(6) Технологийн зохистой байдал-Тогтолцоонд тулгарах асуудал**

Дээр өгүүлсэнчлэн 75т/ц-ын зуухны тухайд өмнө нь амжилттай хэрэгжүүлсэн болхоор 220т/ц-ын тухайд гадны орны технологи шаардлагатай гэж таамаглагдаж байна. Өнөөгийн байдлаар ОХУ-д үйлвэрлэгдсэн зуухнууд байдаг учраас хэрэгжүүлэх байгууллагууд ч гэсэн хязгаарлагдмал байх магадлалтай.

**(7) Үйл ажиллагаа эрхлэгч-Төр захиргааны байгууллагын үүрэг оролцоо**

Зардлын хувьд асар өндөр болох учраас ДЦС-3 нь уг санхүүжилтийг гаргах боломж байгаа эсэх нь асар том асуудал болох болов уу. Тогтолцооны тухайд бол том оврын үйлдвэрлэлийн ажил болох учраас ЭХЯ-ны зөвшөөрөл шаардлагатай болно гэж бодож байна.



**(8) Арга хэмжээтэй холбоотой бусад асуудал**

БУШ-ын Зууханд өөрчлөн шинэчлэх нь зуухтай холбоотой арга хэмжээ болох учраас утаанд авах арга хэмжээний тоног хэрэгсэлийг хамтаар шийдэх боломж байгаа юм.

**2.5.9.6 Үнсэн сангаас хийсэхээс хамгаалах арга хэмжээ (Арга хэмжээний санал-5)****(1) Арга хэмжээний товч танилцуулга**

ДЦС-ын үнсэн сангийн хаягдал үнс хийсэхээс хамгаалсан арга хэмжээг хэрэгжүүлэх.

**(2) Арга хэмжээний нөлөөлөх орчин**

ДЦС-ын үнсэн сан нь битүү дүүрсэний дараа хуурай болсон үнс нь салхинд хийсэж, орчин тойрондоо ихээхэн нөлөө үзүүлж байгаа. Зарим үнсэн санд хуурай үнсийг хөрсөөр хучиж хийсэж бужигнахаас хамгаалсан байдаг. Мөн шатсан үнсийг үнсэн санд устай холин хаясан байдаг тул устай, чийгтэй байх үедээ салхинд хийсдэггүй байна. Иймээс ашиглаж буй үнсэн сангийн хувьд холих усны түвшинг нэмэгдүүлсэнээр хийсэлтийг багасгах боломжтой юм. Мөн салхинаас хамгаалсан өндөр хаалт, хашаа баривал үр дүнтэй байх боломжтой.

Иймээс арга хэмжээний санал (5)-д ДЦС-ын үнсэн сангаас хийсэх үнсийг багасгах арга хэмжээ (салхинаас хамгаалсан хаалт, хашаа барих зэрэг) –г хэрэгжүүлэх юм.

**(3) Арга хэмжээний дэлгэрэнгүй**

ДЦС-ын үнсэн санд авах арга хэмжээний санал (5) –ын дэлгэрэнгүйг Хүснэгт 2.5-24-д үзүүлэв.

**Хүснэгт 2.5-24 Суурь нөхцөл болон арга хэмжээний хувилбарын товч танилцуулга**

	<b>Суурь нөхцөл</b>	<b>Үнсэн санд авах арга хэмжээ</b>
Товч танилцуулга	2011 оны хувьд дараах үнсэн сангууд дүүрч, хөрсөөр хучихын тулд жил орчим хатаах байдалтай байгаа ДЦС II : Зүүн талын үнсэн сан ДЦС III : 5-р үнсэн сан ДЦС IV: 5-р үнсэн сан	Суурь нөхцлийн байдал буюу үнсэн сангийн үнс хуурайшиж бужигнан хийсэхээс хамгаалах зохимжтой хашаа, хаалтыг судлан сонгож, битүү дүүрсэн үнсэн санд хамгаалах хашаа, хаалтыг барих тохиолдолд(Зураг 2.5-33-д үзүүлэв) тус ажлыг хийх засварын машин үнсэн сангаар дотор давхин явж болохуйц хөлдсөн байх өвлийн улиралд хэрэгжүүлэх боломжтой гэж үзэн, хийсэлтээс хамгаалах үр дүнг 80%-тай гэж үзэх.
Дундаж идэлтийн гүн	2011 оын 3сараас 2012 оны 2 сарын хооронд хийссэн үнсний хэмжээний судалгааны дүн	2011 оны 3 сараас 2012 оны 2 сарын үнс хийсэлтийн судалгааны дүнгээс 80%-иар багасгасан үзүүлэлт утга
Хийсэлт явагдах хүрээ	ДЦС II зүүн талын үнсэн сан: 100% , ДЦС III 5-р үнсэн сан: 100% ДЦС IV 5-р үнсэн сан: 100%	ДЦС II зүүн талын үнсэн сан: 100% ДЦС III 5-р үнсэн сан: 100% ДЦС IV 5-р үнсэн сан: 100%




Эх сурвалж: Японы ой үржүүлгийн агентлагийн цахим хуудас  
( <http://www.rinya.maff.go.jp/j/sekou/gijutu/pdf/pdf/12bouhuu2.pdf> )

**Зураг 2.5-33 Салхинаас хамгаалах хашаа суурилуулсан жишээ**

**(4) Арга хэмжээний үр дүн**

Суурь нөхцөл болон арга хэмжээний санал (5)-ын РМ<sub>10</sub>-ын ялгарлын хэмжээг Зураг 2.5-34-т үзүүлэв. Арга хэмжээний өмнө хойно нь харьцуулалт хийж, РМ<sub>10</sub> -ын ялгарлын хэмжээнд 953.82 тонын бууралт гарсныг харж болно.


Мөн арга хэмжээний санал (5)-ын  $PM_{10}$  агууламжийн тархалтын харьцуулалтыг Зураг 2.5-35-д үзүүлэв. Зурагт улаанаар дугуйлсан mesh нь орчны хамгийн өндөр агууламж бүхий цэг юм. Арга хэмжээний өмнөхтэй харьцуулахад өндөр агууламжийн хүрээ нэлээд багассан байгааг харж болно.



Суурь нөхцөл	Арга хэмжээний санал (5)	Багассан хувь
1,192.27	238.45	80.00%

Нэгж : тонн/жил

**Зураг 2.5-34 Суурь нөхцөл болон арга хэмжээний санал (5)-ын  $PM_{10}$ -ын ялгарлын хэмжээ болон ялгарлын багассан хэмжээ**



Зураг 2.5-35 Суурь нөхцөл болон арга хэмжээний санал (5)-ын PM<sub>10</sub> агууламжийн тархалтын харьцуулалт

Суурь нөхцөл болон арга хэмжээний хувилбарын агууламжийн тархалтын загварчлалын хамгийн өндөр агууламжийг Хүснэгт 2.5-25-т үзүүлэв.

Үнсэн санд авах арга хэмжээг хэрэгжүүлсэнээр агууламж ихээхэн багасч байгаа нь харагдаж байна. Арга хэмжээний хувилбарын орчны хамгийн өндөр агууламжийг арга хэмжээ хэрэгжүүлээгүй байх тохиолдолтой харьцуулахад  $12.84 \mu\text{г}/\text{м}^3$  80%-иар багассан байна.

**Хүснэгт 2.5-25 Суурь нөхцөл болон арга хэмжээний санал (5)-ын тархалтын загварчлалын хамгийн өндөр агууламж**

Нэгж :  $\mu\text{г}/\text{м}^3$

	Суурь нөхцөл	Арга хэмжээний санал (5)
PM <sub>10</sub>	17.30	3.46

Дээр үзүүлсэнчлэн ДЦС-ын үнсэн сангаас үүдэлтэй агаарын бохирдлыг бууруулахад салхинаас хамгаалах хаалт, хашааг баривал ихээхэн үр дүнтэй байх нь мэдэгдэж байна. Хийсэлтийн хэмжээ их болох хүчтэй салхины улиралд салхинаас хамгаалах хашаа хаалт хийсэнч өндөр үр ашигтай байж болно.

**(5) Арга хэмжээний зардал**

223,140,000₮ (=¥13,130,000)

		Өртөг	Үнэ нэгж	Тоо	Нийт
Үндсэн сургалт	Японоос томиллоор	20,000,000	₮/удаа	1	20,000,000
Туршилт	Барилгын ажлы зардал	29,464,286	₮/жил	2	58,928,571
	Хүн хүчний зардал г.м	1,000,000	₮/сар	24	24,000,000
Хэрэгжилт	ДЦС-2	29,464,286	₮/удаа	1	29,464,286
	ДЦС-3	41,250,000	₮/удаа	1	41,250,000
	ДЦС-4	49,500,000	₮/удаа	1	49,500,000
Нийт					223,142,857

**(6) Технологийн зохистой байдал-тогтолцоонд түлгарсах асуудал**

Технологийн ийм шийдэлтэй хашаа хаалт барисан бодит жишээ байдаг боловч ашиглалтын боломжийн тухайд нягталж үзэх шаардлага байна.

Тогтолцооны хувьд ДЦС-ын хяналтанд байдаг үнсэн сан дотор хашаа хаалт барихад асуудал байхгүй.

**(7) Үйл ажиллагаа эрхлэгч- Төр захиргааны байгууллагын үүрэг оролцоо**

Зарчмын хувьд үйл ажиллагаа эрхлэгчид зардлыг хариуцахаар тооцоолж хэрэгжүүлэхээр тооцоолж байна. Эрчим хүчний яаманд арга хэмжээний төлөвлөгөөг зарлагын хамт тайлагнадаг байх.

**(8) Арга хэмжээтэй холбоотой бусад асуудал**

Үнсэн сангаас хийсэх тоосны эсрэг арга хэмжээ болох хөрсний хучилт зэрэгтэй давхцахгүй гэж бодож байна.

**2.5.9.7 MNS стандартыг хангуулах ( Арга хэмжээний санал-11)**

**(1) Арга хэмжээний товч танилцуулга**

2010 оны зуухны газарт биечлэн хийсэн судалгаан дотор утааны хэмжилт хийж MNS-ын стандартыг хангаагүй байгаа зуухнуудыг стандартыг хангахаар болсон гэж төсөөлөн нийт УХЗ-ыг MNS-ын стандартыг хангаж байгаад тооцох.

**(2) Арга хэмжээний нөлөөлөх орчин**

Улаанбаатар хотод 200 гаруй УХЗ байдаг бөгөөд  $PM_{10}$ -ын ялгарлын стандартыг хангаж чадахааргүй загварууд ихэнх хувийг эзлэж байна. УХЗ суурилагдсан газруудын ихэнх нь ДЦС-ын төвийн шугамаас дулаанд холбогдох боломжгүй нөхцөл байдалтай байгаа тул агаарын бохирдлын эсрэг арга хэмжээг яаралтай хэрэгжүүлэх шаардлагатай байгаа юм. Иймээс УХЗ-ны үйл ажиллагааг үргэлжлүүлж, аль болох хямд зардлаар арга хэмжээний тоноглолыг суурилуулан агаарын бохирдлыг бууруулах шаардлагатай байгаа юм.

УХЗ-ны утааны хэмжилтээс үзэхэд MNS-н стандартыг давсан байгаа УХЗ-нууд их ажиглагдсан. Иймд эдгээрыг стандартыг хангах хэмжээнд хүргэхийн тулд галалгааны хяналтыг сайжруулах, циклон үнс баригч суурилуулах, өндөр АҮК-той УХЗ-аар шинэчлэх зэрэг арга хэмжээнүүд шаардлагатай байна. Үүнд тулгуурлан арга хэмжээний санал-11 болгож MNS-ын стандартыг хангаагүй зуухнуудыг дээрх арга хэмжээнүүдийг хэрэгжүүлэн нийт УХЗ-ыг стандартыг хангуулдаг болгоно гэж оруулсан.

**(3) Арга хэмжээний дэлгэрэнгүй**

УХЗ-нд авах арга хэмжээний санал-11-ийн суурь нөхцөл болон арга хэмжээний хувилбарын тохируулгыг Хүснэгт 2.5-26 үзүүлэв.


**Хүснэгт 2.5-26 Суурь нөхцөл болон арга хэмжээний хувилбарын тохируулгын товч агуулга**

	Суурь нөхцөл	MNS-ын стандартыг хангах
Агуулга		2010 оны зуухны газар дээр биечлэн хийсэн судалгааны өгөгдөл дээрх 2 дах жилийн утааны хэмжилтэнд утааны хийний агууламж нь MNS-ын стандартыг хангаагүй зуухнуудыг стандарт утгатай болгосон.
Нүүрсний хэрэглээ	2010 оны зуухны газар дээр биечлэн хийсэн судалгааны өгөгдөл	Суурь нөхцөлтэй адил
Яндангийн мэдээлэл	2010-ны зуухны газар дээр биечлэн хийсэн судалгааны өгөгдөл	Суурь нөхцөлтэй адил
Ялгарлын коэффициент	2 дах жилийн утааны хийн хэмжилтийн дүн	2 дах жилийн хэмжилтийн дүнгээр үнсний хэмжээг дараах байдлаар суулгасан. ①Хэмжилтээр тоосны агууламж нь MNS-ын стандартаас давсан тохиолдолд: Тоосны агууламж MNS-ын стандартын доторх агууламжтай болсон гэж төсөөлж, ялгарлын коэффициентийг тооцоолох. ②Хэмжилтээр тоосны агууламж нь MNS-ын стандарт агууламжийг давсан байгаа тохиолдолд: Суурь нөхцөлтэй адил утгаар авах

**(4) Арга хэмжээнээс гарах үр дүн**

Суурь нөхцөл болон арга хэмжээ-11-ийн тухайд  $PM_{10}$ -ын ялгарлын хэмжээний графикыг Зураг 2.5-36-д үзүүлэв. Мөн суурь нөхцөл болон арга хэмжээ-11-д гарах ялгарлын тархалтыг Зураг 2.5-37-т үзүүлэв. Арга хэмжээнээс гарах ялгарлын бууралтын үр ашиг 1,121.11тон/жил байсан.

Мөн арга хэмжээ-11-ийн  $PM_{10}$ -ын агууламжийн тархалтын харьцуулалтыг Зураг 2.5-38-т үзүүлэв. Зураг дээр улаанаар тодруулсан талбайн mesh нь хамгийн их агууламжтай хэсэг байна. Арга хэмжээгээр Улаанбаатар хотын зүүн бүсэд УХЗ нягтрал ихээр байрласан газрын багахан хэсэгт өндөр агууламжтайгаас бусад хэсгийн ихэнх нь агууламж нэлээд их хэмжээгээр буусан байгааг харж болно.




	PM <sub>10</sub>
Суурь нөхцөл	1,307.00
Арга хэмжээ-11	175.89


Нэгж: тон/жил

**Зураг 2.5-36 Суурь нөхцөл болон арга хэмжээ-11-д үүсэх PM<sub>10</sub>-ын ялгарлын хэмжээ**





Зураг 2.5-37 Суурь нөхцөл болон арга хэмжээ-11-д гарах PM<sub>10</sub>-ын ялгарлын тархалтын хэмжээний харьцуулалт



Зураг 2.5-38 Суурь нөхцөл болон арга хэмжээ-11-д үүсэх PM<sub>10</sub>-ын агууламжийн тархалтын харьцуулалт

Суурь нөхцөл болон арга хэмжээний хувилбараар агууламжийн тархалтын загвараар хамгийн их агууламжтай газрыг Хүснэгт 2.5-27-д үзүүлэв. Нийт агууламж буурч нэлээд их хэмжээний бууралтын үр ашиг харагдаж байсан. Хамгийн их агууламж нь суурь нөхцөлөөс даруй 94.54%-иар буурсан.

**Хүснэгт 2.5-27 Суурь нөхцөл болон арга хэмжээ-11 дээр үүсэх байдлын загвараар гарах хамгийн их агууламж**

	Нэгж: $\mu\text{г}/\text{м}^3$	
	Суурь нөхцөл	Арга хэмжээ-11
PM <sub>10</sub>	33.71	1.84

Дээр үзүүлсэнчлэн УХЗ-ны тухайд MNS-ын стандартыг хангахын тулд галалгааны хяналтыг сайжруулах, циклон үнс баригч суурилуулах, өндөр АҮК-той УХЗ-аар шинэчлэх зэрэг арга хэмжээг авч хэрэгжүүлснээр томоохон хэмжээний үр ашиг бүхий агаарын бохирдлын эсрэг авах арга хэмжээ болж чадах найдлага төрүүлж чадаж байна.

**(5) Арга хэмжээний зардал**

Үйл ажиллагаа эрхлэгч талд зардлыг даалгах учраас төр засгийн талаас зардал гаргах шаардлагагүй.

**(6) Технологийн зохистой байдал-тогтолцоонд тулгарах асуудал**

Галалгааны хяналтын зарчимын тухай ойлголтыг УХЗ-тай холбоотой дүрс бичлэгийг ашигласан техникчийн сургалтаар дамжуулан боломжтой болно. Үүнтэй холбогдуулан тогтолцооны зөрчил байхгүй.

Циклон үнс баригч суурилуулаад байгаа УХЗ-нууд оршин байгаа тул технологийн хувьд боломжтой байгаа. Гэхдээ циклон үнс баригчийг суурилуулж байршуулах орон зайн асуудал болон циклон үнс баригч суурилуулснаас болж үүдэх даралтын алдагдлаас хамгаалах утаа сорогч суурилуулж тохиргоо хийх шаардлагатай. УХЗ-ны эзэмшигч өөрийн зардлаар циклон үнс баригчийг суурилуулах учраас тогтолцоонд зөрчил үүсэхгүй.

Өндөр АҮК-той УХЗ-аар шинэчлэх ажлыг Монголд улсад хоёр шаттай хөнгөлттэй зээл болон МСС-гийн зүгээс хэрэгжүүлж байгаа тул цаашид хэрэгжүүлэхэд технологийн хувьд боломжтой. Харин тогтолцоонд тулгарах асуудлын хувьд шинэчлэхээр сонгох УХЗ-ны өртөг өндөр учраас шинэчлэх ажлын хэрэгжилтэнд асуудал тулгарч байна.

**(7) Үйл ажиллагаа эрхлэгч-Төр захиргааны байгууллагын үүрэг оролцоо**

Ирээдүйд, үйл ажиллагаа эрхлэгч нь ялгарлын стандартыг мөрдөж ажиллах үүрэгтэй болох бөгөөд, тэр хүртэл галалгааны хяналтыг сайжруулах, циклон үнс баригч суурилуулах, өндөр АҮК-той зуух зэрэг нь үүний нэг арга хэмжээний шатлал юм. Төр захиргааны байгууллагын үүрэг оролцоо нь зуух бүртгэл, шалгалт, ялгарлын журмыг эрх тэгш байдлаар хэрэгжүүлэх явдал бөгөөд үйл ажиллагаа эрхлэгч нар арга хэмжээний зориулалттай тоноглол суурилуулалтын ажилд дэмжлэг үзүүлэх санхүүжилтийн тогтолцоо зэргийг судалж үзэх асуудал үүдэн гарна.

**(8) Арга хэмжээтэй холбоотой бусад асуудал**

Дээр дурьдсанчлан галалгааны хяналтыг сайжруулах, циклон үнс баригч суурилуулах, өндөр АҮК-той зуух зэрэг нь ялгарлын стандартыг мөрдүүлэх арга зам юм. УХЗ-ны шинэчлэлтэй холбоотой төсөл болон дээрх арга хэмжээнээс гарах үр ашигийг олж авах боломжтой болно.

**2.5.9.8 Арга хэмжээний зардалд харьцах үр ашиг**


6 арга хэмжээний зардалд харьцах үр ашгийг Хүснэгт 2.5-28-д үзүүлэв.

PM<sub>10</sub>-ын бууралтын хэмжээ, PM<sub>10</sub>-ын агууламжийн бууралтын үр ашиг, арга хэмжээний зардал, PM<sub>10</sub> бууралтын хэмжээ бүрт харьцах зардал гэсэн шалгуур үзүүлэлтийг чухалчлан үзэхээс хамааран эрэмбэлэх дараалал өөр өөр болно.

## Хүснэгт 2.5-28 Арга хэмжээний санал тус бүрийн зардал харьцах үр ашиг

Арга хэмжээний зардал	PM <sub>10</sub> -ын бууралтын хэмжээ (тон/жил)	Арга хэмжээний өмнө болон хойно хамгийн өндөр агууламжийн өөрчлөлт <sup>3</sup> мкг/м	Арга хэмжээний зардал	Арга хэмжээний байгууламжын ашиглагдах хугацаа жилээр (Төсөөлөл)	PM <sub>10</sub> -ын бууралтын хэмжээ 1тон тутамд зарцуулагдах жилийн зардал
1: УХЗ-ны төвлөрүүлэлт	563.38	33.71→6.00	8,440,000,000₮ (=₮496,470,000)	10	1,498,000₮ (₮88,000)
2: УХЗ-нд циклон үнс баригч суурилуулалт	813.59	33.71→11.04	428,000,000₮ (=₮25,180,000)	10	52,600₮ (₮3,100)
3: Гэрийн зуухны оронд УХЗ-аар халаалт түгээх	507.43	59.10→1.60	16,930,000,000₮ (=₮995,880,000)	10	3,336,000₮ (₮196,000)
4: ДЦС-3-ын тоосруулсан системээс БУШ-д шилжүүлэн өөрчлөх	2,943.51	9.37→3.31	92,000,000,000₮ (=₮5,411,760,000)	30	1,042,000₮ (₮61,000)
5: Үнсэн сангаас хийсэх шорооноос хамгаалах хашаа хаалт	953.45	17.30→3.46	223,140,000₮ (=₮13,130,000)	3	78,000₮ (₮4,600)
6: УХЗ-ны MNS-ын стандарт мөрдөлт	1121.11	33.71→1.84	0₮ ААНБ-ын зардал	-	0₮ (₮0)

Хөндлөн шугамд PM<sub>10</sub>-ын бууралтын хэмжээг босоо шугам дах зардал дээр харж, арга хэмжээний зардал багаас нь жагсаасан график Зураг 2.5-39 дээр байна. Энэ графикаас хэр зэрэг PM<sub>10</sub>-ыг бууруулах бэ, арга хэмжээний зардал хэдий хэмжээ хүртэл байлгах бэ гэдэгт судалгаа хийхэд хялбар болно.



Зураг 2.5-39 PM<sub>10</sub>-бууралтын хэмжээ болон арга хэмжээний зардалын хамаарал

### 2.5.10 Бүтэц бүрдүүлэлт

Тус төслөөр Х/Т болох НАЧА-д эрх мэдэл-хүчин чадлын хязгаар байна гэж үзсэн учраас дараа Х/Т-АХ-ийг нэмж байгуулан харилцан уялдаа холбоотой байлгахаар болгосон бөгөөд энэ харилцаа холбоог төслөөс дэмжлэг үзүүлж ирсэн болхоор төсөл дууссны дараа тогтвортой байдлын хувьд эргэлзээтэй хэвээр байгаа.

ЗБХТ шиг хотын даргын захирамж гарч бодитоор тогтолцоог хөдөлгөж эхэлсэн хэдийч эх үүсвэрийн инвентор-тархалтын загварчлалын хэрэгжилтэнд хамааралтай бүтэц шиг уялдаа холбооны боломжийн талаар хэлэлцэнгээ албажиж баталгаажаагүй зүйл байгаа.

ЗБХТ болон эх үүсвэрийн инвентор-тархалтын загварчлалын хэрэгжилтэнд хамааралтай бүтцийг харьцуулж системчлэх асуудалд дүн шинжилгээ хийнэ.

#### 2.5.10.1 Бүтэц бүрдүүлэх үйл ажиллагаа

ЗБХТ-г бүрдүүлэхэд хэрэгжүүлсэн үйл ажиллагааг Хүснэгт 2.5-29-д нэгтгэлээ.

**Хүснэгт 2.5-29 ЗБХТ-г бүрдүүлэхтэй холбоотой үйл ажиллагаа**

Хугацаа	Үйл ажиллагаа	Үр ашиг
2010 оны 6 сарын 25	ЗБХТ болон эх үүсвэрийн инвентортой холбоотой ажил хэргийн хуралдаан	Японы ЗБХТ-ны тухай мэдлэгийг эзэмшиж чадсан.
2010 оны 10 сарын 16~30 (15 өдөр)	БО-ны урдирдлагын менежментийн Японы сургалт	Сургалтын сэдэв болгож УБ хотын ЗБХТ-ны саналыг боловсруулсан.
2011 оны 1 сар	ЗБХТ-той холбоотой уулзалт	БО-ны удирдлагын менежментын Япон дах сургалтын суралцагчдыг голлосон ЗБХТ-нд хамааралтай хүмүүсийг цуглуулж уулзалт, семинарыг товловсон.
2011 оны 2 сарын 11	ЗБХТ-ны семинар	2011 оны өвлөөс ЗБХТ-г эхлүүлэх тал дээр санал нэгдсэн.
2011 оны 3 сар	ЗБХТ-г бүрдүүлэхтэй холбоотой албан бичиг	Семинар дээр тохиролцсон ЗБХТ-г бүрдүүлэх зөвлөмж гаргасан албан бичгийг НАЧА-ын дарга, ЛИСА олон улсын хамтын ажиллагааны зөвлөх мэргэжилтэн нарын гарын үсэгтэйгээр ЕМ Бат болон Хотын орлогч дарга Ганболд нарт өргөн барьсан.
2011 оны 8 сарын 2	ЗБХТ-нд хамааралтай хотын даргын захирамж	ЗБХТ-г УБ хотод албан ёсоор хүлээн зөвшөөрсөн.
2011 оны 9 сар	Үндэсний Статистикт бүртгүүлэх	Зуухны мэдүүлэгийн маягт үндэсний статистикийн хороонд албан ёсоор бүртгэгдэв.
2011 оны 9 сарын 21	Зуухны бүртгэлийн ажил хэргийн хуралдаан болон ЗБХТ-г танилцуулах уулзалт (Анхдугаар)	ЗБХТ-г эхлүүлсэн. Зуухны үйл ажиллагаа эрхлэгч нарыг цуглуулж шинээр үүсгэсэн ЗБХТ-г тайлбарлан танилцуулав.
2011 оны 9 сарын 23	ХЗХ-ны 3-дугаар хуралдаан	ЗБХТ-нд хамааралтай асуудлуудын тухай хэлэлцүүлэг явуулсан.
2011 оны 9 сарын 29, 10 сарын 4, 10 сарын 11	ЗБХТ-г танилцуулах уулзалт (2,3,4-дүгээр)	Дээрхтэй адил
2011 оны 9 сарын 29, 10 сарын 7 (үдээс өмнө-үдээс хойш)	Зуухны галчийн сургалт (Анхдугаар, 2,3 дугаар)	Зуухны галчийн сургалт явуулж батламж гардуулсан.
2011 оны 12 сарын 2	ХЗХ-ны 4 дүгээр хуралдаан	ЗБХТ-ны явц байдлын талаар тайлагнасан.

Эх үүсвэрийн инвентор боловсруулалт-тархалтын загварчлалын хэрэгжилтэнд хамаарах бүтэц бүрдүүлэх үйл ажиллагааны хэрэгжилтийг Хүснэгт 2.5-30-д нэгтгэсэн.

**Хүснэгт 2.5-30 Эх үүсвэрийн инвентор боловсруулалт-тархалтын загварчлалын хэрэгжилтэнд хамаарах бүтэц бүрдүүлэх үйл ажиллагааны хэрэгжилт**

Хугацаа	Үйл ажиллагаа	Үр дүн
2010 оны 6 сарын 25	Зуухны Бүртгэл-Зөвшөөрлийн тогтолцоо болон эх үүсвэрийн инвенторт хамааралтай ажил хэргийн хуралдаан	Эх үүсвэрийн инвенторын товч агуулгын тухай ойлголтын өгч чадсан.
2011 оны 3 сарын 4	Эх үүсвэрийн инвентор-тархалтын загварт хамааралтай ажил хэргийн хуралдаан	Эх үүсвэрийн инвенторын товч агуулгын тухай дахин тайлбарлахын зэрэгцээ тархалтын загварчлалын тооцооллын үр дүнг үзүүлсэн.
2011 оны 6 сарын 6, 7, 15, 23	Эх үүсвэрийн инвентор-тархалтын загварчлалын сургалт	Цагаар агаарын өгөгдөл, БО-ны өгөгдлийн дүн шинжилгээ, тархалтын загварчлалд оруулах өгөгдөл боловсруулах арга болон тархалтын загварчлалын дүнг үнэлэх аргын тухай анхаарах зүйлийн тухай сургалт явуулсан.
2011 оны 6 сарын 13	Эх үүсвэрийн инвентор-тархалтын загварчлалын сургалт	Тархалтын загварын дүнг үзүүлсэн зүйлийн нэг хэсэг, эх үүсвэрийн инвенторын боловсруулалт, эх үүсвэрийн өгөгдлийн нарийвчлалыг дээшлүүлэх нь гол асуудал. Мөн эх үүсвэрийн инвентор-тархалтын загвар боловсруулалтын тогтолцооны тухай илтгэл тавьсан.
2011 оны 10 сарын 16 оны ~29 (14 өдөр)	БО-ны удирдлагын менежментийн Япон дах сургалт	Япон дах АБ-оос хамгаалах арга хэмжээнд хэрэгтэй ялгарлын инвентортэй тархалтын загварчлалыг ашиглах аргачлалын тухай ойлголтыг гүнзгийрүүлж, түүнд тулгуурлан УБ хотын АБ-ыг бууруулах төлөвлөгөөний хэлэлцээр байгуулхын тулд НАЧА болон холбогдох байгууллагууд хэрхэн уялдаа холбоотой байх ёстой тухай авч үзэхийг зорилго болгосон сургалт явуулсан.
2012 оны 3 сарын 29	Х/Т-АХ-ийн 2 дугаар хуралдаан	Мэргэжилтэнгээс эх үүсвэрийн инвентор боловсруулсан дүн болон тархалтын загварчлалын дүнгийн тухай илтгэл тавьж техникийн зөвөлгөөн хийсэн. Мэргэжилтэнгээс холбогдох байгууллагын хамтын ажиллагааны бүтэцтэй хамааралтай схем -бүтцийн зургийг тайлбарлаж, онцгойлон



		эх үүсвэрийн инвентор боловсруулалт-тархалтын загварчлал хэрэгжүүлэхэд хамтран ажиллах бүтцийн тухай санал солилцож хэлэлцүүлэгийн үр дүнд эх үүсвэрийн инвентор, тархалтын загварчлал боловсруулан хэрэгжүүлэх хамтын ажиллагааны зохион байгуулалтыг судалж үзэхээр болсон.
2012 оны 6	2010 оны тархалтын загварчлал бүрдүүлэх	Эх үүсвэрийн инвенторын баталгаатай бус байдлыг анхааран үзэж хамгийн их, бага, мэргэжилтний дүгнэлт гэсэн 3 хувилбараар 2010 оны өвлийн тархалтын загварыг болосруулж гаргасан.
2012 оны 6 сарын 13	УХЗ-ны утааны хэмжилттэй АБ-ын прогноз тархалтын загварын зөвлөлдөх уулзалт	НАЧА болон УАЧА-нд дээр нэмээд ШУТИС болон МУИС-аас төлөөлөл оролцуулан техникийн хэлэлцүүлэг явуулсан.
2012 оны 9 асрын 14, 17, 25, 11 сарын 6	Эх үүсвэрийн инвентор-Тархалтын загварчлалын сургалт	Тархалтын загварчлалд оруулах өгөгдөл боловсруулах аргачлал мөн эх үүсвэрийн инвентор-тархалтын загварчлалын шинэчлэл, тархалтын загварын үр дүнгээр илэрхийлэх аргачлалын тухай сургалт явуулсан.
2012 оны 11 сарын 20, 23	Хөдөлгөөнт эх үүсвэрийн инвентортой холбоотой сургалт	Хөдөлгөөнт эх үүсвэрийн инвенторын шинэчлэлийн арга замын тухай тайлбарлаж, Microsoft Access дээр ажиллах аргачлал, мэдээллийн санг хадгалах байдал, тооцоолох аргачлал зэргийг тайлбарласан.
2012 оны 11 сарын 20	Бусад талбайн эх үүсвэрийн инвентортой холбоотой сургалт	Хэмжилтийн дүнг оруулж, хэмжилтийн өгөгдөлд үнэлгээ хийж, хийсэлтийн хэмжээг тооцоолсон дүнг нягталж үзсэн.

### 2.5.10.2 Үйл ажиллагаа болон бусад шалтгаануудын талаарх дүн шинжилгээ

ЗБХТ-ны бүрдүүлэлттэй эх үүсвэрийн инвентор боловсруулалт-тархалтын загварчлал хэрэгжүүлэх бүтэц бүрдүүлэх үйл ажиллагааг харьцуулалт хийснээр дараах зүйлсийг ойлгоно.

- Ерөнхийдөө урьд нь байсан хүмүүс төслийн эхний шатнаас үйл ажиллагаанд оролцоо сайтай хэрэгжүүлсэн
- Мөнтүүнчлэн 2010 оны 10 сард БО-ны удирдлагын менежментийн сургалтанд оролцсон суралцагчид голлон 2011 оны 1 сараас 3 сарын хооронд уулзалт хуралдаан, семинар, ЕМ болон

хотын орлогч даргад хүргүүлсэн албан бичиг болон тогтолцоонд шилжүүлэх зэрэгт хуучин хүмүүсийн оролцоо үр дүн өндөртэй байсан гэж бодож байна. Тогтсон тооны холбогдох хүмүүсийн жагсаалтын хамт ЕМ болон хотын орлогч даргад албан бичиг хүргүүлсэн нь 8 сарын хотын даргын захирамж гаргахад нөлөөлсөн гэж хэлж болно.

- Дараагийн хүний үйл ажиллагаа ч гэсэн мөн адил 2011 оны 10 сарын БО-ны удирдлагын менежментийн Япон дах сургалтын дараа Х/Т-АХ-ийн хуралдааныг зохион байгуулах зэргээр тогтолцоо бүрдүүлэлтэнд холбох санаатай байсан боловч хэт урт хугацаагаар сул орхисноос болоод энэ үйл ажиллагааны боломж алдагдсан. Энэ уулзалт хуралдаан зохион байгуулах хоорондын хугацаа сунасан нэг шалтгаан нь 2010 оны өвлийн тархалтын загварчлалыг гаргахад гол цагаа зарцуулсан явдал юм. Одоо ч гэсэн эх үүсвэрийн инвенторт нэлээд их тодорхой бус байдал үлдээд байгаа жишээлбэл РМ<sub>10</sub>-ын агууламжийн прогнозын утга нь бодит хэмжилтийн утгын тал хувийг тайлбарлах төдий байна. Мэргэжилтэнгээс тархалтын загварчлалын дүрслэлтийг дээшлүүлэхэд голлон анхаарснаас болж тархалтын загварын дүнг нийтэд дэлгэх тал дээр оройтуулсан зүйл байгаа. Тархалтын загварчлалыг оройтуулсан нь сургалтын хугацааг хойшлуулахад нөлөөлсөн. 2011 оны 6 сард туршилтын тооцооллыг ашиглан сургалт явуулсны дараа дахин сургалт явуулсан нь 1 жил хагасын дараа 2012 оны 9 сард байлаа.
- Эдгээрийг харьцуулж хэлэхэд ЗБХТ-ны эх сурвалж болох угааны хэмжилтийн технологи эзэмшүүлэлт нь төсөл эхэлсний дөнгөж дараа Япон дах сургалтаас эхлээд тогтмол сургалтуудыг хэрэгжүүлэн Х/Т болон Х/Т-АХ-ийнхэнд техникийн ур чадварыг дээшлүүлж чадсан. Х/Т болох НАЧА-гаас харьцангуй хурдан хугацаанд ЗБХТ-г дэмжих техникийн хамтын ажиллагааг тодорхой болгосон нь тогтолцоог бүрэлдүүлэхэд томоохон хүчин нөлөө болж чадсан гэж бодож байна.
- Мөнтүүнчлэн сүүлийн сургалт болон ажил хэргийн хуралдаанууд голлон эх үүсвэрийн инвентор болон тархалтын загварчлалын тенхик талд анхаарсан нь тогтолцооны бүрдүүлэлтэнд нөлөө үзүүлсэн байх магадлалтай.

Тогтолцооны бүрдүүлэлтэнд нөлөө үзүүлсэн гэх бусад шалгаанууд:


- ЗБХТ-ны хувьд зах зээлийн эдийн засагт шилжих үед орхигдож, эрчим хүчний хуулийн дагуу ашиглалтын зөвшөөрлийг зохицуулах Эрчим Хүчний Зохицуулах Хороо гэдэг байнгын бус байгууллага бий болсон. Түүний бүрэлдэхүүнд ЕМ (Ерөнхий Менежер), ИБХ, НМХГ багтдаг бөгөөд зуухны тоноглолын үзлэг шалгалтанд НАЧА-гаас хамтран оролцож TESTO гэдэг зөөврийн багажаар хэмжилт хийдэг байсан. Энэ байдалд 100kW дээш нийт зуухыг хамруулан шинэ тогтолцооны нэвтрүүлсэн болхоор тодорхой хэмжээгээр холбогдох байгууллагын зууханд хамааралтай ажил үүргийн суурь тогтсон байсан гэж болно.
- Цаашилбал ИБХ, НМХГ нь ЕМ-т, НАЧА нь хотын орлогч даргын мэдэлд хамаардаг байсан болхоор албан бичгийг аль алинд нь гаргаж өгсөн нь зөв тохирсон явдал байсан. Энэ утгаараа эх үүсвэрийн инвентор-тархалтын загварчлалыг боловсруулах тухайд НАЧА-тай хамтран ажиллахад тохиромжтой байгууллага ЦУОШГ болон УАЧА нь БОНХЯ-нд хамаарагдаж АБ-ын эсрэг арга хэмжээнд хамааралтай мэргэжлийн байгууллагын хувиар НАЧА-ны үүрэг бол БОНХЯ-наас тогтоосон агаарын тухай хуулиар зохицуулагдаж байгаа учраас тус яамны хамтын ажиллагааны бүтэц боловсруулалтанд зохицуулалт хийж өгөх хүсэлт гаргах нь зүйтэй байж ч болох талтай.
- Эцсийн шатны үнэлгээний хамтарсан үнэлгээний багийн ярилцлагаар бүтэц бүрдүүлэлтийн зохицуулалтыг АББҮХ-ноос хэрэгжүүлэх ёстой гэсэн санал гарч байсан.

### 2.5.10.3 Агаарын бохирдолд авах арга хэмжээг боловсруулах-хэрэгжүүлэх

Агаарын бохирдолд авах арга хэмжээг боловсруулж-хэрэгжүүлэх циклыг үзүүлсэн байдлыг Зураг 2.5-40-д үзүүлэв.

Агаарын бохирдолд авах арга хэмжээг хэрэгжүүлэх эх үүсвэрийн төрлөөс хамаарч арга хэмжээг боловсруулах болон хэрэгжүүлэх ажлыг хариуцагч байгууллага өөрчлөгдөнө гэж үзэж байна. УХЗ-ны ялгарлын журамлалт болон арга хэмжээг хэрэгжүүлэх тохиолдолд НАЧА, УАЧА-наас гадна ИБХ болон НМХГ зэрэг байгууллагуудын хамтын ажиллагаа шаардлагатай болно. Мөн арга хэмжээг боловсруулах үед урьдчилан уг арга хэмжээнээс гарах үр дүнг шинжлэх ухааны өгөгдөлд тулгуурлан тооцон гаргах ба арга хэмжээний хэрэгжилтийн дараа тухайн үр дүнг шалгаж үзэх шаардлагатай. Жишээлбэл: УХЗ-нд циклон үнс баригч суурилуулах гэж байгаа гэсэн тохиолдолд хэд хэдэн УХЗ-нд циклон үнс баригч суурилуулан түүнийхээ шүүлтийн хувийг утааны хэмжилтээр шалгаж үзсний дараагаар нийт арга хэмжээнд хамруулах зууханд суурилуулах ажлыг явуулах. Мөн тэрхүү арга хэмжээг хэрэгжүүлснээр агаар орчны агууламж хэр хэмжээний сайжирсан гэдгийг шалгаж үзэхийн тулд агаар орчны мониторингийн өгөгдөл болон тархалтын загварчлалыг ашиглах хэрэгтэй гэж үзэж байна.

Гэхдээ орчны агаарын агууламжийн сайжралтыг шалгаж үзэхэд хэд хэдэн шалтгаанаас болж нэлээд хүндрэлтэй байдаг. Шалтгаанын нэг нь тухайн арга хэмжээг хэрэгжүүлсэн эх үүсвэрээс гадна агаар бохирдуулах бодисын ялгарлын хэмжээ ихтэй эх үүсвэрүүд үлдсэн байх тохиолдолд орчны агаарын агууламжийн сайжралт хязгаарлагдмал болдог. Мөнтүүнчлэн орчны агаарын агууламж нь цаг агаарын байдлаас ихээхэн нөлөөлдөг учраас харьцуулалтыг хийх үедээ цаг агаарын байдлыг үргэлж харгалзан үзэх шаардлагатай. Иймээс арга хэмжээг хэрэгжүүлхийн тулд орчны агаарын сайжралтын байдлыг үнэлэхийн төлөө мониторинг төлөвлөгөөг боловсруулдаг байвал сайн байдаг.



Зураг 2.5-40 Агаарын бохирдолд авах арга хэмжээг боловсруулах-хэрэгжүүлэх цикл

### 2.5.11 Үндэсний санаачлагад хувь нэмэр оруулах

2.5.5-д үзүүлсэн АББҮХ болон EBRD-наас зохион байгуулагдсан хуралдаан дээр илтгэл танилцуулга хийсний дээр АББҮХ-ноос гаргсан хүсэлтийн дагуу МСС-аас зохион байгуулсан семинарт илтгэл тавьсан. Тэр илтгэлийн агуулга нь МСС-гаас шинэчилсэн УХЗ-ны РМ<sub>10</sub>-ын бууралтын үр дүнг үзүүлэх болон сайжруулсан зуухнаас тодорхой үр дүнг гарна гэж үзсэн ч гэсэн бусад эх үүсвэрийн нөлөөллөөс болж агаар орчингийн агууламжийн сайжралтын дүн мэдрэгдэхгүй болж байгааг илэрхийсэн явдал байлаа. (Хавсралт материал 2.5-4)

## 2.6 Чадавхийн үнэлгээний үр дүнгийн өөрчлөлт

### 2.6.1 Агаар бохирдуулах эх үүсвэрийн дүн шинжилгээ болон агаар орчны үнэлгээний чадавхи бүрдүүлэлт (Үр дүн-1)

#### 2.6.1.1 Суурин эх үүсвэрийн инвентор


Суралцагчдын суурин эх үүсвэрийн инвенторт хамаарах ур чадварын төвшинг Зураг 2.6-1 -д үзүүлэв. НАЧА-ны хувьд суурин эх үүсвэрийн инвенторт суралцах байдал доогуур байгаа бөгөөд НАЧА болон ЦУОШГ-ын хамтын ажиллагаагаар бие дааж суурин эх үүсвэрийн инвенторын шинэчлэлийн ажлыг хэрэгжүүлж чадахаар болсон.

НАЧА-ны хариуцагч болон ЦУОШГ-ын хариуцагчид эхний жилийн хэрэгжүүлсэн зуухны газруудаар биечлэн хийсэн судалгаагаар дамжуулан суурин эх үүсвэрийн инвентор болон ЗБХТ-нд шаардлагатай өгөгдөл цуглуулах талаар суралцсан.

Ажил хэргийн хуралдаан (2010 оны 6 сар, 2011 оны 3 сар, 6 сар), сургалт (2011 оны 6 сар)-аар ялгарлын инвентор боловсруулалт тухай бүрэн ойлгосон. 2011 оны 6 сарын ажил хэргийн хуралдаанаар эх үүсвэрийн инвенторын шинэчлэлийг зөвхөн бүртгэлийн мэдээллээр бүрдүүлж бүртгэлийн мэдээллээс бусад ялгарлын хэмжээг тооцоолох шаардлагатай гэдэг ойлголт дутагдалтай байгаа нь тодорхой болсон. Түүнээс хойш сургалтаар дамжуулан ялгарлын инвенторын тухай ойлгож, монгол дах эх үүсвэрийн инвенторыг бүрдүүлэх бүтцийн талаар идэвхитэй цанал солилцох болсон. Монгол талаас инвенторыг боловсруулах сонирхол дээшилж өгөгдөл цуглуулахаас эхлэн зуухны бүртгэлийн өгөгдөлд хяналт тавих зэргээр анхаарч эхэлсэн. УХЗ-ны өгөгдөл цугларах хүртэл нэлээд цаг хугацаа зарцуулсан боловч өнөөг хүртэл олж авсан туршлагадаа тулгуурлан цуурин эх үүсвэрийн инвентор боловсруулахад шаардлагатай өгөгдлийн чанарт хяналтанд анхаарал хандуулдаг болсон.

2012 оны 9 сар, 2012 оны 11 сард оролцогчдын (Participants) жагсаалтанд ороогүй холбогдох хүмүүсийг оролцуулсан нэлээд олон тооны суралцагчдыг хамруулан суурин эх үүсвэрийн инвенторын мэдээлэл шинэчлэлд сургах сургалтыг зохион байгуулсан. Үүний үр дүнд оролцогчид суурин эх үүсвэрийн инвентор боловсруулах чадварыг өндөр хувиар дээшлүүлж чадсан. Ялангуяа ЦУОШГ-ын оролцогчдын ур чадварын өсөлт мэдэгдэхүйц түвшинд хүрч инвенторыг бие даан шинэчлэх чадвартай болсон. Энэ удаагийн сургалтаар суурин эх үүсвэрийн инвентор боловсруулахад шаардлагатай өгөгдлийн чанарын хяналтанд анхаарал хандуулж чадахаар болсон бөгөөд цаашлаад ялгарлын инвенторын мэдээллийн шинэчлэлийн ажиллагаанд идэвхитэй оролцохоор зохион байгуулалттай болж чадсан.

ЭБЭХЯ-ны хариуцагч болон БОАЖЯ-ны хариуцагчид нь суурин эх үүсвэрийн инвентор боловсруулахаар техникийн ур чадвар эзэмшигч болж чадаагүй боловч цаашдаа арга хэмжээний хувилбарын сонголтын тухайд идэвхитэй оролцоно гэж найдвар тавьж байгаа.



Зураг 2.6-1 Суурин эх үүсвэрийн инвенторын ур чадварын түвшинд гарсан өсөлт


### 2.6.1.2 Хөдөлгөөнт эх үүсвэрийн инвентор

Зураг 2.6-2 -д Техникийн ур чадвар түвшингийн өсөлтийг үзүүлэв.

Ц. Мөнхбат (БОАЖЯ) нь ажил хэргийн хуралдаан оролцохоос өөрөөр техникийн ур чадварын түвшингийн өөрчлөлтийг тодорхойлох боломжгүй байсан учраас энэ зурагт оруулаагүй. Мөн Х/Т-АХ-ийн байгууллагад хамааралгүй боловч ажил хэргийн хуралдаан зэргээс техникийн ур чадвар эзэмшиж чадсан хүмүүсийн тухайд ур чадварын түвшингийн өсөлтийг тогтмол хугацаанд нягталж чадаагүй учраас энэ зурагт оруулаагүй. Нөгөөтэйгүүр Д. Өнөрбат (УАЧА) нь албан ёсоор оролцогч биш боловч 2011 оны 6 сараас хойш хөдөлгөөнт эх үүсвэрийн инвентор боловсруулах ажиллагаанд маш өргөн цар хүрээтэйгээр хамрагдаж ирсэн болхоор энэ зурагт оруулсан.

2011 оны 6 сарын ажил хэргийн хуралдаанаас хойш боломжийнхоо хэрээр Х/Т нь голлож ажилласан инвенторын мэдээлэл шинэчлэлтийг туршиж үзсэн. Хөдөлгөөний эрчмийн судалгаа, хөдөлгөөний хурдны судалгаа, Т/Х-ийн бүртгэлийн өгөгдөл, шатахууны хэрэглээний хэмжээ зэрэг өгөгдөл цуглуулалт боломжтой болсон.

Мөн 2012 оны 11 сарын ажил хэргийн хуралдаан зэрэгт оролцогчдыг хамруулан ЦУОШЛ, ИМН, АББҮХ, Цэвэр агаарын сан, Нийслэлийн нийтийн тээврийн газар, ТИС, Цахилгаан Тээвэр Компанийханд сургалт явуулсан. Ялангуяа ЦУОШЛ болон ИМН-гаас оролцогч нарын чадвар дээшилж, хөдөлгөөнт эх үүсвэрийн мэдээлийн шинэчлэл хийх түвшинд хүрсэн.




Зураг 2.6-2 Хөдөлгөөнт эх үүсвэрийн инвенторын ур чадварын түвшингийн өсөлт

### 2.6.1.3 Бусад эх үүсвэрийн инвентор

Зураг 2.6-3 -д техникийн ур чадварын түвшингийн өсөлтийг үзүүлэв. Алтанхуяг (БОАЖЯ) төслийн ажилд оролцох оролцоо бага, техникийн ур чадварын түвшингийн өсөлт тодорхойгүй учраас энэ зурагт оруулаагүй. НАЧА-ын хамтрагчаар 2 хүн байгаа боловч 1 хүн нь өмнө дурьдсан хөдөлгөөнт эх үүсвэрийн хариуцагчаар хамрагдаж байсан болхоор бусад эх үүсвэрийн техникийн ур чадвар эзэмшилтэнд бараг оролцоогүй тул уг хүний техникийн ур чадварын түвшингийн өсөлтөнд нөлөөлсөн гэж үзсэн. Үлдсэн 2 хүний тухайд газар дээрх судалгаа болон ажил хэргийн хуралдаанаар дамжуулан сайн боловсорч чадсан.

Ялгарлын хэмжээ ихтэй учраас ДЦС-ын үнсэн сангийн тухайд мэдээлэл цуглуулах болон газар дээрх хэмжилтийн ажилд Х/Т, цахилгаан станцын хариуцагч, орчуулагч нар байнга хамтран оролцсон. Мөн ажил хэргийн хуралдаан зэргээр тооцоолол болон сургалт явуулсан. 2012 оны хавраас НАЧА болон ДЦС нь Японы мэргэжилтэнгийн тусламжгүйгээр хэмжилтийг үргэлжлүүлж чадахаар болсон.



Зураг 2.6-3 Бусад эх үүсвэрийн инвенторын техникийн ур чадварын түвшингийн өсөлт


#### 2.6.1.4 Тархалтын загварчлал модель

Тархалтын загварчлалын ур чадварын түвшингийн өсөлтийг Зураг 2.6-4-д үзүүлэв. НАЧА-ны хувьд тархалтын загварт суралцах байдал доогуур байгаа бөгөөд НАЧА, ЦУОШГ болон УАЧА-ны хамтын ажиллагаагаар суурин эх үүсвэрийн инвенторын шинэчлэл болон тархалтын загварчлалын ажлыг хэрэгжүүлж чадахаар болсон.

НАЧА нь тархалтын загварчлалын ашиглалтын сургалтанд хамрагдаж байсан хэдий ч ашиглаж байсан туршлага бага. ЦУОШГ нь US-EPA загварыг ашиглан тархалтын загварчлал гаргаж байсан туршлагатай байсан болхоор загвар дээр ажиллах суурь онолын тухай ойлголттой байсан. Гэвч инвенторын өгөгдөлийн нарийвчлалын үнэлгээ болон загвар боловсруулахтай холбоотой мэдлэг туршлага дутагдалтай байсан учир загварын ерөнхий техникийн ур чадвар эзэмших шаардлагатай байсан.

Иймээс ажил хэргийн хуралдаан (2010 оны 6 сар, 2011 оны 3 сар, 2011 оны 6 сар), сургалт (2011 оны 6 сар)-аар оролцогчдын жагсаалтанд ороогүй байсан холбогдох хүмүүсийг оролцуулан олон тооны хүмүүст техникийн ур чадвар эзэмшүүлэх ажлыг хэрэгжүүлсэн. НАЧА болон ЦУОШГ-ын тухайд 2011 оны 9 сараас хойш ялгарлын инвенторын өгөгдөлийг ашиглан тогтмол чадвар эзэмшүүлэлтийн арга хэмжээ авч хэрэгжүүлэн үндсэн техникт сургасан. Гэвч сүүлийн үеийн өгөгдөлийг ашигласан ялгарлын инвенторын шинэчлэл болон тархалтын загварчлал боловсруулах хүртэл хийгдээгүй бөгөөд илүү сайн дадлагажуулж чадаагүй.

2012 оны 9 сар, 2012 оны 11 сард эх үүсвэрийн инвенторын шинэчлэл, тархалтын загварчлал боловсруулалт-тооцооллын үр дүнг ашиглах аргачлал (тархалтын зураг боловсруулалт болон уг зураг дээрх дүн шинжилгээ судалгаа) зэрэг чухал зүйлүүдийг онцгойлон сургалт явуулсан. Үүний үр дүнд суралцагчдын тархалтын загварчлал боловсруулах чадварт томоохон ахиц гарч, тархалтын загварын дүнг бие даан ашиглаж чадах хүмүүс нэлээд боловсрон гарсан.




Зураг 2.6-4 Тархалтын загварчлалын ур чадварын түвшингийн өсөлт

#### 2.6.2 Утааны хийн хэмжилт (Үр дүн- 2)

Сургалтанд хамрагдсан мэргэжилтний утааны хийн хэмжилтийн ур чадварын байдлыг Зураг 2.6-5-д үзүүлэв.



Сурч эзэмшсэн байдлыг 60-65%-иас дээш гэж дүгнэхэд мэргэшсэн байдлын хувьд тухайн хүн бие дааж ажиллах түвшинд хүрсэн гэж үзэж байгааг харуулах бөгөөд сургалтанд хамрагдсан хүн бүрийн чадвар нь бие даах чадавхи бүхий мэргэшсэн ажилтан гэж үзэхэд арай хангалтгүй байсан бөгөөд харилцан бие биедээ тусалж нөхөх байдлаар баг болж ажиллах түвшинд байсан.



**Зураг 2.6-5 Агаар бохирдуулагч суурин эх үүсвэрийн хэмжилт Мэргэжлийн чадавхийн ахиц**

Дараах байдлаар сургалтыг явуулсан болно.

Сургалт эхлэхээс өмнө оролцогчид нь ерөнхийдөө мэргэжлийн ур чадавхийн түвшин доогуур байсан. Харин ДЦС-IVийн мэргэжилтний хувьд бодит байдалд хэмжилт хийж байсан ажлын туршлагатай, мөн тоосны хэмжилтийг ч өөрсдийн хүчээр хийж болох багаж төхөөрөмжтэй, байгууллагын түвшинд чадавхийг эзэмшсэн байсан.

ДЦС-IV болон БОХЗТЛ—ын хувьд 1990-ээд оны үеэс утааны хийн хэмжилтийн техникийн ур чадавхийн тал дээр заавар дэмжлэг авсанаар багаж төхөөрөмжийн ажиллагаа, хэмжилтийн техникийн ур чадавхийг сурч эзэмшиж эхэлсэн юм. Мөн хэдэн жилийн өмнө ЖАЙКА-ын техникийн хамтын ажиллагааны хүрээнд ДЦС-IV –т хэмжилтийн 1 иж бүрдэл багаж төхөөрөмжийг нийлүүлж, холбогдох сургалтыг зохион байгуулж байсан юм. Харьяалагдах салбар хэлтэсийн мэргэжилтнүүд нь ажлын залгамж халаа болох залуу шинэ мэргэжилтэнд техникийн ур чадавхи, мэдлэг туршлагаа өвлүүлэн ирсэнээр тус станцын ажилтны мэргэжлийн чадавхийн түвшин бусад газартай харьцуулахад өндөр байдаг байна.

Төслийн эхний жил (2010 оны 7 сар, 8 сар) японд зохион байгуулагдсан сургалтын үеэр шаардлагатай мэдлэг, багаж төхөөрөмжийн ажиллагааны талаар зааж танилцуулсаны зэрэгцээ ажлын талбарт бодит хэмжилтийн дадлага, сургалтыг хэд хэдэн удаа зохион байгуулсан. Гэвч энэ чиглэлийн техникийн чадавхийг сурч эзэмшихэд цаг хугацаа ихээхэн шаардагдах тул тус сургалтаар холбогдох мэдлэг, ажиллагааны горимын зарим хэсгийг ойлгох төдий түвшинд хүрсэн юм. Мөн японы зуны бүгчим халуунд ажлын талбарт хэмжилт хийхэд биеийн тамир тэнхээ дутагдаж ядрах байдал ч харагдаж байсан.

2010 оны 9 сард ДЦС IV дээр бодит хэмжилт хийх сургалт, дадлагыг явуулсан бөгөөд японд явагдсан сургалтаас сурч мэдсэн мэдлэг, ажиллагааны дадлага туршлагаа ашиглаж, сурсан зүйлээ сэргээж давтах маягаар явагдсан тул сургалтанд оролцогчдын хувьд маш хурдан сурч дадлагжиж байсан.

Сургалтын дүнд ДЦС IV-ийн 2 ажилтнаас бусад оролцогч мэргэжилтний хувьд бие дааж өөрсдөө хэмжилтийг хийх чадвартай хүн байхгүй байсан хэдий ч оролцогчдын тал хагас нь анхан шатны түвшингээс дунд шатны түвшинд ойртсон гэж үнэлэгдсэн байна.

Төслийн эхний жилийн өвөл (2010 оны 11 сар~2011 оны 3 сар) хийгдсэн утааны хийн хэмжилтийн үеэр ур чадавхийн ахиц бага байсан нь энэ үеэр шинээр сурч тогтоосон зүйл цөөн, ажиллагааг дахин давтах замаар хэмжилтийн ажилд дасаж бүрэн дадлагажиж, алдаа гаргах нь багассан.

Дараа нь үргэлжлээд 2011 оны 5 сард уусмалын аргаар анализ шинжилгээ хийх талаар сургалт явагдахад оролцогчдын дотроос хэдэн хүний сурч эзэмшсэн байдал 50%-д хүрсэн бөгөөд ажиллагааны дадлага, практикийг хийхээс илүү өгөгдлийн зөв бурууг таниж мэдэх чадавхийг эзэмших нь чухал болохыг ойлгож мэдсэн.

Төслийн 2 дахь жилийн өвөл (2011 оны 11 сар~2012 оны 2 сар)-ийн утааны хийн хэмжилтэнд автомат төхөөрөмжийг ашиглах боломжтой болж, энэ чиглэлийн сургалтыг зохион байгуулсанаар төхөөрөмжтэй ажиллах арга барилыг сурч эзэмшсэн. Эхний жилийн сургалтаар механик ажиллагаатай төхөөрөмж дээр ажиллаж сурсанаар үндсэн мэдлэг, ойлголтийг авсан байсан учраас автомат төхөөрөмжийн ажиллагааг хурдан сурч эзэмшиж чадсан. УХЗ-ны бодит хэмжилтэнд ДЦС-аас оролцох хүн (гадагш гарах зөвшөөрөл авахад бэрхшээлтэйн улмаас ) цөөхөн байсан тул хяналт-шинжилгээний талын мэргэжилтнүүд оролцож тодорхой хэмжээгээр ур чадавхиа ахиулсан. Гэвч урьдын адил өгөгдлийн зөв буруу, алдаатайг мэдэж дүгнэх чадавхи, өгөгдлийг боловсруулах, үүссэн асуудлыг шийдвэрлэх чадвар зэргийг цаашид сайжруулах шаардлагатай байсан тул 2012 оны 5 сард өгөгдлийг боловсруулах , тооцооллын sheet буюу хуудсыг ашиглах аргын талаар сургалт явуулсан.

2012 оны 9, 11 сард хэмжилтийн зааварчилгааг боловсруулах талаар сургалт явуулсан бөгөөд тус сургалтын зорилго нь хэмжилтийн ажиллагааны цогц процессыг дахин бататган ойлгуулж, хараахан ойлгож чадаагүй зүйлийг нөхөж тайлбарлан заах, буруу ойлголт авсан зүйлийг засаж зөвөөр ойлгуулах зэрэг явдал байсан.

### **2.6.3 Ялгарлын хэм хэмжээг журамлах НАЧА-ны хяналтын чадавхийг бэхжүүлэх (Үр дүн-3)**

Үр дүн-3-ыг хариуцсан ажилтан хүүхэд төрүүлэн амралт авсан болон Батсайхан дэд даргын хэсэг хугацаанд ажлаас чөлөөлөгдсөн зэргээс хамааран хэд хэдэн удаа хариуцагч өөрчлөгдсөн бөгөөд одоо хариуцан ажиллаж буй Галымбек мэргэжилтэн нь тус албанд 2011 оны 9 сараас орж ажиллаж эхлээд байгаа юм. Мөн томоохон эх үүсвэрийн улсын нэгдсэн тоо бүртгэлийг хэрэгжүүлэх ажилтай төслийн үйл ажиллагааг уялдуулах шаардлагатай байсан учраас НАЧА-ны мэргэжилтэн Цацралыг Х/Т болгож, холбогдох техникийн ур чадавхийг эзэмшүүлсэн юм.

Үр дүн-3 үйл ажиллагааны хувьд зуухны бүртгэлийн тогтолцоог бий болгож, нэвтрүүлэхтэй холбогдсон захирамж гаргуулах, холбогдох зөвшөөрөл авах зэрэг ажлыг шат дараалан хийхэд ихэнх хугацаа зарцуулагдсан. Тус ажлыг хариуцагч ажилтан нь зуухны бүртгэлийн мэдээллийн санг боловсруулах, тус мэдээллийн санг томоохон эх үүсвэрийн улсын нэгдсэн тоо бүртгэлийн мэдээллийн сантай уялдуулан программчлах ажлыг мэдээлэл технологийн үйлчилгээ үзүүлэгч байгууллагад захиалгаар хийлгэх, зохион байгуулах, хянах ажлыг хариуцах тул тухайн мэргэжилтнийг программчлал хийгдэх ажлын урсгал, захиалгын хяналтын талаар ойлголттой болгох зорилгоор холбогдох лекцийг явуулсан.

Хэрэглэгч (болон захиалагч тал)-аас харахад шинээр бий болгох системийн тодорхойлолт, захиалагч болон гүйцэтгэгч талын ажил үүргийн хувиарлалт, программчлах ажлын үйлдэл, холбогдох бичиг баримтыг боловсруулах зэргийн талаар зааж тайлбарласан. Мэдээлэл технологийн чадварлаг ажилтан энэ салбарын мэдлэг ойлголт муутай захиалагч талтай ажиллах, мэдээлэл технологийн мэргэжилтэн

боловч ажлаа сайн мэдэхгүй гүйцэтгэгч тал байх зэрэг тохиолдолд хийх шаардлагатай болдог ажлын талаар 2 тал нэгдсэн ойлголттой болохын тулд ашиглах хэрэгсүүрийг бодит жишээгээр тайлбарласан. Тус сургалтын талаар Х/Т-ын өгсөн үнэлгээг дараах хэсэгт үзүүлсэн бөгөөд мэргэжилтэн Цацралын хувьд томоохон бохирдуулах эх үүсвэрийн улсын нэгдсэн тоо бүртгэлийн мэдээллийн сангийн

программыг захиалгаар хийлгэх ажлыг хариуцаж байсан болохоор энэ талаарх ойлголт сайтай байсан.

Ойлголт	Хангалттай ойлгосон.	1
	Ерөнхийдөө ойлгосон	2
	Сайн ойлгоогүй	3
Ажил үүрэгт хэрэг болох эсэх (ашиглах)	Хэрэг болно	А
	Бага зэрэг хэрэг болно	В
	Бараг хэрэг болохгүй	С

Асуулт	Галымбек		Цацрал	
	Ойлголт	Ашиглалт	Ойлголт	Ашиглалт
Программчлах ажлын процессын талаар	2	В	1	А
Программчлах ажлыг захиалагч болон гүйцэтгэгч талын ажлын хувиарлалт	2	В	1	А
Программыг захиалах үед анхаарах зүйлсийн талаар	2	В	1	А
Захиалагч тал болон гүйцэтгэгч тал нь зохион бүтээх программын талаар нэгдсэн ойлголттой болоход ашиглах хэрэгсүүрийн талаар (ER зураг, мэдээллийн сангийн хүснэгтийн тодорхойлолт, ажлын үйлдэл дарааллын схем зураг)	2	В	2	А
2011 оны зуухны бүртгэлийн өгөгдлийг ашиглах, өгөгдөл оруулахад үүсэж болох асуудал, цаашид мэдээллийн сантай ажиллах талаар	2	В	1	А
Зуухны бүртгэлийн мэдээллийн санд оруулахаар төлөвлөж буй анализ шинжилгээ хийх функцийн талаар	2	В	1	А
Томоохон бохирдуулах эх үүсвэрийн улсын нэгдсэн тоо бүртгэлийн системтэй уялдуулах талаар	2	В	1	А

#### **2.6.4 Агаар бохирдуулах эх үүсвэрт авах арга хэмжээ (Үр дүн-4)**

##### **2.6.4.1 Агаарын бохирдлын эсрэг авах арга хэмжээ**

Зуухнаас үүдэлтэй агаарын бохирдлыг бууруулах арга хэмжээний хувьд НАЧА-нд холбогдох ур чадавхийг эзэмшүүлж байгаа хэдий ч арга хэмжээний техникийн ур чадавхийн тал дээр дэмжих, хамтран ажиллах байгууллага шаардлагатай байгаа тул ШУТИС-ийн Эрчим хүч, Инженерийн сургууль нь хамтран ажиллахад тохиромжтой байгууллага гэж үзэж байгаа юм. НАЧА-ны мэргэжилтэн болон их сургуулийн судлаач, холбогдох мэргэжлийн хүмүүстэй хамтран ажилласнаар авах арга хэмжээг удирдан зохион байгуулах, хэрэгжүүлэх боломжтой болох юм.

Хэт авианы зарцуулалт хэмжүүр болон өгөгдөл цуглуулагч зэрэг хэмжилтийн багаж хэрэгсэлтэй ажиллах талаарх ойлголт, мэдлэгийг гүнзгийрүүлж чадсан тул цаашид эдгээр тоног төхөөрөмжийг монгол талд шилжүүлэн өгсөнөөр шаардлагатай үед их сургуулийн холбогдох газрууд ч ашиглах боломжийг бүрдүүлэх нь чухал юм.

ДЦС-ын холбогдох хүмүүсийн хувьд зуухны ажиллагааны хяналтыг өөрснөө бие даан хийх хангалттай мэдлэг, туршлагатай хэдий ч ДЦС-ын агаарын бохирдлын эсрэг авах арга хэмжээний хувьд боловсон хүчний техникийн ур чадавхи гэхээс илүү элэгдэж муудсан тоног төхөөрөмжийг шинэчлэх зэрэг арга хэмжээг хэрэгжүүлэхэд шаардагдах хөрөнгө, мөнгөний тал дээр асуудалтай байдаг гэж үзэж байна.

Мөн төслийн хүрээнд УХЗ-ны галч болон хариуцагч ажилтанд зориулан зуухны зөв галлагаа, ажиллагааг сайжруулах талаар видео хичээлийг боловсруулан бэлтгэж 2012 оны 4 сард холбогдох хүмүүст үзүүлж санал бодлыг нь аван дахин сайжруулан янзалж, 10 сард видео хичээлийг бэлэн болгосон бөгөөд зуухны үйл ажиллагааны холбогдох хүмүүст үзүүлсэн нь өндөр үнэлгээ авсан.

Х/Т-ын зуухны техникийн чадавхийн түвшингийн ахицыг Хүснэгт 2.6-1 болон Хүснэгт 2.6-2-д үзүүлэв.

**Хүснэгт 2.6-1 ДЦС-ын зуухтай холбоотой мэргэжлийн чадавхийн ахиц**

Мэргэжлийн ур чадавхийн үзүүлэлт			НАЧА			ДЦС-2			ДЦС-3			ДЦС-4		
			Эх. Өмнө	Явц	Дуусах үе	Эх. Өмнө	Явц	Дуусах үе	Эх. Өмнө	Явц	Дуусах үе	Эх. Өмнө	Явц	Дуусах үе
1. ДЦС-ын зууханд авах арга хэмжээ	Суурь мэдлэг	Шаталтын урвалын талаарх ойлголт	4	5	5	4	5	5	4	5	5	4	5	5
		Уурын хүснэгтийг ашиглах арга (ханасан уурын хүснэгт, хэт халсан уурын хүснэгт)	4	5	5	4	5	5	4	5	5	4	5	5
		Зуухны дулааны балансыг тооцоолох аргын ойлголт	4	5	5	4	5	5	4	5	5	4	5	5
		Зуухны АҮК-ийн байнгын хяналтын талаарх ойлголт	4	5	5	4	5	5	4	5	5	4	5	5
	Өгөгдөл цуглуулалт	Утааны хий O2 тооцоо, лазерь термометр,термопарын хэрэглээ	4	5	5	4	5	5	4	5	5	4	5	5
		Утааны хий O2 тооцоо, лазерь термометр,термопарын ажиллагааны заавар	3	5	5	3	5	5	3	5	5	3	5	5
		Хэмжилтийн төлөвлөгөөг боловсруулах аргын талаарх ойлголт	4	4	4	3	4	4	3	4	4	3	4	4
		Хэмжилтийн төлөвлөгөөг боловсруулахад анхаарах зүйл (ажиллах тавцан, СО хордлого, хий алдах үеийн аюулгүйн арга хэмжээ)	4	5	5	4	5	5	4	5	5	4	5	5
	Арга хэмжээний судалгаа	Ерөнхий арга хэмжээ (Утааны хийгээр алдагдаж буй дулааныг багасгах арга : Агаарын харьцаа, агаар халаагч зэрэг)	4	5	5	4	5	5	4	5	5	4	5	5
		Дулааны балансаас шалтгаалах арга хэмжээний үр дүнг тооцоолох арга	4	4	4	4	4	4	4	4	4	4	4	4
		Арга хэмжээг судлахад анхаарах зүйлсийн талаарх ойлголт (хөдрөх цэг зэрэг)	3	4	4	3	4	4	3	4	4	3	4	4
		Утааны орчны бохирдолд авах арга хэмжээ (тоос, SOX, NOX) -ний талаарх мэдлэг	4	5	5	4	5	5	4	5	5	4	5	5

**Хүснэгт 2.6-2 УХЗ-тай холбоотой мэргэжлийн чадавхийн ахиц**

Мэргэжлийн ур чадавхийн үзүүлэлт			НАЧА			ХЗАЗГ			ИБХ			ШУТИС 1			ШУТИС 2			Төмөр зам		
			Эх. Өмнө	Явц	Дуусах үе	Эх. Өмнө	Явц	Дуусах үе	Эх. Өмнө	Явц	Дуусах үе	Эх. Өмнө	Явц	Дуусах үе	Эх. Өмнө	Явц	Дуусах үе	Эх. Өмнө	Явц	Дуусах үе
2. УХЗ-нд авах арга хэмжээ Үйлдвэрийн уурын зууханд авах арга хэмжээ	Суурь мэдлэг	Шаталтын урвалын талаарх ойлголт	4	5	5	4	4	4	4	4	4	5	5	5	5	5	5	4	4	4
		Уурын хүснэгтийн утгын талаарх ойлголт (ханасан уурын хүснэгт)	4	5	5	4	4	4	4	4	4	5	5	5	5	5	5	4	4	4
		Зуухны дулааны балансын талаарх ерөнхий ойлголт	4	5	5	4	4	4	4	4	4	5	5	5	5	5	5	4	4	4
	Өгөгдөл цуглуулалт	Утааны хий O2 тооцоо, лазерь термометр,термопарын хэрэглээ	4	5	5	4	5	5	4	5	5	5	5	5	5	5	5	4	5	5
		Утааны хий O2 тооцоо, лазерь термометр,термопарын ажиллагааны заавар	4	5	5	3	4	4	3	3	3	4	5	5	4	5	5	3	4	4
		Хэмжилтийн төлөвлөгөө боловсруулах арга	4	4	4	3	4	4	3	3	3	4	5	5	4	5	5	4	4	4
		Хэмжилтийн төлөвлөгөөг боловсруулахад анхаарах зүйл (ажиллах тавцан, СО хордлого, хий алдах үеийн аюулгүйн арга хэмжээ)	4	5	5	3	5	5	3	4	4	3	4	4	3	4	4	5	5	5
	Арга хэмжээний судалгаа	Ерөнхий арга хэмжээ (Утааны хийнд алдагдах дулааныг багасгах арга : Агаарын харьцаа, агаар халаагч зэрэг)	4	5	5	4	5	5	4	5	5	5	5	5	5	5	5	4	5	5
		Галын хотлын үлээлтийг хянах тухай гол ойлголт	4	5	5	4	5	5	4	5	5	5	5	5	5	5	5	4	5	5
		Гинжин хэлбэрийн АҮК-ийн ялгаа (нүүстөрөгчийн дутуу шаталтаас үүсэх алдагдал)	3	4	4	3	4	4	4	4	4	4	4	4	4	5	5	3	4	4
		Арга хэмжээг судлахад анхаарах зүйлсийн талаарх ойлголт (хөдрөх цэг зэрэг)	3	4	4	3	4	4	4	4	4	5	5	5	5	5	5	3	4	4
		Утааны орчны бохирдолд авах арга хэмжээ (тоос, SOX, NOX) -ний талаарх мэдлэг	4	5	5	5	5	5	5	5	5	5	5	5	5	5	5	4	5	5

#### **2.6.4.2 Эрчим хүч, дулаан хэмнэлт**

НАЧА-ны тус салбарыг хариуцсан мэргэжилтнээс гадна ВЕЕС буюу Барилгын эрчим хүч хэмнэлтийн төв (ШУТИС-ийн харьяа)-ийн хариуцсан ажилтан ЭХДХ-ийн оношлогоо, холбогдох техникийн ур чадавхийн талаарх лекц, сургалтанд идэвхтэй оролцож, ерөнхийдөө ур чадавхийн түвшин нэлээд ахиж сайжирсан гэж үзэж байна.

НАЧА-ны хариуцсан мэргэжилтний хувьд дээрх үйл ажиллагаанд идэвхтэй оролцож, техникийн ур чадавхийн түвшин ахисан боловч урьд нь сурч, ажилласан байсан чиглэл, ажлын туршлагаас нь харахад ЭХДХ-ийн оношлогоог бие даан хийж чадах түвшинд хараахан хүрээгүй байгаа тул цаашид монгол дахь ЭХДХ-ийн салбарыг хөгжүүлэх өнөөгийн шаардлага, ач холбогдлын үүднээс УБ хотын агаарын бохирдлыг бууруулах, хамгаалах арга хэмжээтэй холбогдуулан энэ салбарын техникийн ур чадавхи, мэдлэг ойлголтыг сайтар ашиглах нь чухал байгаа юм.

Мөн бас нэг чухал зүйл нь ЭХДХ-ийн оношлогооны техникийн ур чадавхийг эзэмшүүлэхийн зэрэгцээ төслийн хүрээнд нийлүүлэгдсэн оношлогооны зориулалтын хэмжигч багаж хэрэгслийг цаашид хэрхэн ашиглах асуудал байгаа бөгөөд үйлдвэрүүд дээр хийгдсэн оношлогоо, мөн ажил хэргийн хуралдааны үеэр эдгээр багаж хэрэгслийг НАЧА нь хариуцан ажиллах боловч шаардлагатай тохиолдолд холбогдох байгууллагууд авч хэрэглэх боломжтой болохыг тайлбарласан болно.

#### **2.6.5 Байгаль орчны хяналт, удирдлагын чадавхи (Үр дүн-5)**

Байгаль орчны хяналт, удирдлагын чадавхийн хувьд техникийн болон хяналт удирдлагын нэгдсэн ур чадварын хэлэх бөгөөд тухайлбал, тодорхой нэг ур чадавхийн үнэлгээнээс өөр гэж үзэх юм. Нэг үнэлгээний шалгуур үзүүлэлт гэдэг нь төслийн үйл ажиллагааг хэрэгжүүлсэнээр агаарын бохирдлын эсрэг авах арга хэмжээний хяналт, удирдлагатай холбоотой бүтэц, зохион байгуулалтын тогтолцоог бүрдүүлж чадсан уу үгүй юу гэдэг зүйл байж болох юм. Бүтцийн тогтолцоог бий болгож чадсан эсэх гэдэг талаас авч үзэх тохиолдолд, тухайн боловсон хүчний харьяалагдах байгууллагын ажлын эрх үүрэг, чадавхи, шийдвэр гаргагч түвшиний албан тушаалтаны хамтын ажиллагааны байдал, хэмжээ нөлөөлдөг. Иймээс байгаль орчны хяналт, удирдлагын чадавхийн үнэлэмжийн хувьд тухайн байгууллага бүрийн боловсон хүчин, бүтэц зохион байгуулалтыг хамтад нь нийлүүлэн үнэлгээ өгдөг байна.

Мөн 2010 оны 3 сард эхлэн 2013 оны 3 сард дуусахаар төлөвлөж буй 3 жилийн төслийн хугацаанд төрийн эрх баригч нам солигдсон явдал нь ялангуяа байгаль орчны хяналт, удирдлагын салбарын чадавхийг сайжруулахад нөлөөлсөн гэж үзэж байна. 2012 оны 6 сард төслийн ерөнхий дарга болох үйлдвэрлэл, экологийн асуудал хариуцсан орлогч дарга өөрчлөгдөн, шинэ дарга томилогдсон бөгөөд цаашид тус шинэ орлогч дарга нь төслийн даргын үүргийг үргэлжлүүлэн хийж байсан боловч орон нутгийн сонгуулийн дүнд 12 сард дахин шинэ хүн орлогч дарга болсон. Төслийн менежер бөгөөд хамтрагч тал болох НАЧА-ны даргын хувьд 2012 оны 6 сард явагдсан сонгуулийн дараа ажлаасаа чөлөөлөгдсөн боловч 12 сар буюу өнөөг хүртэл шинэ дарга томилогдоогүй тус албаны дэд дарга нь даргын үүргийг орлон гүйцэтгэж байгаа юм.

##### **2.6.5.1 Нийслэлий Агаарын чанарын алба (НАЧА)**

Төслийн хамтрагч тал болох НАЧА-ны хувьд дэд дарга Ч. Батсайхан хэсэг хугацаанд ажлаасаа чөлөөлөгдсөн байсан боловч төсөл хэрэгжилтийн хугацаанд голлох үүрэг гүйцэтгэж байсан. Төсөл эхэлсэн үеэс утааны хийн хэмжилт, эх үүсвэрийн инвентор, тархалтын загварчлал гэсэн ажлууд, мөн тэдгээрийг ашиглан агаарын бохирдлыг бууруулах арга хэмжээг хэрэгжүүлэх талаар судлах талаар бараг ойлголт мэдлэггүй байсан.

Дараа нь 2010 оны 10 сард японд зохион байгуулагдсан байгаль орчны хяналт, удирдлагын менежментийн сургалтаас 2011 оны зуухны бүртгэл, хяналтын тогтолцоог бүрдүүлж, нэвтрүүлэх ажлыг хийснээр агаарын бохирдлын эсрэг авах арга хэмжээний тогтолцоог бүрдүүлэхэд голлох үүрэгтэй оролцож ажилласан бөгөөд 2012 оны 12 сард мөн япон зохион байгуулагдсан сургалтанд хамрагдсанаар хэрэгжүүлэх арга хэмжээг судлах явц, тэдгээрийн эргэх холбооны талаар ойлгон мэдэж, холбогдох байгууллагатай санамж бичиг байгуулах зэрэг тодорхой үйл ажиллагааг явуулахаар төлөвлөж байна.

НАЧА-ыг бүтэц, зохион байгуулалтын талаас нь авч үзвэл, төслийн явцын үнэлгээний үеэр яригдаж байсанчлан мэргэжлийн шинж чанар багатай ажил хийхээс аргагүй байдалд байгаа ч утааны хийн хэмжилтийн ур чадавхийг ашиглан агаарын бохирдлыг бууруулах арга хэмжээг судлан үнэлгээ хийж, зуухны бүртгэл, хяналтын тогтолцоо болон бохирдуулах эх үүсвэрийн улсын нэгдсэн тоо бүртгэл зохион байгуулах зэрэг ажилд тодорхой үүрэг оролцоотой байх зэргээр байгууллагын хэмжээнд үйл ажиллагааны түвшингээ илэрхий ахуилан сайжруулж байна.

Гэвч урьдчилсан судалгааны үеэс тус албаны дарга 2 удаа өөрчлөгдөж, Батсайхан даргыг залгамжлах менежерийг бэлтгэх зэрэг байгууллагатай холбогдох байгаль орчны хяналт, удирдлагын чадварын асуудлыг цаашид шийдвэрлэх ёстой байна.

#### **2.6.5.2 Цаг уур орчны шинжилгээний газар болон Улсын Агаарын чанарын мэргэжлийн алба (ЦУОШГ/УАЧМА)**

ЦУОШГ-ын мэргэжилтэн Энхмаа нь төслийн урьдчилсан судалгааны ажлын үеэс төсөл хэрэгжилтийн хугацааны туршид нягт хамтран ажиллахын зэрэгцээ төслийн явцын болон эцсийн шатны үнэлгээний монгол талын үнэлгээний ажилтанаар ажилласан тул тус төслийг цогцоор нь сайн ойлгож, техникийн ур чадавхи эзэмших тал дээр ч үр дүнтэй байсан гишүүдийн нэг юм.

ЦУОШГ, УАЧМА болон БОХЗТЛ-ийн мэргэжилтэн, ажилтанууд нь эх үүсвэрийн инвентор, тархалтын загварчлал боловсруулалт (Үр дүн-1), байгаль орчны хяналт, удирдлагын менежмент (Үр дүн-5)-тэй холбоотой үйл ажиллагаанаас гадна утааны хийн хэмжилтийн сургалтанд оролцож байсан бөгөөд эх үүсвэрийн инвентор, утааны хийн хэмжилт (Үр дүн-2)-ийн ажилд идэвхтэй оролцсон.

Мэргэжилтэн Энхмаагийн хувьд төсөлтэй хамтран ажиллахаас өмнө эх үүсвэрийн инвентор боловсруулах ажлын туршлагатай байсан хэдий ч тэр үед боловсруулж байсан эх үүсвэрийн инвентор нь одоогийн ЦУОШГ болон УАЧМА-ны боловсруулж буй томоохон эх үүсвэрийн улсын нэгдсэн тоо бүртгэлийн ажилтай харьцуулахад хангалтгүй байдалтай байсан. Мөн төслийн эхний үед явагдсан сургалтанд “эх үүсвэрийн инвентор” болон “зуухны бүртгэлийн мэдээллийн сан” гэсэн 2 өөр ойлголтыг ялгахгүй байх тохиолдол ч байсан. Гэвч одоо эдгээрийн талаар хангалттай мэдлэгтэй болсоны дээр эдгээр зүйлийг агаарын бохирдлын эсрэг авах арга хэмжээг судлах, үнэлгээ хийхэд ашиглах талаар сайтар ойлгож мэдсэн. Мөн УАЧМА-ны дэд дарга зэрэг удирдах дээд албан тушаалтаны түвшинд ч төслийн үйл ажиллагааг ойлгож, дэмжин ажиллаж ирсэн юм.

УАЧМА-ны мэргэжилтэн Нямдаваа нь төсөл хэрэгжилтийн дунд үеэс төслийн үйл ажиллагаанд оролцох болж, эх үүсвэрийн инвентор, тархалтын загварчлалыг боловсруулах ажилд идэвхтэй оролцож ирсэн. Мөн Нямдаваа нь төслийн хүрээнд 3 дах жилээ японд зохион байгуулагдсан байгаль орчны хяналт, удирдлагын менежментийн сургалтанд оролцож, агаарын бохирдлын эсрэг авах арга хэмжээг судлах, холбогдох ажлын эргэх холбоог тодорхойлон гаргах талаарх хэлэлцүүлэгт голлох үүрэгтэйгээр оролцож байсан.

Мөн томоохон эх үүсвэрийн улсын нэгдсэн тоо бүртгэлийн ажлыг хариуцан ажиллаж байгаа бөгөөд тус бүртгэлийн ажлыг НАЧА-ны зуухны бүртгэлийн мэдээллийн сантай уялдуула талаар ажиллаж байна.

Үүнээс дүгнэхэд ЦУОШГ болон УАЧМА нь төслийн үйл ажиллагаанд оролцож хамтран ажилласнаар байгууллагын хувьд байгаль орчны хяналт, удирдлагын менежментийн талаарх ойлголт, мэргэжлийн ур чадавхиа ихээхэн сайжруулсаны дээр НАЧА-тай уялдаа холбоотой хамтран ажиллах болсоны зэрэгцээ цаашид агаарын бохирдлыг бууруулах арга хэмжээг судлах, санал боловсруулах, үнэлгээ хийх ажилд чухал үүрэгтэй оролцох байгууллага юм.

### **2.6.5.3 Хотын хөгжлийн бодлогын хэлтэс (ХХБХ)**

ХХБХ –ын мэргэжилтэн Цогтсайхан нь төслийн урьдчилсан судалгааны ажлын үеэс төсөл хэрэгжилтийн хугацааны туршид нягт хамтран ажилласан. Тэрээр төслийн үр дүн-1-ээс үр дүн-4 –ийн тодорхой техникийн ур чадавхийн чиглэлийн үйл ажиллагаанд оролцож байгаагүй хэдий ч байгаль орчны хяналт, удирдлагын менежментийн сургалтанд оролцож, зуухны бүртгэл, хяналтын тогтолцоог бүрдүүлэх тал дээр дэмжин ажилласан юм. Мөн ХЗХ-ны хуралдаанд биечлэн оролцож, оролцох боломжгүй тохиолдолд төлөөлөн хүн явуулах зэргээр хариуцлагатай хандаж байсан.

2012 оны 6 сард зуухны бүртгэл, хяналтын тогтолцоог нэвтрүүлэхтэй холбогдуулсан хэлэлцүүлэгийн үеэр эрчим хүчний хяналтын газрыг шинээр байгуулах нь зүйтэй гэсэн саналыг тавьж, мөн 2012 оны 12 сард зохион байгуулагдсан ХЗХ-ны хуралдаан дээр агаарын бохирдлыг бууруулах арга хэмжээний саналын хэлэлцүүлгийн явцад УБ хотын эрчим хүчний хангамжийн төлөвлөгөөний талаар тайлбарлаж танилцуулах зэргээр Хотын хөгжлийн бодлогын хэлтэсийн хувьд холбогдох арга хэмжээний хяналт удирдлагын менежментийг хэрхэн явуулах талаар судлан ажиллаж байгааг ойлгуулж мэдээлэл хийсэн.

Цаашид агаарын бохирдлын эсрэг авах арга хэмжээг бодитоор хэрэгжүүлэхэд туйлын чухал үүрэг гүйцэтгэх болно гэж найдаж байна.

### **2.6.5.4 Инженерийн байгууламжийн хэлтэс (ИБХ)**

ИБХ-ийн дарга Алтангэрэл болон мэргэжилтэн Ган-Очир нар төслийн үйл ажиллагаанд идэвхтэй оролцсон бөгөөд зуухны бүртгэл, хяналтын тогтолцоог нэвтрүүлэхэд НМХГ-тай хамтран тогтолцоог бүрдүүлэх тал дээр асар их хэмжээний туслалцаа дэмжлэг үзүүлсэн болно.

Тус хэлтэс нь Эрчим хүчний зохицуулах хорооны гишүүн гэдэг байр сууринаас эрчим хүчний хуульд заагдсаны дагуу 1.5 МВт –аас дээших хүчин чадал бүхий зуухыг ажиллуулах зөвшөөрлийг олгож байсан бөгөөд зуухны бүртгэл, хяналтын тогтолцоог нэвтрүүлэх шаардлага, ач холбогдлыг сайтар ойлгож, төслийн үйл ажиллагаа хэрэгжин урагшлах тусам агаарын бохирдлыг бууруулах арга хэмжээний санаа зорилгыг сайн ойлгож, арга хэмжээний саналын талаарх хэлэлцүүлэгт санал бодлоо илэрхийлэх зэргээр хамтран ажилласан. Энэ утгаараа өнөөг хүртэл хариуцан ажиллаж байсан дулаан хангамж зэрэг ашиглалтын төхөөрөмж, байгууламжийг хянах ажилтай агаарын бохирдлыг бууруулах арга хэмжээний уялдаа холбооны талаарх ойлголт нь гүнзгийрсэн гэж үзэж байна.

### **2.6.5.5 Нийслэлийн Мэргэжлийн хяналтын газар (НМХГ)**

НМХГ-ын хувьд Нямдорж даргаас эхлээд олон тооны ажилтан төслийн үйл ажиллагаанд идэвхтэй оролцож, төслийн хүрээнд зохион байгуулагдсан байгаль орчны хяналт, удирдлагын менежментийн сургалтанд тухай бүрт нь хамрагдаж байсан. Ялангуяа зуухны бүртгэл хяналтын тогтолцоог нэвтрүүлэхтэй холбогдуулан хийсэн янз бүрийн хэлэлцүүлэгт оролцож, тогтолцоог бүрдүүлэхэд хувь нэмэр оруулсан юм.

Нөгөө талаар зуухны бүртгэл, хяналтын тогтолцооны хүрээнд төлөвлөгдөж буй утааны хийн ялгарлыг журамлах ажил нь одоохондоо бодит хэрэгжүүлэх шатанд ороогүй байгаа зэргээс тус



байгууллага нь төслийн тодорхой үйл ажиллагаанд хамаарах боломж хязгаарлагдмал байдалтай байгаа юм. Гэвч цаашид журам хяналтыг чангалан мөрдүүлэх ажилд нэлээд чухал үүрэгтэй оролцох байгууллага юм.

#### **2.6.5.6 Эрчим хүчний яам (Хуучнаар Эрдэс баялаг, Эрчим хүчний яам)**

ЭХЯ-ны хувьд Түлшний хэлтэсийн дарга Болдхүү болон тус хэлтэсийн мэргэжилтэн Даваасүрэн нар төслийн үйл ажиллагаатай холбоотой байдаг бөгөөд төслийн хүрээнд японд зохион байгуулагдсан байгаль орчны хяналт, удирдлагын менежментийн сургалтанд эхний жил Даваасүрэн, 3 дах жил Болдхүү дарга тус тус оролцсон .

2011 оны 12 сард зохион байгуулагдсан ХЗХ-ны 4-р хуралдаан дээр төслийн хүрээнд УХЗ болон ДЦС-ын утааны хийн хэмжилтийн дүнгийн талаар танилцуулга хийхэд Болдхүү дарга төслийн үйл ажиллагаа болон хийгдсэн утааны хийн хэмжилтийн дүнг сонин хэвлэлээр нийтэд мэдээллэх нь зүйтэй гэсэн саналыг дэвшүүлж байсан нь утааны хийн хэмжилтийн өгөгдлийн ач холбогдлыг сайтар ойлгодог болохыг харуулсан юм. Мөн 2011 онд боловсруулагдсан шинээр баригдах ДЦС-ын хувьд агаар бохирдуулах бодисын ялгарлын хэм хэмжээг зайлшгүй тогтоож, туйлын чанга ялгарлын стандартыг мөрдүүлэхээр болсон байгаа.

#### **2.6.5.7 Байгаль орчин, Ногоон хөгжлийн яам (Хуучнаар Байгаль орчин, Аялал жуулчлалын яам)**

Агаарын бохирдлын асуудлыг хариуцсан мэргэжилтэн Мөнхбат нь чухал семинар, уулзалт хуралдаанд оролцож, санал бодлоо илэрхийлдэг байсан. Тус яамнаас төслийн хүрээнд японд зохион байгуулагдсан байгаль орчны хяналт, удирдлагын менежментийн сургалтанд эхний жил Саран, 2 дах жил Мөнхбат, 3 дах жил Цээпил гэсэн хүмүүс оролцсон. Сарангийн хувьд зуухны бүртгэл, хяналтын тогтолцоог бүрдүүлэхтэй холбогдуулан хууль эрх зүйн үндэслэл нь болох Агаарын тухай хуультай холбогдох байдлыг магадлах талаар санал дэвшүүлсэн нь цаашид тус тогтолцоог нэвтрүүлэхэд ихээхэн түлхэц, хувь нэмэр болсон юм. Мөнхбатын хувьд Агаарын төлбөрийн тухай хуулинд үндэслэн төлбөр оногдуулах, төлүүлэх ажилд тус тогтолцооны өгөгдлийг ашиглаж болох судалж байсан гэх мэт, төслийн агуулга, үйл ажиллагааг сайтар ойлгож хамтран ажиллаж байсан боловч харамсалтай нь төсөл дуусахаас өмнө ажил нь солигдож, дараагийн хариуцсан мэргэжилтэн Цээпил нь японд сургалтанд хамрагдсан юм.

Байгаль орчин, Ногоон хөгжлийн яамны хувьд цаашид агаарын бохирдлыг бууруулах арга хэмжээний саналыг танилцуулах, хэрэгжүүлэх шатанд хамтран ажиллах болно гэж найдаж байгаа.

#### **2.6.5.8 Халаалтын зуух ашиглалт зохицуулалтын газар (ХЗАЗГ)**

ХЗАЗГ-ын дарга Ган-Очир нь зуухны бүртгэл, хяналтын тогтолцоог бий болгож, нэвтрүүлэх ажлыг дэмжиж, хамтран ажилласан бөгөөд төслийн 2 дах жилд японд зохион байгуулагдсан байгаль орчны хяналт, удирдлагын менежментийн сургалтанд оролцсон. 2012 оны 6 сарын сонгуулийн дүнд төрийн эрх баригч нам солигдсоноор тус газрын дарга өөрчлөгдөж, одоо тус газрын даргаар ажиллаж буй Занданпүрэв томилогдсон юм. Занданпүрэв даргын хувьд ч төсөлтэй идэвхтэй хамтран ажиллах эрмэлзлэлтэй байгаа бөгөөд гэр хорооллын зуухыг төвлөрсөн УХЗ-тай болгох арга хэмжээний саналын талаар зөвшилцөн ярилцсан юм.

### **2.6.5.9 Барилга, хот төлөвлөлтийн яам (Хуучнаар Зам тээвэр, барилга, хот байгуулалтын яам)**

Төслийн эхний жил японд зохион байгуулагдсан Байгаль орчны хяналт, удирдлагын менежментийн сургалтанд Барилга хот төлөвлөлтийн яамнаас мэргэжилтэн Болормаа оролцсон бөгөөд төслийн явцад агаарын бохирдлыг бууруулах арга хэмжээний талаарх хэлэлцүүлэгийн ихэнх нь тус яамтай шууд хамааралгүй асуудал байсан тул аажмаар төсөлтэй холбогдох холбоо нь аажмаар багассан юм.

Тус яамны хувьд агаарын бохирдлыг бууруулах тодорхой арга хэмжээг шийдвэрлэж тогтсон үед эсвэл хот төлөвлөлтийн урт хугацааны төлөвлөгөөтэй уялдуулан агаарын бохирдлын эсрэг авах арга хэмжээг судалж үзэх тохиолдолд чухал үүрэг гүйцэтгэх болно гэж бодож байна.

## **2.7 Төслийн хэрэгжилт, зохион байгуулалтын идэвх санаачлага, сургамж**

### **2.7.1 Төслийн хэрэгжилт, зохион байгуулалтын идэвх санаачлага**

#### **2.7.1.1 Урьдчилсан судалгаа болон түүнд тулгуурласан төлөвлөгөө**

Тус төслийн хүрээнд хэд хэдэн удаа урьдчилсан судалгааны ажлыг зохион байгуулсан бөгөөд төслийг хэрэгжүүлэх явцад тулгарах асуудлыг сонгож, тэдгээр асуудлыг шийдвэрлэхэд чиглэсэн төлөвлөгөөг боловсруулсан.

Хамгийн гол бөгөөд онцлог зүйл нь Х/Т-АХ-ийг байгуулсан явдал юм. НАЧА-ыг хамтрагч талын байгууллагаар сонгож төслийг боловсруулсан боловч бодит байдал дээр агаарын бохирдлын хяналт, удирдлагын үйл ажиллагаа, гүйцэтгэх ажлын эрх үүрэг нь олон тооны байгууллагад хуваагдсан байдалтай байгааг мэдсэнээр НАЧА-ны үүрэг, эрх мэдлээс хэтэрсэн тохиолдолд түүнийг нөхөж дэмжих байх зорилгоор салбарын бусад холбогдох байгууллагаас Х/Т-АХ –ийг бүрдүүлсэн юм. Мөн төслийн ерөнхий даргаар хотын үйлдвэрлэл, экологийн асуудал хариуцсан орлогч даргыг, төслийн менежерээр НАЧА-ны даргыг ажиллуулахаар хүсэлт гаргасан юм.

Х/Т-АХ-ийн гишүүдийг бүрэлдэхүүнд ЗАА-ны Инженерийн байгууламжийн хэлтэс, Мэргэжлийн хяналтын газар, Хотын бодлого төлөвлөлтийн газар, Халаалтын зуух ашиглалт зохицуулалтын газар зэрэг байгууллагаас, мөн Байгаль орчин, Ногоон хөгжлийн яам, Эрчим хүчний яам гэсэн төрийн дээд байгууллагаас оролцуулсан.

Мөн хэд хэдэн удаагийн урьдчилсан судалгааны үер хийгдсэн 2 дах удаагийн нарийвчилсан төлөвлөгөө боловсруулах судалгаанд төслийн хувьд чухал байр суурийг эзэлж буй 3-н ДЦС болон УБ хотын хэмжээний бүх УХЗ-аар явж биечилсэн судалгаа хийсэний зэрэгцээ 14 газрын УХЗ-нд утааны хийн хэмжилтийг хийсэн.

Биечилсэн судалгаа болон утааны хийн хэмжилт нь өвлийн улиралд хийгдээгүй хэдий ч утааны хийн хэмжилт хийснээр УХЗ-ны бодит байдлыг мэдэж чадсан юм.

Утааны хийн хэмжилтийг эхний үед УБ-ын хүнд нөхцөл байдлын дотор анх удаа утааны хийн хэмжилт хийж байгаа ажилтануудтай хамтран хийхэд бэрхшээлтэй, аюултай зүйлүүд байсан бөгөөд төсөл эхэлсэний дараа 2010 оны зун 1 сарын хугацаатай утааны хийн хэмжилтийн сургалтыг японд зохион байгуулсан. Мөн төслийн хүрээнд нийлүүлэгдэх багаж төхөөрөмж монголд ирэхээс өмнө намар хавьцаа ДЦС IV дээр утааны хийн хэмжилтийн дадлагыг явуулах зэргээр нарийн төлөвлөгөөний дагуу шахуу ажиллаж чадсан.

Ийнхүү сургалтын төлөвлөгөөг сайтар боловсруулж чадсаны дүнд УБ хотын өвлийн туйлын хүнд хэцүү нөхцөл байдалд ч техникийн ур чадавхи эзэмшүүлэх үйл ажиллагааг сэтгэлдээ хүрэхээр амжилттай хэрэгжүүлж чадсан юм.

Эцэст нь төслийг 1-2 жил гэсэн урт хугацааны туршид тасралтгүй хэрэгжүүлж чадсанд тус төслийн санааг гаргаж боловсруулсан ЖАЙКА-ын зөвлөх мэргэжилтэн Яамада гуайн зүтгэл чармайлт их байсныг онцлон тэмдэглэмээр байна.

### **2.7.1.2 Улирлын чанартай нөхцөл байдал**

Тус төсөл нь УБ хотын өвлийн улирлын агаарын бохирдолд чиглэсэн бөгөөд 10 сараас дараа оны 3 сар хүртэлх хугацааг өвлийн улирал гэж үздэг тул энэ нь бүтэн жилийн бараг хагас жилтэй тэнцэх хугацаа болох юм. Утааны хийн хэмжилт, агаарын бохирдлыг бууруулах арга хэмжээний судалгаа, зуухны судалгаа зэрэг үйл ажиллагааг голчлон өвлийн улиралд л хэрэгжүүлэх боломжтой юм.

Тухайлбал, утааны хийн хэмжилтийн хувьд эхний жилийн зун утааны хийн хэмжилтийн сургалтыг японд зохион байгуулж, тэр жилийнхээ намар нь ДЦС IV дээр тус байгууллагын багаж төхөөрөмжийг ашиглан хэмжилтийн дадлагыг явуулсанаар тэр өвөлдөө зуухны байгууламж дээр бодит хэмжилтийн ажлыг хийхээр зорьсон юм.

Мөн монголын зуны томоохон баяр болох наадмын дараах 7, 8 сард ихэнх монгол хүмүүс ажлын амралтаа авдаг тул 2 дах жилийн төгсгөлийг 6 сард болгож өөрчилсөн.

Нөгөө талаар өвлийн улиралд төслийн үйл ажиллагаа хэтэрхий их төвлөрвөл Х/Т-ын хувьд ажиллах нөхцөл боломж бэрхшээлтэй болох талтай учраас үйлдвэр дээр хийгдэх ЭХДХ-ийн оношлогоо, эх үүсвэрийн инвентор боловсруулалт, тархалтын загварчлалт гаргах зэрэг үйл ажиллагааг өвлөөс бусад улиралд зохион байгуулж хэрэгжүүлсэн.

Мөн төсөл хэрэгжил хугацаанд НАЧА болон бусад нийслэлийн байгууллагын ажил эхлэх цаг 9 цагаас 8 цаг болж өөрчлөгдсөн учраас төслийн мэргэжилтэн бид бүхэн мөн ажиллах цагаа тааруулж өөрчилсөн бөгөөд өглөө бүр хамтран ажиллаж буй монгол мэргэжилтэнүүдтэй уулзах боломж олдож байсан нь бидний хувьд дотно, сайхан орчинг бүрдүүлж байсан юм.

### **2.7.1.3 Төслийн ажлын өрөө**

Ажиллах өрөө тасалгааны хувьд төслийн багын санаачлагаар бус НАЧА болон монгол талын бололцооны хүрээнд НАЧА-ны өрөөнд 3-4 суудлыг төслийн мэргэжилтэнд гарган өгч, мөн тусд нь Хан-Уул дүүргийн Гутал оффисийн байранд 40 м<sup>2</sup>-ын хэмжээтэй ажлын өрөөг бэлдэж өгсөн нь төслийн үйл ажиллагааг хэрэгжүүлэх, зохион байгуулахад туйлын тохиромжтой тустай байсан. Гутал оффисийн ажлын өрөөг мэргэжилтэн бид бүхэн “шинэ оффис” гэж дуудаж нэрлэдэг.

Төслийн удирдагч болон зуухны бүртгэл, хяналтын тогтолцоо, эх үүсвэрийн инвентор, тархалтын загварчлалыг хариуцсан мэргэжилтэн ихэвчлэн НАЧА-ны өрөөнд ажилладаг бөгөөд энэ нь албаны дарга, дэд дарга болон бусад хамтрагч талын мэргэжилтэнтэй шаардлага гарсан үед уулзаж ярилцаж болох, мөн өдөр бүр хэрэг болгож уулзалт цуглаан хийхгүй байсан ч хамтрагч талын мэргэжилтнүүдийн байдлыг мэдэж ойлгож боломжтой байсан нь туйлын сайн хэрэг болсон юм.

Хамтрагч талын мэргэжилтнүүд нь өөрсдийн хариуцсан өдөр тутмын үүрэгт ажлаа хийхийн хажуугаар төслийн үйл ажиллагаанд оролцож ажиллаж байсан болохоор тэдний ажлын байдлыг ерөнхийд нь мэдэж ойлгож байх нь төслийн мэргэжилтэн бидний хувьд ч үйл ажиллагаагаа төлөвлөж явуулахад туйлын нэмэр тустай байсан.

Нөгөө талаар утааны хийн хэмжилт, агаарын бохирдлыг бууруулах арга хэмжээ, ЭХДХ-ийн оношлогоо гэсэн тодорхой салбар, чиглэлийн ажлыг хариуцсан мэргэжилтэн нь багаж хэрэгслийг ажиллуулах бэлтгэл ажлыг хийх зэрэг үед Гутал оффис дах төслийн ажлын өрөөг голлон ашиглаж байсан. Мөн уусмалын аргаар анализ шинжилгээ хийх зэрэгт БОХЗТЛ-ийн лабораторийн өрөөг

ашиглаж байсан. Төслийн үйл ажиллагаанд хийгдэхээр заагдсан байсан 50 удаагийн утааны хийн хэмжилтийг 200 гаруй удаа болгож хийж чадсан зэрэг нь дээр өгүүлсэнчлэн бидний ажиллах нөхцөл байдал тохиромжтой байсаны ач тус бөгөөд бид бүхэнд ийнхүү тухтай, үр дүнтэй ажиллах боломжийг бүрдүүлж өгсөнд холбогдох байгууллага, мэргэжилтэн та бүхэнд талархаж байгаагаа илэрхийлье.

## **2.7.2 Төслийн сургамж**

### **2.7.2.1 Япон мэргэжилтэнг урт хугацаагаар байлгах шаардлага**

Төслийн явцын үнэлгээгээр төслийн зохион байгуулалт менежментийн үүднээс төслийн удирдагч эсвэл голлох үүрэг бүхий япон мэргэжилтэнг байгаа монголд байлгаж ажиллуулах нь илүү үр дүнтэй гэсэн санал гарсан тул түүнээс хойш төслийн удирдагч нь монгол ажиллах томилолтын хугацааг 2 дахин нэмэгдүүлэн ажиллаж байна.

Тухайлбал, чухал хандивлагч байгууллагын хурал зохион байгуулагдах талаар гэнэт цаг нь тулсан үед мэдээлэл ирэхэд төслөөс оролцож чадахгүй тохиолдол гарч байсан бөгөөд иймэрхүү үед УБ хотод байнга ажилладаг төслийн мэргэжилтэн байвал зохих байдлаар оролцож ажиллах боломжтой байх юм.

Мөн өөр нэг асуудал нь ЖАЙКА-ын техникийн хамтын ажиллагааны төслийн мэргэжилтэн зөвлөх нь ерөнхийдөө хувийн хэвшлийн байгууллага байдаг учраас хандивлагчдийн уулзалт, хуралдаан болох үед ихэвчлэн хандивлагч байгууллагын ажилтан, мэргэжилтнүүд оролцож цаашдын ажлын хэлэлцүүлэг, санал солилцох явагдах тохиолдолд тус төслийн зөвлөх мэргэжилтний хувьд ЖАЙКА-тай хийсэн гэрээнд заагдсаны дагуу хамаагүй үг хэлж амлалт өгөх, үйл ажиллагааны талаар шийдвэр дүгнэлт гаргах зэргээр хэлэлцүүлэгт дур мэдэн оролцох эрхгүй байдаг.

Монголд ЖАЙКА –ын төлөөлөгчийн газар байдаг бөгөөд тус төслийг хариуцсан ажилтан нь давхар бусад олон төслийг нэгтгэн хариуцдаг тул мэргэжилтэнтэй нэгэн адил гэнэтийн цаг хугацааны хувьд давчуу ажил хэргийн хувьд тэдгээрт оролцох зэргээр хангалттай хамааран ажиллаж чадахгүй байх тохиолдол гардаг.

Боломжтой бол хувийн зөвлөгчөөр тэргүүлүүлсэн мэргэжилтний багтай зэрэгцэх хэлбэрээр японы улсын болон хотын захиргааны байгаль орчны асуудал хариуцсан ажилтан зэргийг урт хугацааны томилолтоор монголд байлгавал зохион байгуулалтын хувьд туйлын зөв зохистой болно гэж үзэж байна.

### **2.7.2.2 Онцлог бүхий гадаад хэлний орчуулагчийн асуудал**

Тус төсөлд нийт 14 япон мэргэжилтэн ажилласан бөгөөд мэргэжилтнүүдийн монголд ажиллах хугацаанд монгол хэлний 3 орчуулагч ажилласан. Ихэнх Х/Т болон Х/Т-АХ-тай ажиллах үед англи хэлээр шууд харилцах боломж тун хязгаарлагдмал байсан тул орчуулагчийн тооноос хамааран төслийн үйл ажиллагаа шахагдах, хязгаарлагдах тохиолдол ч гарч байсан.

Гэвч орчуулагчийн тоог нэмэгдүүлэхийг хүссэн ч агаарын бохирдлын эсрэг авах арга хэмжээ, утааны хийн хэмжилт, эх үүсвэрийн инвентор, тархалтын загварчлал гэсэн салбарын шинэ ойлголт, ухагдахуун нь монгол хэлний мэргэжлийн үг хэллэгийн салбарт хараахан орчуулагдаж хэвшээгүй, энэ талын мэргэжлийн орчуулга хийх гадаад хэлний чадавхи бүхий орчуулагч тэр болгон олдохгүй ховор байсан.

Тус төслийн хувьд Б. Батсүх, А. Хишигжаргал, Г. Баасанхүү гэсэн япон хэлний өндөр чадавхитай 3 орчуулагчтай хамтран ажилласанаар төслийн үйл ажиллагааг амжилттай хэрэгжүүлж чадсан гэж үзэж байна. Орчуулагч Б. Батсүх нь нарийвчилсан төлөвлөгөө боловсруулах судалгааны ажлын үеэс төсөлд ажиллаж эхэлсэн бөгөөд монгол талын холбогдох байгууллагын мэргэжилтэнтэй зөв харилцаа тогтоож, хамтран ажиллахад ихээхэн үүрэг гүйцэтгэсэн юм. Орчуулагч А. Хишигжаргалын хувьд голчлон

утааны хийн хэмжилтийн үйл ажиллагааг хариуцан орчуулагчаар ажиллаж, зуухны байгууламж зэрэг ажлын талбарт байнга хамт явж бодит хэмжилтийн ажилд гар бие оролцон ажилласан. Тухайн ажлын талбарт утааны хийн хэмжилтийн ажлыг хийхэд холбогдох үндсэн зарчмыг тодорхой хэмжээгээр ойлгож мэдсэн байх шаардлага тавигддаг бөгөөд Хишгээ орчуулагч нь энэ шаардлагыг хангалттай биелүүлж, япон мэргэжилтний ажилд ихээхэн тус нэмэр болж чадсан юм. Орчуулагч Г. Баасанхүү нь японд их сургуульд суралцаж байсан бөгөөд төслийн үйл ажиллагааны хүрээнд япон монгол хэлний бичгийн болон ярианы орчуулгын ажлыг хийсэнээр бидний ажилд зохих хувь нэмэр оруулсан юм.

Богино хугацааны гэрээтэйгээр төсөл хэрэгжсэн 3 жилийн хугацаанд дээрх 3-н чадварлаг орчуулагчийн туслалцаатайгаар ажиллаж чадсан нь бидний хувьд туйлын аз завшаантай хэрэг болсон гэж бодож байна. Нөгөө талаар эдгээр орчуулагч нарын хувьд төсөлд ажилласан хугацаандаа энэ салбарын мэргэжлийн үг хэллэгийг сурч мэдсэний зэрэгцээ УБ хотын агаарын бохирдлын эсрэг авах арга хэмжээний талаар тодорхой ойлголт, мэдлэгтэй болж чадсан гэж хэлж болох юм.

Өвөрмөц онцлог бүхий хэлтэй гадаад орны хувьд гадаад хэлний чадварлаг орчуулагчийг бэлтгэх, энэ талын боловсон хүчнээр хангах явдал нь аливаа төсөл хэрэгжүүлэхэд тавигдах туйлын чухал нөхцөл шаардлагын нэг болдог гэж бодож байна.

## 2.8 Цаашдын чиг хандлага

Төслийн зорилго болон гарах үр дүнгийн хувьд ялангуяа ойрын ирээдүйтэй холбогдуулан бодож боловсруулсан болно.

Утааны хийн хэмжилтийн техникийн ур чадавхи эзэмшүүлсэн байдлыг мэргэжлийн талаас нь авч үзвэл нэлээн амжилттай хэрэгжсэн гэж дүгнэж болох юм. Тэсгим хүйтэн УБ хотын нөхцөл байдлаас харахад ийм хэмжээний хэмжилтийн өгөгдөлтэй болж чадсан нь монгол талын холбогдох олон тооны мэргэжилтэн, ажилтан нь утааны хийн хэмжилтийг хийж чадахуйц болсон явдал нь том амжилт, үр дүн гэж үзсэн. Гэвч эцсийн үнэлгээний үеэр төлөвлөж байсан утааны хийн хяналт-шинжилгээг хийж чадаагүйн улмаас үнэлгээ буурсан бөгөөд энэ нь монгол талын байгууллагын бүтэц, зохион байгуулалт, тогтолцооны асуудлаас шалтгаалсан болно.

Төсөл хэрэгжилтийн эцсийн шатанд хэрэгжсэн үйл ажиллагаа нь УХЗ-ны циклон тоос баригчын АҮК-ийг хэмжиж, мөн гэрийн зууханд сайжруулсан түлшний туршилт, хэмжилтийг хийж тэдгээрийн үр дүнг судалж үзсэн нь цаашид НАЧА-ны гүйцэтгэх ажил үүргийн чиглэлийг тодорхойлж өгсөн гэж хэлж болох юм. НАЧА нь утааны хийн хэмжилтийн техникийн ур чадавхидаа тулгуурлан АБ-ын эсрэг авах арга хэмжээний үр дүнг тухайн арга хэмжээг хэрэгжүүлэхээс өмнө болон дараа нь үнэлгээ өгөх нь зүйтэй. ЖАЙКА-ын техникийн ур чадавхи эзэмшүүлэх үйл ажиллагааны нэг онцлог нь тухайн, байгууламж, эх үүсвэр дээр утааны хийн хэмжилтийн багаж хэрэгслийг авч очин, бодит хэмжилтийг хийснээр холбогдох ур чадавхи, дадлагыг эзэмшүүлэх явдал байдаг. Тухайлбал, сайжруулсан зуухны хувьд лабороторийн туршилтаар тогтоогдож магадлагдсан бүтээмж, чадавхи нь гэрт бодит нөхцөл байдал дээр үнэхээр батлагдаж байгаа эсэхийг магадлаж шалгах шаардлагатай гэж үздэг.

Мөн төсөл хэрэгжилтийн хугацаанд хэмжилтийн хувьд үр дүнтэй хялбаршуулсан аргыг олж чадаагүй нь цаашид хийх шаардлагатай асуудал болон үлдэж байна. Нөгөө талаар Дэлхийн банк, МСС зэрэг бусад хандивлагч байгууллага нь ЖАЙКА-аас өөр багаж төхөөрөмж, хэмжилтийн аргыг ашиглан гэрийн зуухны утааны хийн хэмжилт хийж байгаа тул эдгээр хэмжилтийн аргыг хооронд нь харьцуулах шаардлагатай байгаа юм. Дээрх байдлаас утааны хийн хэмжилтийн ур чадавхийн хувьд түүний үр ашигтай хэрэглээ болон, холбогдох чадавхийг улам сайжруулж, хөгжүүлэхэд тал дээр анхаарч, байнга дэмжлэг үзүүлж ажиллах нь зүйтэй юм.

Эх үүсвэрийн инвентор боловсруулалт, тархалтын загварчлалын хувьд монгол талын мэргэжилтнүүд нь инвентор шинэчлэх арга, боловсруулалтын дараалал зэрэг гол агуулга, зарчмыг сурч эзэмшсэн түвшинд байгаа бөгөөд тэдгээрийг АБ-ын хяналт, удирдлагын менежментэд ашиглах тал дээр туршлагагүй байгаа.

Хамгийн чухал зүйл нь эх үүсвэрийн инвенторын баримжаалсан тооцоолол, тархалтын загварчлалаар урьдчилсан таамаглал буюу прогноз гаргахад шаардагдах өгөгдөл, мэдээллийн нөхцөл байдал, таамаглалын дүнгийн илгэлцүүрийн түвшин, мөн хамрах хүрээ зэргийг сайтар ойлгох явдал юм. Одоогийн төслийн хүрээнд хийгдсэн тархалтын загварчлалын үр дүнгийн хувьд ч эргэлзээтэй, итгэлцүүрийн түвшин багатай зүйлүүд орсон байгаа талаар тус тайланд дурьдсан байгаа билээ.

Тархалтын загварчлалын моделийн прогноз дүнгийн итгэлцүүрийн түвшин өндөр байх нь эх үүсвэрийн инвенторын нарийвчлалаас хамаардаг тул тодорхой бүс нутагт урт хугацааг хамарсан эх үүсвэрийн инвенторын шинэчлэлийг агаар орчны агууламжтай харьцуулсаны үндсэн дээр тархалтын загварчлалын дүнд үнэлгээ хийх гэсэн дэс дараалалтай ажлуудыг хийснээр эх үүсвэрийн инвенторын баримжаалсан тооцоолол болон тархалтын загварчлалын моделийг бүхэлд нь сайжруулж чадах юм.

Тархалтын загварчлал нь эх үүсвэр-агаар орчны агууламжийн холбоонд дүн шинжилгээ хийх боломжийг бүрдүүлж өгөх туйлын ач холбогдол бүхий хэрэглүүр тул цаашид улам сайжруулж, төрийн бодлого төлөвлөлтөнд ашиглах зэрэг ажлыг эрчимжүүлэх нь зүйтэй юм. Гэхдээ үүнд нэг анхаарах ёстой зүйл нь тархалтын загварчлалын дүнг тэр хэвээр нь юм болгонд ашиглах, эсвэл гарсан дүнд хэтрүүлэн дүн шинжилгээ хийх, тэдгээр тоон үзүүлэлт, утгыг эцсийн дүгнэлт гэсэн байдлаар авч хэрэглэхгүй байх явдал юм.

Ашигтай хэрэглүүрийг АБ-ын хяналт, удирдлагын менежментэд зөв ашиглахын тулд НАЧА, ЦУОШГ болон УАЧМА гэсэн мэргэжлийн байгууллагуудын хүрээнд энэ талын мэдлэг, ойлголтыг хангалттай өгч, шийдвэр гаргах түвшиний албан тушаалтан болон нийт иргэдэд зөв танилцуулж ойлгуулах шаардлагатай юм.

